

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2026 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-58

1.Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал	7-8
2.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2026.03.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	8-50
3.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нарын 8 гишүүн 2025.07.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	50-51
4.Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан	51-58

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
4 дүгээр сарын 07-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 56.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 28 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, Ц.Туваан, Ө.Шижир;
Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Л.Ганбаатар, Т.Доржханд, Ч.Номин,
Н.Номтойбаяр, Н.Учрал, О.Цогтгэрэл;
Эмнэлгийн чөлөөтэй: Л.Мөнхбаатар.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ганбаатар хэлэлцэх асуудлын дарааллын тавдугаар асуудал болох Байнгын хорооны тогтоолын төсөл /Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, Сонсгол даргалагчийг сонгох тухай/ болон зургаадугаар асуудал болох Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/-ийг хэлэлцэхийг хойшлуулах санал гаргаж, хуралдаан даргалагч Ж.Батжаргал уг асуудлуудыг хойшлуулав./15:33/

Нэг.Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны зөвлөх Ч.Батбямба, Ц.Баянмөнх, Ц.Болормаа, референт Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Ж.Батжаргал: Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 31 гишүүнээс 2026 оны 3 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 7

Бүгд: 21
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 13 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2026.03.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга А.Үйлстөгөлдөр, мөн газрын Хуулийн бодлогын газрын дарга Ж.Мөнхболд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх Т.Энхтүвшин, Хууль зүйн ухааны доктор А.Бямбажав, О.Машбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны зөвлөх Ч.Батбямба, Ц.Баянмөнх, Ц.Болормаа, референт Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга А.Үйлстөгөлдөр танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Э.Болормаа, Б.Баярбаатар, Ц.Даваасүрэн, Б.Хэрлэн, А.Ганбаатар, Ц.Сандаг-Очир, Б.Батбаатар, Э.Одбаяр, Л.Оюун-Эрдэнэ, Х.Баасанжаргал, О.Номинчимэг нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга А.Үйлстөгөлдөр, мөн газрын Хуулийн бодлогын газрын дарга Ж.Мөнхболд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх Т.Энхтүвшин, Хууль зүйн ухааны доктор А.Бямбажав нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа, Б.Баярбаатар, Ц.Даваасүрэн, Ц.Сандаг-Очир, Ч.Лодойсамбуу, Л.Оюун-Эрдэнэ, А.Ариунзаяа, С.Зулпхар, Х.Баасанжаргал, Ж.Золжаргал, Ж.Батжаргал нар үг хэлэв.

Ж.Батжаргал: 1.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 7
Бүгд: 21
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 7
Бүгд: 21

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 7

Бүгд: 21

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.“Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 7

Бүгд: 21

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нарын 8 гишүүн 2025.07.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны зөвлөх Ч.Батбямба, Ц.Баянмөнх, Ц.Болормаа, референт Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Ж.Батжаргал: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, У.Отгонбаяр нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “тавин хувь” гэснийг “гучин хувь” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 11

Бүгд: 21

47.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, У.Отгонбаяр нарын гаргасан, “Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

Энэ хуулийг 2026 оны 5 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 10
Бүгд: 21
52.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, мөн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Баяраа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мягмарнаран, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга Ч.Ганболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Ц.Болормаа, референт Б.Баясах, О.Мөнгөнчавхдас, Хяналт шалгалтын газрын ахлах зөвлөх Х.Энэбиш, мөн газрын зөвлөх Ж.Монголжингоо нар байлцав.

Тайланг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга

Б.Энхбаяр, мөн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ч.Бат-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Б.Баярбаатар, Ж.Батжаргал үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцлээ.

Уг асуудлыг 18 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 00 минут үргэлжилж, ирвэл зохих 32 гишүүнээс 21 гишүүн хүрэлцэн ирж, 65.6 хувийн ирцтэйгээр 18 цаг 28 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ц.САНДАГ-ОЧИР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2026 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
15 цаг 28 минут.*

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Батжаргал: Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2026 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг нэрсээр танилцуулъя.

Аюушийн Ариунзаяа, Жадамбын Бат-Эрдэнэ, Батын Батбаатар, Жигжидийн Батжаргал, Баярмагнайн Баярбаатар, Энхбатын Болормаа, Сандагийн Бямбацогт, Амгаланбаатарын Ганбаатар, Цэрэнпилийн Даваасүрэн, Сархадын Зулпхар, Цагаанхүүгийн Идэрбат, Эрдэнэбилэгийн Одбаяр, Бөхчулууны Пүрэвдорж, Цэндийн Сандаг-Очир, Гончигдоржийн Уянгахишиг, Бадарчийн Хэрлэн, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Доржзовдын Энхтуяа нар хүрэлцэн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудлыг та бүгдэд танилцуулъя.

1. Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал.

2. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл. Монгол Улсын Ерөнхийлөгч 2026 оны 3 дугаар сарын 9-ний өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх.

3 дахь асуудал. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нарын 8 гишүүн 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг.

4. Хууль тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан.

5. Байнгын хорооны тогтоолын төсөл /Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/

6. Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/ гэсэн ийм 6 асуудал хэлэлцэхээр орж ирсэн байна.

Ганбаатар ирцэд орсон. Манай Байнгын хорооны гишүүд орж ирээрэй. Шууд санал хураалтаар хуралдаан үргэлжилнэ. Байнгын хорооны ажлын алба ирцэд орсон гишүүдийг дуудаарай.

Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнөөс асуух асуулттай, саналтай гишүүд байна уу?

Ганбаатар гишүүн. Өөр саналтай гишүүд бий юу?

Алга байна. Ганбаатар гишүүний микрофоныг өгөөрэй.

А.Ганбаатар: Өдрийн мэнд хүргэе. Олон нийтийн радио, телевизийн асуудлаар сонсгол хийе гэсэн санаачилга гаргаад тэгээд Төрийн байгуулалтын байнгын хороогоор хэлэлцээд ажлын хэсэг өнөөдөр байгуулагдах юм байна лээ. Тэгээд энэ төслийг нь харахаар даргалагч болон бүрэлдэхүүн гишүүнд нь бас буцаж харахаар юмнууд байна л даа. Тухайн үедээ Энхтуяа гишүүн бид хоёр энэ салбарыг арай илүү бас гадарлах юм гэдэг үүднээс энэ бүрэлдэхүүнд нь ороод сонсголоо даргалъя гэсэн ийм хүсэл, саналтай байсан. Тэгээд арай өөр болоод явчхаж байгаа юм. Тэгээд бусад гишүүдийг чадна, чадахгүй гэдгээр нь биш энэ бүрэлдэхүүний тэнцвэр бас амжилттай, үр дүнтэй болох талаас нь харж үзээд энэ асуудлыг түр хойшлуулбал яасан юм бэ гэсэн ийм саналтай байгаа юм өнөөдрийн хэлэлцэх асуудлаас.

Ж.Батжаргал: /Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох тухай, Сонсгол даргалагчийг сонгох тухай/ Байнгын хорооны тогтоолын төсөл батлах тухай 5, 6 дахь асуудлуудыг санаачлагчид нь өөрөө түр хойшлуулъя гэсэн санал гаргаж байгаа тул хойшлууллаа.

Хэлэлцэх асуудлаа эхний 4 асуудлаараа тогтлоо. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцэх эсэх асуудал.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7-д, энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ гэж заасан. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслөөр нь, бүрээр нь одоо санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлдье. Санал бэлдчихсэн үү? Саналын томъёоллыг танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 31 гишүүнээс 2026 оны 3 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

Санал хураалтын дүнг танилцуулъя. 14 гишүүн дэмжиж, 66.7 хувиар дэмжигдлээ. Дараагийн асуудалдаа оръё.

13.35 цаг

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2026 оны 3 дугаар сарын 9-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийж эхэлье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга А.Үйлстөгөлдөр хийнэ. Үйлстөгөлдөр дарга, ажлын хэсгийг урья.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулж өнөөдрийн хуралдаанд орж ирэх ажлын хэсэг Үйлстөгөлдөр Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Ж.Мөнхболд Хуулийн бодлогын газрын дарга, Т.Энхтүвшин Ерөнхийлөгчийн зөвлөх, А.Бямбажаргал Хууль зүйн ухааны доктор, О.Машбат Хууль зүйн ухааны доктор. Ажлын хэсэг суудлаа эзэлсэн байна. Үйлстөгөлдөр даргыг мэдээллээ хийхийг урьж байна. Ажлын хэсгийн 3 номерын микрофоныг өгөөрэй.

А.Үйлстөгөлдөр: Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын Үндсэн хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслөө санаачилсан билээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах үндэслэл болно. Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна. 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3-д Ерөнхийлөгч Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэх, мөн зүйлийн 4-д Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх асуудлаар Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргахаар зохицуулжээ.

Түүнчлэн Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно. Улсын дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж биелүүлнэ гэж, 67 дугаар зүйлд Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болно гэж тус тус тусгажээ.

Тэгвэл Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн гишүүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох тухай, 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтад Монгол Улсын Үндсэн хуулийн цэц Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4-д зааснаар гишүүнийг эгүүлэн татах үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасныг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн хэмээн заасан нь Үндсэн хуулийн 67 дугаар зүйлийн Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа хүчин

төгөлдөр болно гэсэн заалттай зөрчилдөж энэ шийдвэрийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөх эсэх тухай асуудлыг тавихаар зохицуулсан байна.

Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хуулийг зөрчсөн нь Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар түүнийг эгүүлэн татах үндэслэл болох бөгөөд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт энэ тухай гаргасан Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөн бол түүнийг эгүүлэн татах эсэх асуудлыг Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэнэ гэжээ.

Гэтэл Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хууль зөрчсөн тухай асуудлаар гаргасан Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөх, хэлэлцэн шийдвэрлэх эрхгүй байгаа бөгөөд 67 дугаар зүйлд зааснаар Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болж Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татахаар байна. Мөн зүйлд уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна гэж гэсэн заалтыг шүүхээс хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ хэмээн заасан. Энэхүү Үндсэн хуулийн зарчим ёсоор иргэд төрийн эрх барих дээд байгууллагын үйл ажиллагаа, ард түмний элчийн хувьд Улсын Их Хурлын гишүүний ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, цаашлаад сонгож байгуулсан төлөөлөгчдийн байгууллагын гишүүнийг Үндсэн хууль бусад хууль зөрчсөн тохиолдолд бүрэн эрх, хугацаанаасаа өмнө дуусгавар болох буюу эгүүлэн татах үндэслэлийг тодорхой болгохыг шаардах болсон.

Үүнтэй холбоотой Монгол Улсын Их Хурлын тухай хуульд Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болох буюу эгүүлэн татах үндэслэлийг тодотгох шаардлага тулгамдаж байна.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын үндсэн хуульд байгууллагыг бататган бэхжүүлэх тухай 3.3.1 дүгээр зүйлийн 3.3.1.1-д Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон төрийн байгууллагын болон байгууламжийн хэлбэр, төрийн эрх мэдлийн хуваарилалт, ардчилал, эрх зүйт ёс, үндэсний эв нэгдлийг хангах зарчмыг тууштай хэрэгжүүлнэ гэж заасан нь уул баримт бичгийн 1.1.4-д заасан хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх зарчим, парламентын засаглалд суурилсан нийгмийн тогтвортой байдлыг хангасан ардчилсан төрийн тогтолцоонд үндэсний аюулгүй байдлыг хангах баталгаа мөн гэдэг заалтыг хангах чухал арга зам болно.

Иймээс Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хуулийг зөрчсөн гэж Үндсэн хуулийн цэц дүгнэсэн болон гэмт хэрэг үйлдсэнийг нь шүүх тогтоосон бол эгүүлэн татаж хууль зүйн болон ёс зүйн хариуцлага хүлээлгэх явдал парламентын ардчиллыг бэхжүүлэх, үндэсний аюулгүй байдлыг хангахад тулгамдсан асуудал болсоор байна.

Энэхүү хуулийн төслийн зорилго нь өргөсөн тангаргаасаа няцсан ард түмний элчийн хувьд төлөөлөх, хууль тогтоох чиг үүргийг хэрэгжүүлэхдээ Улсын

Их Хурлын ээлжит чуулганы хуралдааны 30-аас дээш хувьд хүрэлцэн ирээгүй бол санал хураалтад биечлэн оролцоогүй гишүүний ёс зүйн дүрмийг ноцтой болон удаа дараа зөрчсөн Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татаж, хууль зүйн хариуцлагыг тодорхой, ил тод, үр нөлөөтэй болгох замаар Үндсэн хуульт байгууллагыг бататган бэхжүүлэх үндэсний аюулгүй байдлыг хангахад оршиж байгаа юм.

Хуулийн төсөл батлагдсанаар Улсын Их Хурлын гишүүн ардчилсан ёсны зарчмын дагуу ард түмнээс олгосон мандатыг хүндэтгэхийн сацуу Үндсэн хууль зөрчсөн, гэмт хэрэг үйлдсэн, ёс зүйн ноцтой зөрчил гаргасан тохиолдолд эгүүлэн татах тухай Үндсэн хуулийн зохицуулалтыг амьдралд хэрэгжүүлэх, парламентын засаглалыг бэхжүүлэх, улс төрийн намыг хариуцлагатай болгох, төрийн үйл ажиллагааны тэгш байдал, хууль дээдлэх зарчмыг хангахад онцгой ач холбогдолтой юм.

Санаачилсан хуулийн төслийг дагалдах хэлбэрээр Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, мөн хуулийн төсөл батлагдсантай холбоотойгоор “Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулаад байна.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасан журмын дагуу Засгийн газарт хүргүүлж санал авсан бөгөөд Засгийн газрын хуралдааны тэмдэглэлд дурдагдсан асуудлыг хүлээн авч төсөлд тусгасан.

Түүнчлэн уг хуулийн төсөлд Монгол Улсын Ерөнхийлөгчид ямар нэгэн бүрэн эрх олгосон зүйл байхгүй болно.

Хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ж.Батжаргал: Баярлалаа. Хууль санаачлагчийн илтгэл, хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгье. Үг тусдаа, үг тусдаа. Оюун-Эрдэнэ гишүүнээр. Болормаа гишүүнийг нэмье. Болормаа гишүүнийг нэмье. Хэрлэн гишүүн, Хэрлэн гишүүн. Өшөө дараарай. Орчих доо Хэрлэн гишүүн.

Хэрлэн гишүүнээр тасаллаа. Баасанжаргал гишүүнийг оруулаадах. Баасанжаргал гишүүнээр тасаллаа. Ариунзаяа гишүүн асуултаа асууя.

А.Ариунзаяа: Яах вэ дэмжихэд хэцүү, дэмжихгүй байхад бүүр ч хэцүү ийм л хууль байгаад байгаа юм аа. МАН-ын мөрийн хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн даргаар би ажилласан. Тэгээд 24 онд манай намаас мөрийн хөтөлбөрөө боловсруулж гаргахдаа яг энэ сонгодог парламентын засаглал ба эрх мэдлийн хяналт, тэнцэл гэдэг энэ бүлэгтэй 4.3.1 дээр Улсын Их Хурлын гишүүдийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих механизмыг хялбаршуулж, сонгогчдын саналаар эгүүлэн татах эрх зүйн орчныг бүрдүүлнэ ээ гэж тухайн үедээ бас оруулж байсан.

Тэгэхээр ер нь бол Улсын Их Хурлын гишүүд хяналттай, сахилга баттай, хариуцлагатай, бас эгүүлэн татах ийм боломжтой байх ёстой гэсэн ийм зарчим дээр суурилж энэ заалтыг оруулж байсан. Цаг хугацааны хувьд яг энэ хууль одоо өргөн баригдаж байгаа энэ улс төрийн нөхцөл байдал болон яг бичвэрийн хувьд хараад үзэхлээр нэн ялангуяа энэ жагсаалтаар сонгогдсон гишүүд дээр ёс зүйн ноцтой зөрчил гаргасан гэж үзэх намын төлөөллийн төв байгууллага, эсвэл эвслийг төлөөлөх байгууллага дүгнэж гаргах юм байна. Тэгээд үүнийгээ Улсын Их Хуралд уламжилж Улсын Их Хурлын бүлэг болон Улсын Их Хурлаар нээлттэй хэлэлцэнэ ээ гэж оруулсан байна.

Тэгэхээр нэгдүгээрт яагаад зөвхөн энэ жагсаалтын гишүүдийг онцлох болов оо гэдгийг асуумаар байна хууль санаачлагчаас. Ер нь анхны уг нь бол энэ иргэд, сонгогчдын саналаар гэж анхны санаа бол манай мөрийн хөтөлбөрт ийм санаа байсан. Энэ бол яг одоо нөгөө намын үзэл суртлын л агуулгаар болоод явчхаж байгаа байхгүй юу. Тэгээд дээрээс нь тойргоос сонгогдсон гишүүд ёс зүйтэй байх албагүй гэж үзэж байгаа юм уу? Ер нь жагсаалтаар сонгогдсон гишүүдийг яагаад зүгээр л нам нь л сонгосон гэж үзээд иргэдийн, иргэд, сонгогчдын саналыг аваагүй гэж үзээд байгаа юм бол? Тэр чинь улс төрийн намууд бүгдээрээ л намынхаа жагсаалтад орж байгаа хүмүүсийг бүгдийг нь л танилцуулгыг нь гаргаад л манай намыг дэмжээрэй, жагсаалтын тэдэд байгаа хүнийг дэмжье гэвэл намыг нь дугуйлаарай гээд л бид нар чинь сурталчлаад л явдаг шүү дээ.

Би лав даг МАН-ын 12 дээр жагсаж бас баруун бүсэд ажилласан. Тэгээд одоо бас намайг сонгоё оо гэж байгаа бол бас манай намын эдгээр жагсаалтад байгаа хүнийг сонгоё оо гэж байгаа бол саналаа өгөөрэй гэж саналыг нь авч явсан шүү дээ. Тэгээд яагаад ингэж үгүйсгэж явж байгаа юм бол? Тэгээд зөрчлийг нь яагаад зөвхөн энэ жагсаалтын гишүүд дээр тооцно оо гэж оруулж байгаа юм бол? Ер нь энэ ёс зүй гэдгийг бол ноцтой гэж юуг үзэх юм, удаа дараа гэдгийг юу гэж үзэх юм гэдэг нь өөрөө бас их сонирхолтой сонин байгаад байгаа байхгүй юу. Яг өнөөгийн энэ улс төрийн нөхцөл байдал руу буулгаад ирэхлээр ер нь бол залуу гишүүдийн энэ дуу хоолойгоо илэрхийлэх, шүүмжлэлтэй хандах зэрэг энэ ардчилсан үзэл баримтлалыг боомилох ийм л одоо бодлого явж байгаа юм уу.../минут дуусав./

Ж.Батжаргал: Хариулъя. Ажлын хэсгийн 3 номер.

А.Үйлстөгөлдөр: Гишүүний асуултад хариулъя. Гишүүнийг эгүүлэн татах тухай хууль гэнэт одоо ингэж улс төрийн шинжтэй гарч ирж байгаа асуудал бол биш ээ. Энэ бол 1992 оноос хойш Үндсэн хуульдаа байсан асуудал.

Харин энэ асуудал маань өнөөдөртөө бид нар хэрэгжихгүй байгаа, амилахгүй байгаа асуудлаас болж өнөөдөр тулж ирсэн. Ард олон шахан шаардаж байгаа. Монгол Улсын Ерөнхийлөгч бүх ард түмний эв нэгдлийг илэрхийлэгчийн хувьд, мөн бүх ард түмнээс сонгогддог төлөөлөгчийн хувьд ард түмнийхээ дуу хоолойг сонсож, ард түмнийхээ хүсэмжийг биелүүлж энэхүү хуулийн төслийг нэгдүгээрт өргөн барьж байгаа.

Хоёрдугаарт, энэ ямар нэгэн нам улс төрийн зорилгоор хэн нэгнийг хэлмэгдүүлэх асуудал огт биш ээ гэдгийг одоо хариуцлагатайгаар хэлмээр байна.

Энэхүү хуульд бол заасан жагсаалтын асуудлыг Ариунзаяа гишүүн бас онцолж асууж байх шиг байна. Жагсаалтын гишүүдийг сонгохдоо иргэд хэн нэгнийг

дугуйлдаггүй. Иргэд намыг дугуйлдаг. Өөрөөр хэлэх юм бол тойргоос сонгогдсон гишүүнийг дугуйлж сонгогчоод, мөн намд итгэл үзүүлж намыг дугуйлдаг. Намаас жагсаалтын гишүүдийг өөрсдөө сонгож оруулдаг байх.

Тэгвэл хэрвээ жагсаалтын гишүүд дээр ёс зүйн хариуцлага үүсвэл, аливаа асуудал үүсвэл бид энийг хэрхэх вэ, хэн хариуцлага хүлээх юм? Иргэд, сонгогчид намыг дугуйлчхаад байдаг. Энэ хариуцлагаас намыг мулталж болохгүй. Энэ хариуцлагыг нам өөрөө хүлээх ёстой. Улс төрийн намын тухай хуулийн 19.5-д. Улс төрийн намын тухай хуулийг бид өнгөрсөн жил Их Хурлын гишүүд та бүхэн баталсан.

Улс төрийн намын тухай хуульд 19.5 дээр Монгол Улсын Их Хурлын сонгуульд намаас нэр дэвшигчийг сонгохдоо тухайн албан тушаалыг хаших ёс зүйн болон хууль тогтоомж, холбогдох журмаар тогтоосон шаардлагад үндэслэнэ ээ гэхихсэн байгаа.

Тэгэхээр энэ дээр намыг бид оролцуулж нам өөрөө хариуцлага хүлээх ёстой, хариуцлагажих ёстой. Ингээд жагсаалтын гишүүнтэйгээ асуудлаа бас ярих ёстой гэсэн үндэслэлээр бид нар энэ асуудлыг оруулсан юм аа.

Тогтолцооны хувьд гэх юм бол манай холимог тогтолцоог мажоритар тогтолцоотой хамтатган нэг ижил түвшинд ойлгох нь буруу юм. Энэ аль ч орны энэ асуудал дээр байгаа жишээн дээр харж, судалгаан дээр үндэслэж харж болж байна. Тэгээд Улс төрийн намын тухай хуулийн 7.4.2-т Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл болон бодлогын талаарх асуудлыг Улсын Их Хурал дахь намын бүлгээрээ дамжуулан Улсын Их Хуралд оруулна гэж байгаа юм. Ийм учраас энэ хариуцлагын асуудал нам өөрөө хүлээх ёстой. Нэн ялангуяа Улсын Их Хуралд суудалтай нам өөрөө энэ тал дээр хариуцлага хүлээх субъект учраас үүнийг оролцуулах ёстой.

Хэрвээ намыг тусад нь ангид авч үзэх юм бол энэ нөгөө ялгамжтай хандаж байна аа гэдэг асуудал чинь өөрөө энэ дээр орж ирж байгаа юм . Тийм учраас энэ тал дээр ингэж хариулмаар байна.

Ж.Батжаргал: Ариунзаяа гишүүн тодруулъя.

А.Ариунзаяа: Үйлстөгөлдөр дарга бас буруу л ярьж байна. Миний асуулт бол ёс зүйн асуудал зөвхөн жагсаалтын гишүүдэд л хамаатай юм уу, тойргийн гишүүд, тойргоос сонгогдсон гишүүд ёс зүйгүй байж болох юм уу гэдэг ийм асуултыг асуугаад байгаа байхгүй юу. Яагаад зөвхөн жагсаалтын гишүүд удаа дараа ноцтой зөрчил гаргасан болоод л нам нь татах гээд байгаа юм бэ? Тойргоос сонгогдсон хүмүүс иргэдийн саналыг одоо шууд саналаа өгсөн учраас, нэрээр нь саналаа өгсөн учраас ёс зүйгүй байж болно оо гэж байгаа юм уу? Үгүй шүү дээ ёс зүй бол адилхан байх ёстой. Зарим улс орнууд бол намаа сольсон хүмүүс тойргоос гарсан хүн байх юм бол нөхөн сонгууль ч зарладаггүй жагсаалтаасаа дараагийн хүн нь ороод явдаг байхгүй юу ер нь бол. Тэгээд ийм нэг жагсаалтын гишүүдийг л ад үзсэн байдлыг Ерөнхийлөгчөөсөө хүртэл ийм юмыг одоо бас гаргамааргүй байгаа байхгүй юу. Намын жагсаалтад хэнийг орж байгаа вэ гэдгийгээ сурталчилдаг шүү дээ. Бага хурлаараа ч гэсэн бид нар хэнийг оруулах вэ гэдгийгээ дотоод ардчиллаараа сонгодог байхгүй юу. Зүгээр таг харанхуй оруулдаг юм биш.../минут дуусав./

Ж.Батжаргал: Хариулъя. Ажлын хэсгийн 3 номер.

А.Үйлстөгөлдөр: Гишүүний асуултад хариулъя. Ариунзаяа гишүүн хуулиа сайн унших хэрэгтэй байна. Хуулийн төслийг. Энэ хуулийн төслийн 3 дээр яг таны асууж байгаа зүйлийг бол тодорхой тусгасан байгаа. Энэ бол Улсын Их Хурлын гишүүд заавал жагсаалтаар гэлтгүй бүх гишүүнд энэ ёс зүйн асуудал хамааралтай байгаа. Бүгдэд нь хамаарч байгаа шүү гэдгийг танд тодотгож хэлмээр байна. 3 дугаар зүйл дээр байгаа.

Мөн бас энийг хэн нэгний улс төрийн үйл ажиллагаагаар хэн нэгнийг эгүүлэн татах, заавал эсвэл жагсаалтыг ялгаварлан гадуурхах ч гэдэг юм уу ийм зүйл бол энд бол огт байхгүй ээ. Энийг бол хариуцлагатайгаар хэлье ээ. Хуулиа сайн уншаад хуулиа харах юм бол харин нөгөөтээгүүр хэн нэгнийг хэлмэгдүүлэх вэ гэдэг асуудал бол, асуулт бол Их Хурлын гишүүд байгаа байх. Ийм ямар ч боломж байхгүй. Энэ дээр бол хэн нэгнийг хэлмэгдүүлчих вий гээ.../минут дуусав./

Ж.Батжаргал: Ариунзаяа гишүүн тодруулъя.

А.Ариунзаяа: Би харин ч ёстой сайн уншдаг гишүүдийн нэг байгаа шүү. Энэ дээр намайг одоо анхааралтай уншаарай гэдэг нь одоо бас юу л бол доо. 9.1.6 хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар буюу жагсаалтаар нэр дэвшиж сонгогдсон гишүүнийг нэр дэвшүүлсэн намын төлөөллийн төв байгууллага, эсхүл эвслийг төлөөлөх байгууллага ёс зүйн ноцтой зөрчил гаргасан гэж үзэж уг гишүүнийг эгүүлэн татах саналаа Улсын Их Хурлын даргад Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгээр уламжлан өргөн мэдүүлж, уг саналыг Улсын Их Хуралд нээлттэй хэлэлцэн илээр санал хураан гишүүнийг олонх дэмжсэн гэсэн ийм заалтаар эгүүлэн татах ийм заалт онцгойлон хувь тэнцүүлэн буюу жагсаалтаар сонгогдож орж ирж байгаа гишүүд дээр оруулж ирсэн байгаа юм.

Тэгээд яах вэ та бид 2 одоо тийм, үгүй гэж мэтгэлцээд яах вэ. Ямар ч байсан энэ жагсаалтын гишүүдийг онцолж ингэж дурдаж байгаа нь зөвхөн хууль дээр ч биш та болон таны хажууд сууж байгаа эрхэм хэвлэлийн хурлыг хийхдээ хүртэл жагсаалтын гишүүд гэж удаа дараа хэлснийг одоо бат.../минут дуусав./

Ж.Батжаргал: Санал байлаа. Болормаа гишүүн асуултаа асууя.

Э.Болормаа: Би эхлээд асуултыг хурал даргалагчаас нэг асуулт асууя. Энэ Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга яагаад ажлын хэсгээр энэ хуралд орж ирсэн юм бол? Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь хуулийн дагуу үндсэн чиг үүрэг нь бол зөвлөлийн үндсэн чиг үүрэгт хамаарах асуудлаар судалгаа хийх, үнэлэлт, дүгнэлт гаргах, шийдвэрийн үндэслэлийг боловсруулах, биелэлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулж, Зөвлөлийн гишүүд бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслах гэсэн ийм үндсэн чиг үүрэгтэй байна. Өнөөдөр энд бол Үндэсний аюулгүй байдлын хурал болж байна гэж би бодохгүй байна. Тэгэхээр би эхлээд хурал даргалагчаас энийг асууя. Өнөөдөр энэ хуулийг өргөн барьж байгаа Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргаас бас асууя.

Яг энэ хуульд өргөн барьснаар, би яг 3 хүний жишээгээр асууя. Өнгөрсөн 7 хоног Энхтүвшин гишүүн ордон дотор мөргөсөн юм уу, зодолдсон юм уу юм боллоо. Энэ хууль батлагдвал яг энэ үйлдэл дээр ямар арга хэмжээ авах вэ? Энэ хуульд хамаарагдах уу? Нэг хүн шордоод, өдөөд, албаар энийг нэг онилж байгаад

гээд бүүр нэг тийм юм зохион байгуулаад хийвэл хэн нь ёс зүйн алдаа гаргасан болох вэ?

Хоёр дахь жишээ асууя. Улсын Их Хурлын гишүүн Лүндэг жишээлбэл намрын чуулганаар хамгийн бага ирцтэй гишүүдийн нэг. Гишүүний энэ санал хураалтын 30-аас дээш хувьд бол биечлэн оролцоогүй байх. Тийм бол жишээлбэл Лүндэг гишүүн дээр ямар хариуцлага тооцно гэсэн үг вэ?

Гурав дахь нь энэ хууль батлагдсанаар Мөнхтуяа, Нара гишүүн лайв/live/ хийж тэнд бид нар ямар үг хэлэх нь таалагдана уу, таалагдахгүй байна уу ардчилсан Монгол улсад өөрийнхөө үзэл бодлоо илэрхийлэх энэ эрхээ эдэлж байгаа дээр нь тэр ноцтой ёс зүйн зөрчил мөн үү? Энэ 3-н асуудал, энэ 3-н би бодит жишээгээр асууж байгаа шүү. Энэ хуулиар яаж зохицуулагдах вэ?

Ж.Батжаргал: Хууль санаачлагчийн ажлын хэсгийн нэрсэнд Хууль зүйн ухааны доктор Бямбажаргал гэж орж ирсэн. Энэ дагуугаа ажлын хэсэгт байгаа гэдгийг зориуд хэлье ээ. Хариульа ажлын хэсгийн 3 номер.

А.Үйлстөгөлдөр: Бямбажаргал доктор бол Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүдийн үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх үндсэн чиг үүрэгтэй. Бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь туслалцаа үзүүлэх чиг үүрэгтэй байдаг.

Хоёрдугаарт, хуулийн төслийн маань ажлын хэсгийн гишүүн. Тийм учраас энэ Аюулгүйн зөвлөлийн дарга оролцох ёсгүй ээ гэдэг энэ асуудал байж болохгүй ээ.

Би дараагийн таны тэр асуултад хариульа. Одоо зарим гишүүдийн ёс зүйн зөрчил ярьж байгаа, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх асуудал бол энэ бол ёс зүйн ноцтой зөрчилд орох уу гэж Болормаа гишүүн асууж байх шиг байна. Ёс зүйн ноцтой зөрчил болох уу, ёс зүйн зөрчлийг яаж шийдэх юм бэ гэж. Улсын Их Хурлын гишүүний дагаж мөрдөж байгаа ёс зүйн дүрэм гэж байгаа. Та бүхний маань дагаж мөрдөж байгаа. Тэгвэл энэ дүрэмд хэн өөрчлөлт оруулах юм? Энэ дүрмийг хэн шинэчлэх юм? Энийг Улсын Их Хурлын гишүүд та бүхэн өөрсдөө.

Тийм учраас Ерөнхийлөгчөөс санаачилж байгаа энэхүү хууль дээр, дагалдах тогтоол дээр та бүхэн маань энийг оролцуулж Улсын Их Хурлын гишүүд өөрсдийнхөө Улсын Их Хурлынхаа бүрэн эрхийн хэмжээнд ёс зүйн зөрчил гэж юу юм бэ, ёс зүйн зөрчил нь дотроо ноцтой зөрчил гэж юу болох юм бэ гэдгийг та бүхэн маань тогтоох юм байгаа юм шүү. Ажлын хэсэг гаргаж энийг тогтоох ёстой байгаа. Энэ асуудал руу бол Ерөнхийлөгчийн институт Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан хуулиар оролцох боломжгүй.

Хэрвээ ийшээ орох юм бол Улсын Их Хурлын үйл ажиллагаа руу орчихно. Улсын Их Хурлын үйл ажиллагааг Улсын Их Хурлын гишүүд өөрсдөө шийдвэрлэх ёстой хуулиар. Тийм учраас энийг Их Хурлын гишүүд та бүхэн маань өөрсдөө шийдэх юм байгаа юм. Та бүхэн маань асуудлаа шийдээд, санал санаачилгаа гаргаад ёс зүйг хэрхэн тодорхойлох вэ, зөрчлийг хэрхэн ангилалх вэ, хэрхэн үнэлэлт, дүгнэлт өгөх вэ, хэрхэн шийтгэл оногдуулах вэ гэдгийг та бүхэн өөрсдөө томъёолох юм байгаа юм шүү.

Түрүүн тэр зарим гишүүдийн асуудлыг ярьж байна. Тэр ирцдээ хүрдэггүй ч гэдэг юм уу, тухайн ордонд асуудал үүсгэсэн ч гэдэг юм уу тухайн гишүүдийн асуудал ч гэсэн мөн энэ ёс зүйн асуудал уу, юу вэ гэдгийг бол та бүхэн тодорхойлно. Мөн ирцийн асуудал бас түрүүн ярьсан. Энэ ирцийн асуудлыг нь тодорхой хэлж байгаа. Ирцийн асуудал дээр ямар ч гишүүн мэдээж энэ асуудлаас ангид авч үзэгдэхгүй ээ гэдгийг хариулъя. Баярлалаа.

Ж.Батжаргал: Болормаа гишүүн тодруулъя.

Э.Болормаа: Улсын Их Хурлын гишүүний хувьд би хэзээ ч Монголчуудад ёс зүй ийм байх ёстой гээд ингээд хуульчлаад тэрийг хэлэх тийм том толгой гаргаж зүрхлэхгүй. Та бол Улсын Их Хурал бол өөрсдөө ёс зүй гэдэг юмыг тодорхойл оо гэж байна. Тэр бол бас их том өндөрлөг байх. Харин өнөөдөр энд хамгийн том ёс зүйн зөрчил өөрөө юу вэ гэхлээр найзан дундаа ороод Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга нь өөрийнхөө энэ төрийн тусгай ажлынхаа албан тушаалаа нугаад ажлын хэсгийн доктор, судлаач гэж энэ ажлын хэсэгт орж ирнэ гэдэг өөрөө энэ өөрөө ёс зүйн асуудал шүү. Энийг та бүхэн маань сайн бодоорой. Бие биеэ таньдаг бид нар нэг ордонд ажилладаг хамаагүй шүү дээ. Та хуулиар заасан чиг үүргээ хэрэгжүүлэх ёстой. Хэнийг хуурч ийм юм хийж байгаа юм бэ?

Ж.Батжаргал: Хариулъя ажлын хэсгийн. Санал уу? Санал. Баярбаатар гишүүн асуулт асууя.

Б.Баярбаатар: Байнгын хорооны гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Өнөөдөр өргөн баригдсан хуулийн хэлэлцэх эсэхийг Байнгын хороо хэлэлцэх гэж байх шиг байна. Би хэд хэдэн зүгээр танин мэдэхүйн шинжтэй ч байж магадгүй хэдэн асуултууд асууя. Энэ ёс зүйн зөрчил гэж яг юуг хэлж байгаа юм? Ёс зүйн зөрчлийг өнөөдөр хуульчилсан яг хэдэн орон байдаг юм? Ёс зүйн ноцтой зөрчил гэж яг юуг хэлж байгаа юм? Хууль санаачлагч энийг нэг юм тооцоолсон байгаа шүү дээ. Ёс зүйн зөрчлөөсөө ноцтой зөрчил нь юугаараа ялгаатай юм гэдэг асуудал.

Дараагийн нэг асуудал нь юу гэхээр энэ эгүүлэн татах эрх ер нь хэнд байдаг юм? Би бол одоо олон судалгаа юман дээрээс үзсэн. Эгүүлэн татах эрх бол зөвхөн сонгосон субъектүүдэд байдаг байхгүй юу. Манай Үндсэн хууль дээр эгүүлэн татна аа гээд биччихсэн байгаа нь өөрөө алдаа байхгүй юу. Парламент өнөөдөр парламентынхаа гишүүнийг эгүүлэн татах эрхгүй. Үндсэн хуулийн цэц эгүүлэн татах эрхгүй, ганцхан сонгогчид нь өөрсдөө эгүүлэн татна.

Хэрвээ бид нар энэ асуудлыг ярих гэж байгаа бол энэ эгүүлэн татна гэдэг үгээ чөлөөлнө гэж байж оруулж ирж байх ёстой. Эс үгүй бол хөөнө. Одоо хатуухан хэлэхэд. Тэгж байж энэ хууль зүйн хэллэг нь өөрөө зөв болох гээд байгаа юм.

Дээр нь энэ тангаргаасаа няцсан гэж яг юу яах юм? Энэ арай л тийм ерөнхий ойлголт байгаад байгаа байхгүй юу. Яасныг тангаргаасаа няцсан гэх юм? Тэр Үйлстөгөлдөр дарга түрүүн бас Ариунзаяа гишүүний асуултад хариулж байх шиг байна. Тэр жагсаалтын гишүүд буюу хувь тэнцүүлэн сонгосон гэж. Нам нь дэвшүүлээд ингээд нам өөрөө хариуцлага хүлээнэ. Яах вэ олон улсын жишигт бол нам нь өөрөө Үндсэн хууль зөрчсөн бол гэж нэг ийм томъёолол байдаг юм. Нам нь өөрөө шүү. Гишүүн биш.

Нэг талаараа жагсаалт дотроо нээлттэй, хаалттай гэж 2 байгаа. Манайх нээлттэй жагсаалтаар явсан. Хэн хэн жагсаалтын хэддүгээрт жагссан бэ гэдэг

нэртэйгээ, зурагтайгаа явж байгаад бараг тэр жагсаалтын гишүүдийг чинь харж намд нь санал өгсөн байхгүй юу. Магадгүй одоо ингээд энэ жагсаалтын гишүүдийг чинь ингээд төлөөллийн төв байгууллага нь шийдвэр гаргаад эгүүлэн татдаг болчихъё л доо. 28 оны сонгуульд эхний 10 дээр нь нэг олон нийтийн хүлээлтэд үүссэн, нийцсэн маш гоё улсуудыг ингэж нэр дэвшүүлж оруулчхаад орсныхоо дараа нөгөө 10-ыгаа эгүүлэн татаад дараагийнх нь 10-ыг оруулж ирдэг. Нөгөө дараагийнх нь 10 нь нөгөө улс төрд олон жил болчихсон нөгөө нөхдүүд нь ингээд ард нь жагсчихсан байж байгаад үгүй ээ ийм эрсдэл үүснэ шүү дээ.

Дээр нь энэ чинь Улсын Их Хурлын гишүүн чинь Үндсэн хуулиараа юу гэж заасан байдаг билээ? Бүх ард түмний элч байна гэж заасан байдаг билүү? Улс төрийн намын элч байна гэж заасан байдаг билүү? Иймэрхүү зүйлүүд байна. Тэгэхээр энэ асуултдаа би хариулт авчихъя. Тэгээд дараа нь тодруулъя.

Ж.Батжаргал: Хариулъя. Ажлын хэсгийн 2 номер.

А.Бямбажаргал: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Гишүүний асуусан асуултад хариулъя. Та үндсэндээ 4 асуудал бас хөндөж тавилаа. Тэгээд бид нар нэг зүйлийг хамгийн түрүүнд зарчим болгож бид ярих ёстой байх. Тэр юу вэ гэхээр Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж байгаа Үндсэн хуулийн дэг журмын хүрээнд энэ асуудлаа бид нар ярих ёстой. Дэг журмын хүрээнд.

Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Үндсэн хууль 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр батлагдаж, 2 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсөн байдаг нийт улс орон даяар. 1992 онд Монгол Улсын Үндсэн хуулийг батлахдаа 2 газар эгүүлэн татна гэдэг заалтыг оруулсан байдаг.

Нэгдүгээрт, Монгол Улсын Үндсэн хуулийн 29.3 дугаар зүйлд, 3 дугаар зүйлд.

Хоёр дахь нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хянан шийдвэрлэх маргааны төрөл буюу Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2.4 дэх заалтад. Өөрөөр хэлбэл, Цэцийн харьяалан шийдвэрлэх маргааны нэг бол Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах эсэх асуудлаар дүгнэлт гаргана.

Гэхдээ энэ дүгнэлт нь бол эцсийн дүгнэлт шүү дээ. Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 3-д нь 1, 2 дахь асуудлаар хэрэв Улсын Их Хурал хүлээж аваагүй бол түүнийг нь дахин хянан үзэж Цэцийн шийдвэр гаргахаар заасан байдаг. Энэ тухай холбогдох Үндсэн хуулийн цэцийн шийдвэр өдгөө бол 7 удаа гарсан байгаа юм.

Өөрөөр хэлбэл, би үүгээр юуг хэлэх гээд байгаа юм бэ гэхээр эгүүлэн татна гэдэг энэ асуудлыг хэрэвзээ өөр хэлбэрээр томъёолж өөр агуулгаар ярина гэвэл энэ Үндсэн хууль өөрчлөгдөх хэрэгтэй болно. Өөрчлөгдөх хэрэгтэй болно.

2019 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд хэд хэдэн асуудал хөндөгдсөний нэг нь 29.3 дээр тодруулж нэг зохицуулалтыг оруулсан юм. Тэр нь гишүүн өргөсөн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол эгүүлэн татагдана гэдэг ийм зүйлийг. Би бол дэд ажлын хэсэг тухайн үед ажиллаж байсан. Өнөөдрийн энэ ярьж байгаа зүйлийг 19 онд ч гэсэн би яг энэ хэлбэрээр ярьж байсан. Миний протоколууд одоо ч гэсэн байж байна. 1 дүгээрт.

Хоёрдугаарт, бусад улс, орнуудын хувьд ер нь, ер нь ёс зүй гэдэг энэ асуудлыг хуульчилдаг юм уу, хуульчилдаггүй юм уу гэдэг агуулга хөндөж байна. Монгол Улсын хувьд гэлтгүй одоо бид нарын хуульчдын хувьд бол хамгийн эхний үздэг Ромын эрх зүйгээс авхуулаад л бид нар чинь хууль зүйн боловсрол эзэмшсэн. Тэртээ өмнө хэдэн зууны өмнөх дамжсан тэр хэм хэмжээнүүд ерөөсөө л хулгай хийж болохгүй, худлаа хэлж болохгүй энэ чинь явсаар байгаад л хэм хэмжээ чинь л өөрөө нийгмийн хэм хэмжээ хууль болдог.

Өнөөдөр гэхэд Монгол Улсын Их Хурал 2009 оноос хойш Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм гэдэг энэ дүрмийг Улсын Их Хурлын тогтоолын төслөөр, тогтоолоор баталж мөрдөж байна. 21 онд шинэчилсэн шинэчилсэн. Өөрөөр хэлбэл, энэ хариулт маань өөрөө тэрний нэг нь Монгол Улс өөрөө юм байгаа юм.

Харин энэ дүрмийн хэрэгжилтийг хэрхэн хангах вэ, яаж хангах вэ гэдэг бол энэ өөрөө тусдаа асуудал байх. Бусад улс, орнуудын жишээ бий. Ёс зүйн асуудал дээр тухайлбал Улсын Их Хурлын гишүүдийн одоо гарын авлага гэж энэ ном байдаг. Та бүхэнд бас бодвол өгсөн байх. Энэ хүрээний 175 дугаар талыг та бүхэн харах юм бол ёс зүйн хариуцлагыг хүлээлгэдэг, хянадаг, түүнд тооцох сахилгын бусад шийтгэлүүдээр нь улс орнуудыг харьцуулж тавьсан байгаа.

Тухайлбал, Австрали улс сануулах, анхааруулах, донгодох гэх мэтчилэн ийм шийтгэл. Энэ дандаа ёс зүйн шүү. Би одоо өөр зүйл яриагүй. Их Британи Улс тусдаа бие даасан хуультай. "Recall" гэж байгаа энэ бол өөрөө. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс бас Бундастагийн ёс зүйн дүрэмтэй. Энэтхэг улс одоо хамгийн их олон парламентын гишүүнтэй улс шүү дээ. Умард Ирланд.../минут дуусав./

Ж.Батжаргал: Тодруулах юм уу та? Баярбаатар гишүүн тодруулъя.

Б.Баярбаатар: Таны тийм саяын дурдсан улсуудад тэрнээс гаднах улсуудад ёс зүйн ноцтой зөрчил гэдгийг нэг ч улс нь хуульчлаагүй байгаа шүү. Ноцтой зөрчил гэдгийг.

Дээр нь наад саяын таны ярьсан улсууд дээр чинь ёс зүйн зөрчил юуг үздэг юм бэ гэхээр ашиг сонирхлын зөрчлийг, хөрөнгө орлогоо худал мэдүүлснийг ерөнхий агуулгаар нь ярьж байгаа шүү. Хуралд хүндэтгэлгүй хандсаныг гэж байгаа. Эрүүгийн гэмт хэргийн шинжтэй асуудал бол тэртээ тэргүй тэр парламентын гишүүнээс чөлөөлөх үндэслэл нь шүүхийн шийдвэр бол болдог юм. Шүүхийн шийдвэр бол заавал биелэгдэх ёстой шүү дээ. "rule of rule" гээд. Шүүхийн шийдвэрийг парламент ч хэлэлцэх эрх байхгүй.

Тэр намын асуулт дээр нэг хариулт авъя. Жагсаалтын асуулт дээр. Хариулж амжсангүй байх шиг байна лээ.

Ж.Батжаргал: Хариулъя. Ажлын хэсгийн 2 номер.

А.Бямбажаргал: Баярлалаа. Та яг би бас хэлэх гэж байсан зүйлүүд маань бас хэлчихлээ учраас би тэн дээр нь товчилъя. Зарчмын хувьд бол Монгол Улсын Үндсэн хуульд эгүүлэн татах харилцааг 19 онд зохицуулахдаа бид бүхэн өргөсөн тангаргаасаа няцаж, Үндсэн хууль зөрчсөн болох нь тогтоосон бол эгүүлэн татна аа гээд нэг императив шинжтэй биччихсэн юм билээ. Өөрөөр хэлбэл, энэ маань бол шууд хэрэгжих ийм хэм хэмжээ байдлаар.

Таны хэлж байгаа бас гишүүнтэй би санал нэг байна. Бусад улс, орнуудаас бид нар Монгол Улсын Үндсэн хуулийн энэ дэг журам шиг зохицуулалтыг хайгаад олохгүй юм билээ. Яагаад гэвэл энэ зөвхөн Монгол Улсад байгаа юм билээ. Зөвхөн Монгол Улсад.

Хоёрдугаарт, уг хуулийн төслөөр ёс зүйн гэдэг энэ асуудалтай холбоотойгоор мэдээж хэрэг энэ яригдаж байгаа Улсын Их Хурлын гишүүний тангарагт “ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж” гэж нэмэлт оруулж байгаа.

Ж.Батжаргал: Баярбаатар гишүүн нэмж тодруулах гэж байна уу? Баярбаатар гишүүний микрофоныг.

Б.Баярбаатар: Яах вэ хууль санаачлагчийн санааг би ойлгож байна. Зүгээр өнөөдөр бол ёс зүй бол өөрөө хэм хэмжээ өнөөдөр нийгмийн хүлээлт болчихоод байгаа нь үнэн. Тэгэхдээ бид өнөөдөр энд сэтгэлийн хөөрлөөр хандаж бас болохгүй байгаад байгаа юм. Өнөөдөр үүссэн нөхцөл байдал дээр уялдаж бас энэ асуудал дээр хандаж болохгүй байгаад байгаа юм. Олон талаас нь судалж, үзэж байж, долоо хэмжиж нэг огтол гэдэг зарчмаар явах байх гэж би харж байгаа юм.

Мэдээж өнөөдөр Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татдаг, эс үгүй бол чөлөөлдөг ийм хуультай байх ёстой Монгол Улс. Зүгээр ийм хуультай байх ёстой гэдэг зарчмын үндсэн дээр өнөөдөр улс төрийн нам ч юм уу, Үндсэн хуулийн шүүх ч юм уу дангаар шийдвэр гаргаж одоо асуудалд ханддаг ийм эрх зүйн зохицуулалтыг бий болгож бол болохгүй байх. Энэ цаанаа тэр би парламентын дархлаа эд нар гээд том том асуудлууд яриад яах вэ.

Тэгэхдээ зүгээр их л олон талаас нь л харж үзье дээ л гэсэн саналтай байна.

Ж.Батжаргал: Санал байлаа. Даваасүрэн гишүүн асуулт асууя.

Ц.Даваасүрэн: Энэ хууль дээр бид нар 2 зүйлийг анхаарах ёстой байгаад байгаа юм. Тэр бусад улс оронд ямар байх хамаагүй. Манай Үндсэн хууль дээр ямар байна, бусад хууль дээр ямар байна гэдэг л асуудал байхгүй юу. Тэгэхээр энэ төрийн 3 том институт бие биеийнхээ эрх мэдэлд хандсан хууль санаачлахыг хуулиар хориглочихсон юм. Тухайлбал, Их Хурлын тухай хуулийн 4.1-д, Их Хурлын тухай хуульд Их Хурлын эрх мэдэлд онцгой бүрэн эрхэд хэн ч халдаж, бүүр хэн ч халдаж болохгүй гэхсэн байж байгаа.

Нөгөө талаараа бусад хуулиар зохицуулахгүй гэхсэн байж байгаа. Их Хурал гэдэг чинь төлөөллийн байгууллага. Үндсэн хуулиар юу гэж хэлсэн “төрийн эрх мэдэл ард түмний гарт байна. Ард түмэн төлөөллөөрөө дамжуулж төрийн эрх мэдлийг хэрэгжүүлнэ.” гэсэн. Тэгэхээр Их Хурлын гишүүн бол төрийн эрх барих, шийдвэр гаргагч хүн байгаа байхгүй юу. Тэгээд төрийн эрх барих байгууллагынхаа эрх мэдлийг зохицуулсан хуулийг Ерөнхийлөгч санаачилж болохгүй байхгүй юу.

Тэгэхээр наад хууль чинь өөрөө Ерөнхийлөгчийгөө хууль зөрчсөн байдал руу оруулаад байна шүү дээ. Бүр Их Хурлын онцгой бүрэн эрхэд халдаж болохгүй гээд ингээд 4.1 дээр чинь хэлчихсэн байгаа. Их Хурал гэдэг чинь Их Хурлын гишүүдээс бүрдэж байгаа байхгүй юу. Тэгээд мөн Их Хурлын тухай хуулийн 36.1.1 дээр хууль хязгаарын хүрээ, хязгаар гэж байж байгаа. Их Хурлын тухай хууль, Их

Хурлын дэгийн тухай хуулийг гагцхүү Их Хурал, Их Хурлын гишүүн санаачилгаар хуульчилчихсан байгаа. Тэгээд энэ асуудлуудыг та бүхэн бас хэлэлцүүлгийн явцдаа онцгой. Одоо Ерөнхийлөгчийн тухай хуулиудыг Их Хурал барьж аваад хийх юм бол энэ хууль тогтоох байгууллага чинь яаж ч өөрчилж мэдэх байхгүй юу. Хэзээ нэг цагт Их Хурал Ерөнхийлөгчийн институт хооронд маргалдаан болох юм бол юу ч болж болохоор болно шүү дээ.

Тийм учраас хуулиар хориглоод байгаа байхгүй юу. Энэ Их Хурал чинь юуг ч өөрчилж чадах эрх мэдэлтэй төрийн эрх барих дээд байгууллага байхгүй юу. Энийг өдөөж болохгүй байхгүй юу. Засгийн газар нь ч тэр, Ерөнхийлөгч ч тэр нэгдүгээрт.

Хоёрдугаарт байна аа энэ хууль дээр нэг төрийн эрх мэдлийн хуваарилалтад нөлөөлөх заалт орчхоод байгаа юм. Би одоо ингээд олон жил парламентад суухад хэдхэн хүний зөрүүтэй төрийн эрх мэдлийн шийдвэр гарах болчихож байгаа байхгүй юу. Одоо та нар 90-ээд оны эхэн үед бол төрийн эрх баригч тэр шийдвэр гаргахад нөлөөлж байгаа ганц хүн нь Дашбалбар байсан үе бий шүү дээ. Дашбалбар хаашаа хазайна ийм.

Тэгвэл одоогийн энэ орж ирж байгаа хуулиар чинь Дашбалбарыгаа эвтэйхэн зайлуулчихаж болохоор болчихож байгаа байхгүй юу. Тийм учраас аль ч орны парламентад гишүүдийг эгүүлэн татах асуудлыг хориглодог нь тэр байхгүй юу. Төрийн эрх мэдэлд нөлөөлөх гээд байгаа байхгүй юу. Их Хурал чинь төрийн эрх барих байгууллага гэж та бүгд бодооч. Нэг хүн өөрчлөгдөхөд төрийн эрх мэдлийн хуваарилалтад өөрчлөлт орох ийм тохиолдол бол гарна. Амьдрал баян байхгүй юу. Тийм учраас энэ их.../минут дуусав./

Ж.Батжаргал: Санал байна уу? Хариульъя ажлын хэсгийн 2.

А.Бямбажаргал: Даваасүрэн гишүүний асуултад хариульъя. Монгол Улсын Үндсэн хуульд 19 оны нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд та бас яг бас хэллээ. Хууль санаачлах хүрээ, хязгаарыг хуулиар тогтоож болно оо гэдэг ийм заалтыг оруулсан үнэн. Монгол Улсын одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн хүрээнд энэ хязгаарлалтыг, хязгаарлалтыг тухайн үед Улсын Их Хурлын хуулийг батлахдаа юу гэж баталсан бэ гэхээр Монгол Улсын Ерөнхийлөгч зөвхөн Үндсэн хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд хууль санаачилна аа гэж 20 онд Улсын Их Хурлын тухай хуулийг баталсан юм.

Тэгээд тухайн үед Монгол Улсын Ерөнхийлөгч 2020 оны 5 сарын 26-ны өдрийн Е/06 гэдэг ийм хориг тавьж, тавих тухай албан бичгээр Улсын Их Хурлын тухайн батлагдсан хуульд хориг тавьж, уг хоригийг нь Монгол Улсын Их Хурал 2020 оны 8 сарын 20-ны өдрийн 15 дугаар тогтоолоор хүлээж авсан. Хүлээж авсан. Тэгээд ингэж хүлээж аваад Улсын Их Хурлын тухай хуульд ямар өөрчлөлт оруулсан бэ гэхээр Ерөнхийлөгч хууль санаачлахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг нь баримтална аа гэж заасан. Хууль санаачлах хүрээ, хязгаарыг шүү.

Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Ерөнхийлөгч хууль санаачлахдаа Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг гэдэг маань нэмж бүрэн эрх олгохгүй л гэдэг заалт одоо өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байна. Монгол Улсын Ерөнхийлөгч Үндсэн хуулиар хууль санаачлах эрх нээлттэй. Бүүр тодруулж хэлбэл энэ хязгаарлалт анх тогтооё гэж байсан энэ нөгөө тогтоосон зарчим маань

хоригийн дагуу хүлээж аваад харин эсрэгээрээ бүх хуулийг санаачилж болно гэж нээсэн юм билээ шүү. Нээсэн юм билээ.

Үндсэн хуулийн эрх зүйд нэг зарчим үйлчилдэг. Хууль тогтоомж бие биетэйгээ ижил түвшний хууль тогтоомжууд зөрчилдвөл эрх зүйн эрэмбэ буюу ... гэдэг энэ онол, зарчмынхаа дагуу дээд түвшнийх нь хэм хэмжээг нь барих ийм шаардлага үүсдэг юм. Энийг нь бид нар Үндсэн хуулийн эрх зүйд Үндсэн хуулийн зарчимдаа захирагдана аа гэж ингэж нэрлэдэг. Эсрэгээрээ энэ санаачлах эрхгүй гэж үзвэл дахиад тэр нь өөрөө Үндсэн хуулийн хууль санаачлах эрх рүү нь халдсан асуудал болж хувирах юм билээ. Хувирах юм билээ.

Цаашид энэ асуудлыг бас нэг мөр зохицуулах үүднээс зөвхөн Их Хурлын хууль гэлтгүй Хууль тогтоомжийн хуулиар ч тэр, бусад хууль тогтоомжуудаар эдгээр хууль санаачлах эрхийн хүрээ, хязгаарыг тогтоохгүй бол цаашид энэ асуудлууд бол улам л илүү гарах байх гэж ингэж харж байгаа юм. Баярлалаа.

Ж.Батжаргал: Даваасүрэн гишүүн тодруулъя.

Ц.Даваасүрэн: Тэгэхээр Их Хурлын тухай хуулийн 4.1 дээр тодорхой хэлчихсэн одоо тэр дээр би маргаад яах вэ. Их Хурлын онцгой бүрэн эрхэд хэн ч, хэн ч гэж байгаа шүү халдаж болохгүй гэж. Тэгэхээр одоо наад юм чинь цаашдаа юу гэж явах вэ? Өнөөдөртөө гайгүй байж болно. Женко Баттулга Их Хурлын хооронд тийм юм болсон байхгүй юу. Тэр үед бид нар Ерөнхийлөгчийн эрх мэдлийг зөндөө хязгаарласан байхгүй юу. Шүүхтэй холбогдолтой. Ийм жишиг тогтоод эхэлбэл наадах чинь одоо дараагийн парламент дээр байдаг юм уу, тэрний дараагийн парламент дээр Ерөнхийлөгчийгөө хэн ч биш болгож болно шүү дээ энэ Их Хурал чинь хууль тогтоох байгууллага юм чинь. Тэгж болохгүй шүү дээ.

Тийм учраас ёс зүйтэй байя гэвэл энэ 3 бие биеийнхээ эрх мэдэлд халдсан хууль огт санаачилж болохгүй. Төрийн эрх мэдлийг шилжүүлэх. Энийг ер нь бол бид нар онцгой анхаарах ёстой. Тэр би, миний нэг хэлээд байгаа асуудал 1, 2 хүний зөрүүтэй болчихсон парламент цөөнхөд үйлчилнэ ээ. Тэгэхээр энэ хууль цөөнхөд үйлчилнэ ээ. Энийг та нар юу гэж хараад байна?

Ж.Батжаргал: Хариулъя. Ажлын хэсгийн 3 номер.

А.Үйлстөгөлдөр: Түрүүн та 36.1.1-ийг асуусан. Улсын Их Хурлын тухай хуулийн 36.1.1-д Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурлын үйл ажиллагаатай холбоотой хууль санаачилж болно. Зөвхөн гишүүн гэж заасан. Энийг дурдана лээ. Энэ дээр би бас нэмэлт тодруулга, хариулт хэлэх ёстой гэж бодож байна. Энэ бол Улсын Их Хурлын үйл ажиллагааны тухай, үйл ажиллагаатай холбоотой хууль санаачлаагүй ээ. Энэ бол гишүүний бүрэн эрх дуусгавар болохтой холбоотой харилцааг Улсын Их Хурлын үйл ажиллагаа гэж ойлгох нь бас буруу ойлголт юм шүү гэдгийг бас хэлмээр байна. 36.1.1-д байгаа.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн зорилтод бол тодорхой бичсэн байдаг юм байна лээ. Энэ дээр бол яг цэг, таслалаар нь би танд хэлэхэд Их Хурлын бүрэн эрх, зохион байгуулалтын бүтэц, бүрэлдэхүүн, гишүүний бүрэн эрх, халдашгүй байдал, баталгаа гээд мөн улс.../минут дуусав./

Ж.Батжаргал: Даваасүрэн гишүүн тодруулъя.

Ц.Даваасүрэн: Тэгэхээр миний дүү өөрөө Цэц биш, Цэцийн гишүүн биш. Тийм учраас нэг их энэ дээрээ одоо тайлбар өгөөд байх шаардлага байхгүй. Энд хууль дээр биччихсэн байна. Би зүгээр чамд ах хүний хувьд хэлье. 3 институтийн хоорондын зодоон болж эхлэх юм бол ямар байдалд хүрэхийг би хэлээд байна шүү дээ. Болохгүй. Тийм учраас ёс зүйтэй хандаад бие биеийнхээ талаар хууль санаачилдаг байж болохгүй ээ гэж би хэлж байна.

Ялангуяа энэ 1, 2 гишүүнтэй ингээд байх үед цөөнхдөө үйлчилж төрийн эрх мэдлийг шилжүүлдэг ийм хууль болчих юм бол цаашдаа төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, эрх мэдлийг хоорондоо шилжүүлэх цөөнхөд үйлчилнэ. Тэгэхдээ аль ч нам хэзээ нэг цагт цөөнх болно гэж бодож байх хэрэгтэй. Дандаа энэ ардчилсан нийгэмд олонх байна гэж хэзээ ч байхгүй.

Тийм учраас цөөнхөө ... цөмлөдөг ийм хууль болчих вий гэдэг айдас надад байгаад байгаа байхгүй юу. Төрийн эрх мэдэлд шилждэг. Энэ байдлыг одоо бид нар бас гаргаж болохгүй ээ. Төр тогтвортой байх ёстой. Бие биедээ хүндэтгэлтэй хандах ёстой.

Ж.Батжаргал: Баярлалаа. Санал байна. Хэрлэн гишүүн асуулт асууя.

Б.Хэрлэн: Өдрийн мэнд. Тэгэхээр ер нь бол Улсын Их Хурлын гишүүн болоод бид нар ч тангараг өргөдөг. “Монгол Улсын Их Хурлын гишүүн би ард түмний элчийн хувьд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн, төрт ёс, түүх соёлынхоо уламжлалыг хүндэтгэж, Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, авлига, ашиг сонирхлоос ангид байж, гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхэд тангараглая” гээд тангараг өргөдөг л дөө.

Тэгэхээр ер нь бол ёс зүйн ямар одоо зөрчлийг ноцтой гэж үзэх юм бэ гээд сая асуугаад байна. Миний бодлоор энэ яг ёс зүй, ноцтой зөрчил гэдэгт бусад улс, орны жишээнээс харахад их олон улс оронд бас одоо яг энэ ёс зүйн ноцтой зөрчил гаргасан тохиолдолд Улсын Их Хурлын гишүүдийг парламентаас хөөх, эгүүлэн татах ийм хуулийн зохицуулалт бол байгаад байдаг юм байна.

Тэн дээр ямар тохиолдолд энийг ноцтой үздэг юм бэ гэхээр парламентын нэр хүнд, парламентын үйл ажиллагаанд хохирол учруулж байгаа тохиолдолд энийг ноцтой зөрчил гэж үзээд байдаг. Энэ нь эргээд парламентын гишүүнээс хөөх хүртэл ийм арга хэмжээ авахад хүргэдэг юм байна. Тэгэхээр нэгэнт бид нар ингээд төрт ёсныхоо түүхэн уламжлалаа хүндэтгэнэ ээ гээд ингээд андгай, тангаргаа өргөчхөөд тэгсэн хэр нь энэ дээр яг парламент дээрээ ороод ирэнгүүтээ үгүй ээ одоо зүгээр хэлэх, хэлэхгүйгээр хэлээд ёс, жудаг, цадиг гэж юм байхгүйгээр авирлаж байна шүү дээ. Өнөөдөр энэ ёс зүй гэдэг бол үнэхээрийн яах аргагүй бид нар ингэж зохицуулж оруулж ирэхгүй бол Их Хурлын гишүүний бүрэн эрх, Их Хурлын гишүүний халдашгүй байдал гээд ийм юмаараа халхавчлаад дураараа, зоргоороо авирлаад байдаг болоод байх юм. Энэ ер нь зөв юм уу?

Тэгэхээр одоо энэ ноцтой зөрчил гэдэг тухай асуудал дээр та, ажлын хэсгийнхэн хэлж байна. Парламентын гишүүд энэ хуулийг боловсруулах ажлын хэсгийг байгуулаад явах явцдаа ёс зүйн зөрчил гэдэг нь чухам яг юу юм, юу нь ноцтой юм, юу нь сахилгын зөрчил болох юм гэдэг дээр ялгаад ирээд орно байх, энэ дээр ажиллана байх аа гэж ингэж хэлж байна л даа.

Тэгэхээр энэ тухай дээр ер нь бол сахилгын зөрчил, энэ ноцтой зөрчлийн тухай дээр бас та бүхний судалсан, харьцуулсан ийм зүйл байгаа болов уу?

Ж.Батжаргал: Хариулъя. Ажлын хэсгийн 2 номер.

А.Бямбажаргал: Хэрлэн гишүүний асуултад хариулъя. Хуулийн төслийн үндсэн концепцын хүрээнд бас хамгийн түрүүн яригдаж байгаа зүйл бол Улсын Их Хурлын гишүүний өргөж байгаа тангарагт ёс зүйн хэм хэмжээг чанд сахих гэдэг ийм зүйлийг нэмэлтээр оруулахаар тусгасан. Нэмэлтээр оруулахаар.

Хоёрдугаарт, энэ ёс зүйн гэдэг энэ хэм хэмжээг хэмжих хэмжүүр одоо ч гэсэн хүчин төгөлдөр Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд, Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийн хүрээнд ингээд хүчин төгөлдөр үйлчилж.

Хоёрдугаарт, яг энэнтэйгээ уялдаад Улсын Их Хурлын гишүүн, хуулиар бол бид бүхэн юу гэж ярьдаг вэ гэхээр нөхцөл зааж байгаа буюу гипотизыг, гипотиз гэж. Энэ гипотизт нь юу бичсэн юм бэ гэхээр ёс зүйн хүрээнд хэрэв иргэд Улсын Их Хурлын гишүүний, гишүүнээ өөрөөр хэлбэл төлөөллийн дээд байгууллагынхаа гишүүнийг ардчилсан ёсныхоо зарчмын дагуу хяналтыг хэрэгжүүлнэ гэвэл Ёс зүйн хороонд, тэгэхдээ хаа хамаагүй асуудлаар бас биш шүү. Биш шүү. Үндсэн 4 ийм асуудал байгаа.

Нэгдүгээрт, гишүүн өргөсөн тангаргаасаа няцсан эсэх асуудлаар.

Хоёрдугаарт, Улсын Их Хурлын гишүүний үндсэн, 2 үндсэн Улсын Их Хурлын чиг үүрэг бий. Нэгдүгээрт нь бол төлөөлөх чиг үүрэг. Төлөөлөх чиг үүрэг. Өөрөөр хэлбэл, ард түмнээ төлөөлж байгаагийнхаа хувьд хуралдаа идэвхтэй суух гэдэг ийм зарчим маш олон улсуудад бас бичигдсэн байгаа.

Хоёрдугаарт, хоёр дахь чиг үүрэг буюу хууль тогтоох чиг үүрэг. Өөрөөр хэлбэл, хууль тогтооходоо зөвхөн ирцээ бүрдүүлэх бус, санал өгч оролц гэдэг энэ зарчмыг нь бичиж байгаа.

Гуравдугаарт нь бол Монгол Улсын хувьд өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа түрүүн бас нэг дурдагдсан Төрийн албан хаагчийн ёс зүйн хуулиар бол 220 мянга орчим төрийн албан хаагч ёс зүйн энэ хууль нь үйлчлэлийн хүрээнд байгаа юм. Ойролцоогоор 17 хүнд энэ хугацаанд энэ бүүр огцруулах хэмжээний шийтгэл оногдуулж энэ хуулийг хэрэглэсэн юм билээ 21 оноос хойш. Энэ хүрээнд зөвхөн энэ төрийн албан хаагчийн ёс зүйн гэлтгүй төрийн албан хаагчийн хуульд ноцтой зөрчил болон удаа дараа зөрчил гаргах гэдгийг нь одоо хүртэл зохицуулсан байна.

Өөрөөр хэлбэл, ёс зүйн дүрмийн хүрээнд түрүүн бас дурдаад байсан энэ гипотизыг юу гэж бичих гээд байгаа юм бэ гэхээр хэрэв энэ хуулийн төсөл батлагдвал Улсын Их Хурал маань ёс зүйн дүрмээ шинэчлэн батлах гэдэг асуудал гарч ирж байгаа. Энэ хүрээндээ чухам ноцтой зөрчил нь аль нь юм, яаж тооцох юм, юуг оруулах юм, энийг хэрхэн хянах юм? Өөрөөр хэлбэл, ирсэн өргөдөл, гомдлыг Ёс зүйн дэд хороо маань урьдчилан хянан үзэж гэдэг бас гипотез бичсэн.

Улмаар хаа хамаагүй бас асуудлаар биш тэдгээр асуудлуудаар одоо гомдлоо гаргаж үүнийг нь хянаж үзээд Улсын Их Хурал маань бол Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргана шүү дээ. Хүсэлт гаргана. Үндсэн хуулийн цэц яагаад энд орж ирж байгаа юм бэ гэхээр Монгол Улсын Үндсэн хуулийн өнөөдрийн дэг журам энд

үйлчилж байгаа юм. Ардчилсан ёсныхоо зарчмаар парламент маань өөрөө нээлттэйгээр саналаа илээр өгч хэлэлцээд тэгээд улмаар олонхоороо Үндсэн хуулийн цэцэд хандаж байгаа. Энэ бол Үндсэн хуульд ёсны зарчим нь үйлчилж байгаа юм. Үндсэн хуулийн цэц маань уг асуудлыг хянаж үзээд тангаргаасаа няцсан эсэх асуудлыг хянаж үзээд дүгнэлтээ гаргана. Энэ дүгнэлт нь бол эцсийн шийдвэр.

Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн 29.3-тай холбоотойгоор үүнийг нь Улсын Их Хурал авч хэлэлцдэггүй. Энэ бол 95 оноос хойш өнөөг хүртэл тогтсон ийм Цэцийн одоо практик. Энийг нь харин 19 онд бол 29.3 дээрээ бүүр тодорхой болгоод императив шинжтэй хэм хэмжээ болгоод биччихсэн юм билээ. Баярлалаа танд.

Ж.Батжаргал: Баярлалаа. Ганбаатар гишүүн асуулт асууя.

А.Ганбаатар: Байнгын хороогоор энэ хуулийн төсөл хэлэлцэх эсэх дээр гишүүд саналаа хэлж байна. Хамгийн түрүүнд 2015 онд санагдаж байна. Тухайн үед би Ерөнхийлөгчийн зөвлөхөөр ажиллаж байхад Машбат судлаач байл уу тээ яг иймэрхүү агуулгатай хуулийн төсөл орсон. Байнгын хороон дээр буцсан юм. Тэгээд энэ үйл явц давтагдаж магадгүй.

Гэхдээ өнөөдөр энэ нийгмийн байдлыг харахаар одоо иргэд гэх юм уу даа энэ хүмүүс маань Их Хурлын гишүүдээс хариуцлага, ёс зүй нэхэж байгаа юу гэвэл нэхэж байгаа. Манай гишүүдийн ярьж байгааг сонсоход бол энэ Үндсэн хуулиа барьсан зөв зүйтэй асуудлуудаа бас нөгөө талаас нь тавьж байна шүү дээ. Тэгэхээр зарим нэг нь энд нэг халдашгүй дархан байдалдаа шигдэх гээд байгаа юм шиг, зарим нэг нь шударга ёс тогтоох гэж байгаа юм шиг ингэж ийм 2 талцал үүсээд байна. Зүгээр миний ажиглаж байгаагаар.

Өнөөдөр жишээлэхэд Байнгын хороогоор, дараа нь чуулган дээр гишүүд өөр өөрийнхөө байр суурийг хамгаалаад саналаа өгнө. Тэгээд энд нь хэн хэнийх нь байр сууринд битгий халдаач ээ. Их Хурлын гишүүн өөрийнхөө итгэл үнэмшил, судалсан хүрээндээ саналаа өгдөг шүү дээ. Зарим хүн нь одоо энэ хууль батлагдах юм бол эмзэг сэдэв нь хөндөгдөх гээд тойроод байгаа юм шиг, ийм байдалд орох гээд байгаа юм шиг. Зарим нь батлагдах юм бол тэдгээр хүмүүсийг тойруулаад бах нь ханах гээд байгаа юм шиг нэг ийм уур амьсгал бүрдээд байгаа байхгүй юу. Тэгэхээр нэгдүгээрт битгий тэгээч ээ. Энэ хэдэн гишүүд ийш тийш нь битгий чирээч ээ гэж байгаа юм. Санаатай, санаандгүй одоо энэ мэдээллүүд чинь явсаар байгаад энэ рүү ирж байна аа гээд.

Одоо байж байгаа энэ эгүүлэн татах гэдэг юм уу, түдгэлзүүлэх хуулийн хүрээ нь бол уг нь хангалттай. Харамсалтай нь одоо манай эрх баригч нарын ялангуяа энэ гишүүддээ энэ асуудал ургуулсан гишүүдээ оруулж ирээд хариуцлага тооцоод ингээд явахгүй байгаагийн улмаас л одоо ийм юм гарч ирээд байгаа шүү дээ. Миний ойлгож байгаагаар бол.

Тэгээд энэ байж байгаа хуулийн механизм нь явахгүй болохоор дараачийн арга хэрэгсэл буюу одоо янз бүрийн гарцуудыг хайсан ийм нөхцөл байдлаар төсөл нь орж ирсэн юм болов уу гэж харж байна. Ингээд нарийн нарийн хуулийн заалтуудыг нь орж харахаар дэмжихээр зүйлүүд байна. Дэмжиж болохгүй зүйлүүд байж байна. Тэгээд энийг задлаад ярих юм бол цаг хугацаа бас хүрэхгүй байж магадгүй.

Хамгийн энгийн жишээ гэхэд гишүүд тангараг өргөөд л гишүүн байхгүй юу. Жагсаалтынх байна уу, тойргийнх нь уу яг адилхан. Гэтэл намын жагсаалтаар орсон гишүүд намын дарга гэдэг юм уу намын хяналтын зөвлөлөөр ороод л татагдчих ийм юм харагдаж байгаа. Жагсаалтаар сонгогдсон гишүүний хувьд хэлж байгаа юм биш. Энэ бол өөрөө гишүүн болсон хүний үндсэн эрхэнд ингээд халдаад явчих маягтай.

Бусад юмыг нь би сайн мэдэхгүй байна. Түрүүн нэг гишүүн бас хэлж байна. Та 1 минут сунгаад өгөөрэй. Энэ Үндсэн хуулийн 26 байгаа түүний нэг дотор Ерөнхийлөгч, Их Хурал, Засгийн газар гээд нөгөө эрхүүдийг нь, хууль санаачлах эрх.../минут дуусав./

Ж.Батжаргал: Хариулт авч байж тодруулах дэгийн зохицуулалттай. Ажлын хэсгийн 2 номер.

А.Бямбажаргал: Ганбаатар гишүүнд баярлалаа. Тэгэхдээ яг одоо Үндсэн хуулийн нэг дэг журмын хувьд бид нар нэг юман дээр эргэлзэх юмгүй юм шиг байгаа юм аа гишүүн ээ. Юу вэ гэхээр 19 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд 29.3-ыг тодруулсан. Бас дахиад л нөгөө хууль зүйн хэллэгээр гипотез бичсэн байхгүй юу. Ямар гипотез бичсэн бэ гэхээр Үндсэн хууль зөрчсөнийг Цэц тогтоовол эгүүлэн татна аа гэж. 1992 онд, 1992 онд бол тийм зүйл байгаагүй 29.3 маань. Ямар зүйл байсан бэ гэхээр гэмт хэрэгт холбогдсон асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ ээ. Энэ бол тэгэхдээ энэ хуулийн төсөлд бол хамаагүй юм байгаа юм шүү. Тэр түдгэлзүүлэх эсэх асуудал. Улсын Их Хурлын гишүүнийг шүүх гэмт хэрэг үйлдсэнийг нь тогтоовол түүнийг эгүүлэн татна аа гэж 92 онд байсныг Үндсэн хууль зөрчсөнийг нь тогтоовол эгүүлэн татна аа гэж 92 оноос ялгаатай нь 19 онд биччихсэн юм. Энэ өөрөө шинэ дэг журам үйлчилж байгаа юм.

Яг энэнээс үүдэлтэйгээр Улсын Их Хурлын хуулийн хувьд нөгөө Цэцийн шийдвэрийг чинь хэлэлцэх юм уу үгүй юү гэдэг байдлаар одоогийн Улсын Их Хурлын хууль маань бас Үндсэн хуультайгаа зөрчилдсөн байгаа юм байна лээ. Тийм учраас энэ хуулийн төсөл тодруулж тодруулж орж ирж байгаа юм. Хууль санаачлах хүрээ, хязгаарыг та бас сая дурдлаа. Үнэн. Үндсэн хуульд 19 онд тогтоосон боловч эсрэгээрээ одоо бол ямар ч хүрээ, хязгаар байхгүй байгаа юм байна лээ Улсын Их Хурал дээр. Улсын Их Хурлын хуульд Ерөнхийлөгчийн хүрээ, хязгаар бол. Яагаад гэвэл хоригтой холбоотойгоор мэдээж хэрэг авсан.

Бас нэг зүйлийг бид бүхэн бас санах хэрэгтэй. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль гэж ийм хууль байдаг 2010 оны. Энэ хуульд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хүрээ, хязгаарыг тогтоож өгсөн байдаг. Ерөнхийлөгчийн бас Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа хүрээ, хязгаар бас үүгээр зохицуулагдаж байгаа. Улсын Их Хурлын гишүүдийн одоо өнөөдрийн оруулсан байгаа шиг энэ хуулийг Үндсэн хуульд бичье гэвэл Улсын Их Хурлын гишүүнд бас энд хязгаарлагдсан байгаа.

2019 онд энэ 29.3 дахь нэмэлт, өөрчлөлт хаанаас орж ирсэн юм бэ гэдгийг та бас нэг судлаад үзвэл яг та нөгөө асууж байгаа зүйлийнхээ хариулыг тэндээс авчихаар байгаа юм. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын хуулиар Улсын Их Хурлын гишүүн бол Үндсэн хуульдаа ийм зүйл оруулах эрхгүй. Харин энэ эрх нь хэнд байгаа вэ гэхээр Засгийн газар ч ийм эрхгүй. Зөвхөн Монгол Улсын Ерөнхийлөгчид энэ эрх хадгалагдаж байгаа юм.

Түрүүн Даваасүрэн гишүүн бас дурдаж байсан. Бид нар энэ эрх зүйн орчныхоо хүрээнд эдгээрийгээ авч үзэхгүй бол цоо шинээр одоо хэн нэгэн юм зохиож байгаа биш. Энэ чинь Монгол Улсын Үндсэн хуулийн л дэг журам шүү дээ энэ чинь. Тэр хүрээнд л 92 оноос хойш одоо ч гэсэн хүчин төгөлдөр үйлчилж байгаа энэ дэг журмаар бид бүхэн ярьж байгаа юм. Тэрийгээ эгүүлэн татах гэдэг ийм байдлаар биччихсэн. Бусад улс, орнуудад эгүүлэн татах гэдэг нь бол өөр хэлбэртэй.

Тэгээд тийм ч учраас нөгөө императив мандатын хувьд, чөлөөт мандатын хувьд бид нар харьцуулахаар өөр жишиг гарчхаад байгаа юм. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг бас Их Хурал маань хэлэлцэхгүй. Тэгэхдээ энэ зөвхөн нөгөө 66.2.3, 4 буюу Үндсэн хууль зөрчсөн эсэх, эгүүлэн татах эсэх асуудлыг бол энэ Ламжав гуайн мэдээллийн дагуу 1995 онд Монгол Улсын Үндсэн хуулийн цэц шийдээд тэр үеийн Их Хурлын хуулийг хүчингүй болгож байсан юм байна лээ тогтоолоороо.

Өөрөөр хэлбэл, 66.2.3, 4-тэй холбоотой Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар дүгнэлтийг нь хэлэлцээд байхаар хууль биччихсэн чинь Лхамжав гуайн мэдээлэл, тухайн үед бол өргөдөл гэж явсан. Өргөдлийн дагуу Үндсэн хуулийн цэц хянаж үзээд тогтоолоороо дунд суудлаараа хэлэлцээд Их хурал руу оруулсан. Улмаар 95 оны 02 гэдэг тогтоолоор энэ бол Үндсэн хуульд заасны дагуу зөвхөн нөгөө шийдвэрүүд буюу 66.1.2 дахь асуудлуудыг л Үндсэн.../минут дуусав./

Ж.Батжаргал: Ганбаатар гишүүн тодруулъя.

А.Ганбаатар: Тэгээд яах вэ асуулт гэхээсээ илүүтэйгээр ийм одоо давхцалууд гэх юм уу, хүрээ, хязгаар руу нь халдаад орчихсон бол энэ нь бас ингээд маргаан болгоод байх юм биш үү гээд. Гарц байж яагаад болохгүй байгаа юм бэ? Тухайлбал, энэ хуулийн төслийг бас сайжруулаад ийм хуулийн төсөл байж болох ёстой гэсэн гишүүд энд зөндөө байна шүү дээ. Тэгээд энэ гишүүд эрхийг нь аваад өөрсдөө санаачлаад явчхаж болно шүү дээ. Энд санаачилга өгөөд ажлын хэсэг нь одоо ингээд нийлээд явчхаж болно. Тэгээд ийм хууль явъя гэж байгаа бол одоо иймэрхүү гарцуудыг бас хайж үзэхгүй байсан юм уу? Олон нийтийн хэлэлцүүлгүүдийг би харсан. Радио, телевизээр зөндөө хэлэлцүүлэг болж байсан. Мэдээж шүү дээ Их Хурал ёс зүйтэй байх ёстой. Хэрэг төвөг хийсэн бол татагдаж байх ёстой гэдэг энэ нийгмийн сэтгэл зүй олон нийтийн хэлэлцүүлгийг бол заавал дэмжиж гарна.

Тэгэхээр энийг хуульчлахын тулд Их Хурлын гишүүд өөрсдөө яг тэр хүрээ, хязгаарынхаа дагуу санаачлаад ороод ирсэн бол магадгүй өөр байсан юм биш үү гэсэн ийм л юм асууж байгаа юм.

Ж.Батжаргал: Ажлын хэсгийн 3 номер.

А.Үйлстөгөлдөр: Ганбаатар гишүүнийг дэмжиж байна аа таны яриаг. Угаасаа хуулийн төслийг хэлэлцүүлэх, хуулийг цааш хэрхэхийг Улсын Их Хурлын маань эрхэм гишүүд бүгдээрээ оролцож, хэдэн талаас нь хэлэлцэж санаа бодлоо солилцож, нийлж энэ асуудлыг нэг мөр болгож шийдэж, үнэлэлт дүгнэлт өгөх ёстой гэж таны хэлсэн саналтай санал нэг байна.

Ж.Батжаргал: Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

Ц.Сандаг-Очир: Өнгөрсөн 90 оноос хойших 36 жилийн хугацаанд манай улсын Засгийн газрын насжилт 1.6 жил дунджаар. Олон л Засгийн газар огцорч олон л Засгийн газар байгуулагдаж байсан. Парламент бол харьцангуй тогтвортой, хугацаанаасаа өмнө тарж байсан тохиолдол байхгүй ээ. Парламентын дарга нар огцорч байсан хэд хэдэн кэйсүүд гарлаа. Монгол Улсын Ерөнхийлөгч бол нийт ард түмнээсээ сонгогддог. Их Хурлын гишүүд бол тойргийн ард иргэдээсээ сонгогддог. Ард түмнээсээ бас. Өнөөдөр ард түмний дунд төрийн эрх барих дээд байгууллага Парламент, Засгийн газрын нэр хүнд сайнгүй гэхээсээ илүүтэйгээр муу байна шуудхан хэлэхэд муу байна. Энэ юунаас үүдэлтэй вэ гэж. Тэгээд Ерөнхийлөгч бол ард түмнээс сонгогдсон сонгогчийн хувьд Ерөнхийлөгч хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд хуулийг санаачилж орж ирж байна. Ард иргэд хууль санаачлах эрхгүй учраас ард түмний төлөөлөл учраас ард түмэн дотор байгаа асуудлыг хуулийн төсөл болгож оруулж ирж байна аа гэж үзэж байна.

Яагаад гэхээр ард түмэн парламентад өгч байгаа үнэлгээ, улс төрчдөд өгч байгаа үнэлгээ муу байгаа учраас. Улс төрчид бид нар парламентын гишүүд бид нар өөрсдөө хариуцлагагүй, сахилга батгүй, ёс зүйгүй, хурал чуулгандаа суудаггүй, гуйлгадаг, түүлгэдэг. Сүүлдээ бол одоо парламент дээр, Засгийн газар дээр хулгай ярихаас өөр юм ярихаа больсон. Энэ нь өөрөө эргээд төрийн нэр хүндийг унагаж байна аа гэж.

Тийм учраас ийм асуудалд орооцолдоод байгаа гишүүдийг эргүүлэн татдаг байх асуудал хэрэгтэй юм байна аа гэдэг үндсэн дээрээс ард түмний тавиад байгаа хүсэлт, шаардлагад нийцүүлж ийм хуулийн төсөл оруулж ирж байгаа болов уу гэж би хувьдаа бол бодож байна. Бодож байна.

Гэхдээ энэ хуульд бас цаашдаа энэ хууль яг үүгээрээ батлагдаад явбал энэ парламентыг бас тогтворгүй байлгах ийм нөхцөлийг бий болгочих вий дээ гэсэн болгоомжлол байна. Улс төрийн нам намынхаа нэр хүндээр орж ирсэн, жагсаалтаар орж ирсэн гишүүдээ эргүүлэн татаад байдаг болчихвол хэн нэг иргэний гаргасан өргөдөл, гомдлоор асуудлыг хэлэлцүүлээд ингээд байдаг бол энэ бол парламент чинь бол үнэхээр энэ нөгөө 1.6 жилийн насжилттай Засгийн газар шиг.../минут дуусав./

Ж.Батжаргал: Хариулъя. Ажлын хэсгийн 3 номер.

А.Үйлстөгөлдөр: Сандаг-Очир гишүүнтэй санал нэг байна. Мэдээж хуулийн төслийг санаачлахдаа төрийн тэргүүн энэ асуудлыг маш сайн анхаарч үзэж, санал асуулга авч байж хуулийн төслийг санаачилсан. Мэдээж одоо парламентын дархлаанд халдвал яах вэ, гишүүний бүрэн эрх, хэн нэгнийг бас зохион байгуулалттайгаар хэлмэгдүүлбэл яах вэ, энэ нөхцөл байдлыг хэрхэх вэ гэдэг талаар бол өнгөрсөн хугацаанд бол нээлттэй бид нар санал солилцож энэ асуудал дээр маш чухлаар тусгасан байгаа.

Парламентын гишүүнийг 3 шатны механизмаар хамгаалах, аливаа асуудал, хэлмэгдүүлэлтэд өртөхгүй байх талаар нь бас энэ хуульд тусгасан байгаа. Мэдээж Ёс зүйн дэд хороо гаргасан өргөдлийг хэлэлцэж энэ өргөдөл үнэн бодитой юу эсэх асуудлаар дүгнэлт гаргах, нээлттэй урьдчилж хэлэлцээд, түүний дараа нээлттэйгээр ард олондоо нээлттэй санал хураалт гаргаж Улсын Их Хуралд оруулах, үгүй эсэх, мөн дараагийн шатад Улсын Их Хуралд ч гэсэн нээлттэйгээр ард иргэддээ нээлттэйгээр энэ асуудлаар хэлэлцүүлэх гэх мэт. Мөн цаашлаад бол

Улсын Их Хурлаас гаргасан шийдвэрийг Цэц хянан үзэх гэх мэт 3 шатын ийм зүйлийг бол оруулж өгсөн байгаа.

Мэдээж энэ хэрхэн хянах вэ, алийг нь ёс зүйн асуудалгүй вэ, алийг нь хэрхэн шийдвэрлэх вэ гэдэг энэ хэм хэмжээ бүх зүйлүүдийг Их Хуралд өөрт нь хадгалж үлдээж байгаа. Их Хурлын бүрэн эрх. Тийм учраас энэ үндсэн нөхцөлүүдийг гаргасан хуулийн төсөл гэж ойлгож болно. Энэ дээр Их Хурал, Их Хурлын гишүүд, Байнгын хороод хэлэлцээд хуулиа хэрхэхийг асуудлыг цааш нь авч хэлэлцэх нь зүйтэй.

Ямар ч байсан гэсэн хэрэгцээ шаардлага байна уу? Байна. Хамгийн гол нэг ноцтой асуудал нь гэх юм бол манай хоёр хууль хоорондоо зөрчилдчихөөд байгаа юм. Үндсэн хууль, Улсын Их Хурлын тухай хууль хоёр хууль Үндсэн хуульдаа нийцэх ёстой.

Гэтэл Үндсэн хуульдаа Их Хурлын гишүүн хэрэв шүүхээр гэм буруутай, гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон бол татагдана аа гэж Үндсэн хуульд заасан байдаг. Мөн Цэцээр тангаргаасаа няцсан, Үндсэн хууль зөрчсөн гээд ингээд дүгнэлт гарчихсан бол энэ эцсийнх байх ёстой байдаг. Гэтэл шүүхийг шүүх гэж, эсвэл Цэцийн шийдвэрийн дээр Цэц байгаа юм шигээр энийг ахин Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх асуудал үүсчхээд байгаа учраас энэ бүх зүйл нөгөө ... буюу гацаанд орчихоод байгаа асуудал л даа.

Өөрөөр хэлэх юм бол хэрэв энэ асуудлыг Улсын Их Хурал хэлэлцчих юм бол яах вэ? Тэгвэл Улсын Их Хурлын дарга буруутан болох уу? Нөгөө Үндсэн хууль зөрчсөн асуудал дахиж болох гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энд хэн завшаад, хэн хохирч үлдээд байна вэ гэхээр тухайн Их Хурлын гишүүн ёс зүйгүй, эсвэл тухайн хариуцлагын эзэн дунд нь ямар нэгэн хэрэг хүлээхгүйгээр завшаад, хэн хохироод байгаа вэ гэхээр ард нийтийн итгэлийг алдаж, цөөн тооны асуудлаас болж Улсын Их Хурал бүхэлдээ нэр хүндээ унагах, дархлаагаа султгах ийм асуудал буюу энэ хуулийн зөрчлийн асуудал болоод байгаа. Тэгэхээр энэ зайлшгүй хэлэлцэж нэг талдаа гарч анхаарлаа хандуулах зайлшгүй асуудлууд байгаа юм аа гэдгийг бас нэмж дурдахыг хүсэж байна.

Ж.Батжаргал: Сандаг-Очир гишүүн нэмж тодруулъя.

Ц.Сандаг-Очир: Миний хувьд бол хуулийн 9.1.6, 9.2 энэ тэр гээд энэ гомдлоор эргүүлэн татдаг, намаас эргүүлэн татдаг энэ асуудлууд бол байж болохгүй ээ гэж үзэж байгаа юм. Энэ асуудал бол байж болохгүй. Энэ заалтыг бол одоо дэмжиж болохгүй гэж үзэж байгаа юм.

Харин би бол энэ 30-аас дээш хувьд нь хүрэлцэн ирээгүй, санал хураалтын 30-аас дээш хувьд биечлэн оролцоогүй эд нар гээд энийг бол бид нар одоо энэ Улсын Их Хурлын тухай хууль, Дэгийн тухай хуульд эд нар яаж гишүүнийг хуралдаа суудаг байлгах хөшүүргийг хийх үү, санал хураалтад яавал гишүүн хурлаа хаяад гардаг биш заавал биечлэн санал хураалтад оролцдог байх вэ гэдэг хөшүүргүүдийг яаж хийвэл болох вэ гэдэг талаас нь ярьж байгаа. Яг энэнтэй бол агаар нэг энэ заалтууд бол одоо давхцаж байгаа шүү. Энэ бол би бол байх ёстой гэж үзэж байна.

Өнөөдөр Байнгын хороо хуралдаж чадахгүй ирцээсээ болоод, Их Хурал одоо ирцээсээ болоод санал хураалтын үед саналаа хурааж чадахгүй ийм

байдлууд зөндөө байгаа. Тийм учраас заавал энэ Их Хурлын гишүүдийг биеэр суудаг байх, санал хураалтад биеэр оролцдог байх.../минут дуусав./

Ж.Батжаргал: Санал байна. Батбаатар гишүүн асуулт асууя.

Б.Батбаатар: Нэлээн хэдэн асуух гэж байсан зүйлүүд, хэлэх гэж байсан санаануудыг Их Хурлын гишүүд хэлчихсэн учраас давхардуулахгүйгээр зарим нэг зүйлийг асууя гэж бодлоо.

Улсын Их Хурлын гишүүнийг эргүүлэн татах тухай асуудлыг төрийн сонгууль болгоноор иргэд, сонгогчид асуудаг. Энэ ажлыг та нар хийх юм уу хийхгүй юм уу гээд нэр дэвшигч нараас. Өнөөдөр байгаа Сонгуулийн тухай хуулиар бол энэ 126 гишүүн ард түмэнтэй байгуулсан гэрээ байхгүй шүү дээ хувь болгон. Хуучин Их Хурлын гишүүд өөрсдийн мөрийн хөтөлбөртэй байдаг байсан тойрог дээр. Одоо бол байхгүй. Бүгдээрээ энэ 5 мөрийн хөтөлбөр дээр л байгаа. Тэр 5 мөрийн хөтөлбөр буюу парламентад суудалтай намууд бол тэр мөрийн хөтөлбөр бол ард түмэнтэй хийсэн гэрээ. Өгсөн саналаараа тэр мөрийн хөтөлбөр нь дэмжигдэж Их Хурлын гишүүд мөрийн хөтөлбөр бол ард түмэнтэй хийсэн гэрээ. Тэгэхээр энэ мөрийн хөтөлбөрөө биелүүлэхийн тухай асуудал байгаад байгаа юм.

Нэг ёсондоо засаглавал, бид сонгогдвол ийм ажил хийнэ ээ гэдэг зүйлээ. Хийж чадахгүй байгаад нь татах уу, үгүй юү гэдэг тухай ярих ёстой. Дараагийн асуудал нь энэ Их Хурлын гишүүнийг эргүүлэн татчихсан байхад дараа нь яах юм, оронд нь хэнийг оруулах юм, тэр механизмыг хаана суулгаж өгсөн юм? Хэрвээ жагсаалтын гишүүнийг эргүүлэн татаад дараагийн жагсаалтын хүн нь орно оо гэвэл тэр хүн чинь мөнхөд өмнөх жагсаалтын гишүүдтэй байнга оролдоно оо л гэсэн үг. Байнга оролдоно шүү дээ.

Тэгэхээр тухайн дэвшүүлсэн нам нь хэнийг оронд нь оруулах юм бэ гэдэг зүйлийг энэ хуулийн төсөл дээр би харах гээд чадсангүй. Дээрээс нь энэ олонхын кнопоор Их Хуралд олонхыг бүрдүүлэгч нь Ёс зүйн хороо байна уу, нам байна уу, иргэд, сонгогчид байна уу, Цэц байна уу ингээд оруулаад ирэхэд Их Хурлын гишүүдийн олонхын кнопоор Их Хурлын гишүүнээс эгүүлэн татагдана гэж байна. Энэ нь болох юм уу? Нэг ёсондоо эрх барьж байгаа олонх энэ гишүүн байх нь бидэнд хэрэгтэй, байхгүй байх нь бидэнд хэрэгтэй гэдэг кнопын үйлчлэл орно. Тэгэхээр энийгээ яаж зохицуулах вэ?

Тэгээд ёс зүйн дүрэм гэж бас батлах ёсгүй байх аа? Ер нь ёс зүй ярьж байгаа бол нэгэнт хэрвээ энэ хууль батлагдвал дагаж гарах хууль болж хувирах ёстой байх. Дүрмээр бид нар асуудлыг шийдэх нь бас буруу байх. Ер нь бол зүгээр Их Хурлын гишүүдэд жишээ нь Эрүүгийн хууль чинь нэг талаасаа эрүүгийн гэмт хэрэгтнийг шийдэхээс гадна нөгөө талдаа айлгах буюу соён гэгээрүүлэх ажил байдаг юм шүү дээ. Чи хүн гэмтээвэл тэдэн жилийн ялтай шүү гээд. Тэрэнтэй адилхан ийм зүйл бас Их Хурлын тухай хуульд байх нь зөв байх гэж бодож байгаа.

Ж.Батжаргал: Хариулъя. Ажлын хэсгийн 2 номер.

А.Бямбажаргал: Батбаатар гишүүний асуултад хариулъя. Юун түрүүн уг хуулийн төсөлтэй холбоотойгоор хэрэв зээ эгүүлэн татагдвал гэдэг ийм нөхцөл та хэллээ. Энэ бол Улсын Их Хурлын Сонгуулийн хуулиар зохицуулагдах байх. Улсын Их Хурлын Сонгуулийн хуулиар. Өөрөөр хэлбэл, одоо ч гэсэн Улсын Их

Хурлын Сонгуулийн хуулиар зохицуулагдаж байгаа. Тийм учраас түүгээрээ бас зохицуулагдана.

Хоёрдугаарт бас нэг зүйлийг бид нар хүн бодох хэрэгтэй. Дүрмээр байх уу хуулиар байх уу гэдэг бол Улсын Их Хурлын өөрийнх нь онцгой бүрэн эрхийн асуудал. Одоо бол дүрмээр ёс зүйн дүрмийг зохицуулж ирсэн байна 2009 оноос хойш. Анх удаагаа 2009 онд бол энэ дүрмээр зохицуулсан юм билээ. Хожим 2021 онд дүрмийг бол шинэчилж батлаад одоо дагаж мөрдөж байна. Дагаж мөрдөж байна.

Тийм учраас энэ бол өөрөө цаашид хууль байх уу дүрэм байх уу гэдгээс үүдэлтэйгээр иргэний ирсэн гомдол болгоныг бас хэлэлцээд байх одоо бол дүрэм тийм юм байна лээ шүү. Ирсэн гомдлыг л Ёс зүйн дэд хороогоор хэлэлцэх ийм, заавал хэлэлцэх ийм зохицуулалттай.

Тийм учраас хуулийн төсөлд “урьдчилан хянан үзэж” гэдэг ийм нөхцөлийг бичсэн юм. Түүний дараагаар цаашид Үндсэн хуулийн цэц хандах уу үгүй юу гэдгийг шийдэхийн тулд эхлээд дэд хороо маань бол өөрөө бас нээлттэйгээр хэлэлцээд, чуулганаар хэлэлцээд цаашид Үндсэн хуулийн цэцийн энэ асуудал цаашаа өрнөнө.

Хоёрдугаарт бас нэг зүйлийг бас бид бүхэн бас бодох хэрэгтэй. Монгол Улсын Үндсэн хуулийг 92 онд хүчин төгөлдөр дагаж мөрдөж эхэлснээс хойш хамгийн түрүүний баталсан хууль Үндсэн хуулийн цэцийн хууль байдаг. 5 сарын 10-ны өдрийн 92 оны. Энэ хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш өнөөг хүртэл яг одоо ч гэсэн иргэд Үндсэн хуулийн цэцэд Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудал, эгүүлэн татах эсэх асуудлаар мэдээлэл гаргах, өргөдөл гаргах эрх нь одоо ч бас нээлттэй шүү. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулиар ч тэр, Үндсэн хуулиар ч тэр бид нар нөгөө байхгүй зүйлийн тухай биш энэ чинь одоо явж байгаа байгаа гэдэг ийм зүйлийг гэдгийг бас мартаж болохгүй.

Харин Улсын Их Хурал энэ асуудлаа хэлэлцээд хүсэлт гаргавал хүсэлтийг бол заавал маргаан үүсгэж шийддэг. Хүсэлт гаргавал. Өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд Улсын Их Хурал одоогоор ганц удаа хүсэлт гаргасан байгаа Тэмүүжин нарын гишүүдийн санаачилгаар. Өнгөрсөн 7 хоногт Улсын Их Хурал энийг хүлээж авах шиг болсон. Өөрөөр хэлбэл, ард нийтийн төлөөллийн дээд байгууллага өөрсдөө асуудлаа хэлэлцэж байгаа байдлаар парламентынхаа дархлааг нь үлдээж байгаа юм. Хангаж байгаа юм. Хэрэвзээ одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуультайгаа энэнтэйгээ зэрэгцээд энэ дараачийнхыг нь жагсаалтаас нь шууд оруулна аа, оруулахгүй ээ гэдэг хуулийн зохицуулалт энэ ёстой хэн нэгэнд зориулсан хууль болох байх. Энэ хуулийн төсөл бол хэн нэгэнд ерөөсөө зориулаагүй. Хэн нэг жишээг бид нар энэ хууль дээр шууд авч хэрэглэж бас болохгүй, болохгүй.

Яагаад гэвэл хуулийн төсөл маань бол өөрөө тэнд зориулагдаагүй. Батлагдсан өдрөөс дагаж мөрдөнө. Баярлалаа танд.

Ж.Батжаргал: Батбаатар гишүүн тодруулъя.

Б.Батбаатар: Яах вэ тэгээд би бол энэ хуулийн төслийг Их Хуралд нэг хэлэлцээд аваадхаасай гэж бодож байгаа. Тэгээд олонхоороо нөгөө санал өгөхдөө

шийдээд явах байх. Зарим зүйлүүд төслүүд дээр, төслийн зарим зүйлүүд дээр бас саналуудаа оруулаад зарим өөрчлөлтүүдээ хийх ёстой гэдэг өнцгөөр хууль санаачлагч юу гэж бодож байгаа юм бэ гэж асуугаад байгаа юм. Түүнээс биш энэ жишээ нь манай намын 5 дахь, Ардын намын 17 дахь биш ээ 18, 19-д нь байгаа хүн, АН-ын 17 дахь хүн, ХҮН намын 7 дахь жагсаалт, Үндэсний эвслийн 5 дахь жагсаалт. Тэд нар чинь нэг юм бодож эхэлнэ шүү дээ. Яг одоо энэ орж ирж байгаа төслөөрөө батлагдвал Сонгуулийн хууль.../минут дуусав./

Ж.Батжаргал: Хариулт авах билүү? Ажлын хэсгийн 2.

А.Бямбажаргал: Батбаатар гишүүн санал хэллээ гэж ойлголоо. Таны хэлж байгаа бас үнэн. Сонгуулийн хуулийг хэрэв хөндөөд тэр жагсаалтын гишүүдийг эгүүлэн татвал дараачийнх нь шууд сонгогдоно гэдэг ийм хуулийн төсөл магадгүй дагалдуулаад өргөн барьчихсан бол, байсан бол байсан бол энэ чинь одоо тийм зүйл байхгүй гэдгийг танд хэллээ. Байхгүй. Тийм хуулийн төсөл санаачлаагүй. Зүгээр тэгж нөгөө ирээдүйд тэгвэл л гэдэг ийм нөхцөлөөр ургуулж одоо бид нар шууд хуулийг хэрэглэж одоо батлагдсанаар төсөөлөөд тэгж ярих, би одоо тэр хууль санаачлах тийм хууль санаачлаагүй болохоор тэн дээр бол тайлбар хэлэх эрхгүй байгаад байна.

Ж.Батжаргал: Одбаяр гишүүн асуулт асууя.

Э.Одбаяр: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийн энэ өдрийн мэндийг эрье. Өнөөдөр 4 сарын 7-ны өдөр. Өнөөдрөөс 36 жилийн өмнө Монгол Улс албан ёсоор 70 жил нэг намын тогтолцоотой явсан нийгмийн тогтолцоог халж олон намын тогтолцоонд шилжиж, АН бүртгэгдсэн өдөр. Тэгээд 90 оны ардчилсан хувьсгалыг хийж АН-ыг үүсгэн байгуулсан ахмадууддаа бас энэ өдрийн мэндийг хүргэе.

Энэ түүхэн өдөр ийм гунигтай хууль яриад сууж байгаадаа бас нэг жоохон сэтгэл эмзэглэж байна. Бид нарын энэ сүүлийн 36 жилийн турш зорьж явж байгаа олон намын тогтолцоотой үг хэлэх эрх чөлөөтэй, өмчтэй байх, ажил хөдөлмөр эрхлэх, хаана амьдрахаа өөрөө сонгох энэ эрхийн төлөө явж байгаа энэ үйл хэргийг одоо унтраах гэсэн, нухчин дарах гэсэн энэ хууль орж ирж байгаад их харамсаж байна.

Ойлгомжгүй олон зүйлүүд байна л даа. Жишээ нь Улсын Их Хурлын гишүүдийн ёс зүй гэдгийг яг юугаар хэмжих юм, Ёс зүйг хуульчилдаг болчихсон нөгөө үгэнд ор, эсвэл шоронд ор гэдэг шиг ёс зүйтэй бай, эсвэл гишүүнээ өг гэдэг тийм нийгэм рүү орж байна гэж ойлгож байна. Ёс зүй гэдэг дээр ямар үг, хэллэг, ямар үйлдлийг ёс зүй \ зөрчсөн гэж үзэх юм? Энэ дээр бас тайлбар хэлэх нь зүйтэй.

Хоёрдугаарт, энэ Үндсэн хуулийн цэц гэдэг байгууллагыг манай дарга нар ёстой будаа болгож байна. Огцорсон засгийг босгож ирдэг газар болгочихсон байсан чинь одоо үгэнд ордоггүй гишүүдээ татдаг, эргүүлэн татдаг нэг субъект болгохоор ашиглаж байна шүү дээ. Одоо энэ хууль нь яг энэ одоо байгаагаараа батлагдаад явах юм бол энд хэрэлдээд энд одоо асуудал үүсгээд байж байтал тэр Зайсангийн тэнд хуралдаад татаж байх юм байна л даа.

Тэгээд өнөөдрийн энэ байгаа байдлаа хар. Яг, ялангуяа энэ сөрөг хүчний гишүүдийн хувьд ёс зүйтэй байх боломж маш бага байгаа. Яагаад гэхээр эрх

баригчдынх нь гаргаж байгаа үйлдлээс шалтгаалаад. Энэ Цэцийг энэ нэг улс төрийн зодоон руугаа битгий оруулж хутгаач ээ.

Хоёрдугаарт юу вэ гэхээр энэ Үндсэн хуулийн цэц дээр Үндсэн хуулийн манаач байхаас гадна ёс зүйн асуудлыг шийдэх чиг үүрэг бас байдаг юм уу? Энэ 2 асуудал дээр хариулт өгөхийг хүсэж байна.

Хоёрдугаарт юу вэ гэхээр одоо хэдүүлээ нэг жоохон учиртай байхгүй бол нөгөө гадаа хүйтэн байна, дотроо нэг эвтэй байна гээд байсан одоо энэ институт хоорондын асуудал руу бас битгий бас чирчхээрэй гэж бас захих гэсэн юм. Тэгээд 2 асуултдаа хариулт авъя.

Ж.Батжаргал: Хариулъя. Ажлын хэсгийн 2 номер. 3 номер.

А.Үйлстөгөлдөр: Гишүүний асуултад хариулъя. Ёс зүйн тухай асуулаа. Ёс зүй хуульчлагдсан юм байна лээ. Их Хурлын гишүүд маань хуульчилсан. Үүнийгээ бол дагаж мөрдөж байгаа. Энэ нь болохоор Төрийн албаны тухай хуулийн 11.1.2, 11.1.4-д “Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурлын гишүүд нь төрийн улс төрийн албан тушаалд хамаарна.” гэж заасан байдаг. Үүнтэй уялдаатай төрийн албан хаагчийн ёс зүйн хуулийг бас баталсан Их Хурлын гишүүд маань. Энэ Ёс зүйн хуульдаа болохоор төрийн албаны 225 мянга орчим төрийн албан хаагч албан тушаалаасаа халагдах хүртэл хариуцлага хүлээх боломжтой байдаг.

Харин Их Хурлын гишүүдийн хувьд болохоор төрийн өндөр албан тушаалтан нь хамаарч байгаа. Мөн адил энэ хуульдаа хамаарах ёстой. Гэтэл гишүүний ёс зүйн дүрмээр зөвхөн цалингийн 20 хувь хүртэл торгуулах асуудал яригдаж байгаа. Тэгэхээр энэ чинь нөгөө дабл/double/ стандарт чинь бас үүсээд байгаа асуудал, ард иргэдийн бухимдал, бидэнд гаргаж байгаа өргөдөл, санал, гомдол. Ингэхээр энэ хууль маань энэ дүрэмтэйгээ дахиад зөрчилдсөн асуудал байгаа байхгүй юу.

Тэгэхээр манай Ерөнхийлөгчийн санаачилсан энэхүү хууль бол энэ хуулийн ойлгомжгүй зөрчилтэй олон энэ асуудлуудыг шийдэх гэж байгаа асуудал юм аа. Мөн Одбаярын гишүүний асуусан ёс зүйг хэрхэн тодорхойлох вэ гэж түрүүн өмнө бас дурдсан. Ёс зүйг бол хэрхэн зохицуулах вэ гэдгийг Их Хурлын гишүүд та бүхэн шийднэ ээ. Ийшээ бол бид бүхэн орох эрхгүй ээ. Улсын Их Хурал бүрэн эрхийнхээ хүрээнд Улсын Их Хурлын гишүүн та Одбаяр та бас саналаа өгөөд энэ дотроос хэрхэн хэв шинжийг нь хэрхэн тодорхойлох вэ, дүрэм журмыг нь хэрхэн гаргах вэ, зохицуулалт нь хэрхэн байх вэ, ёс зүйн зөрчил, ёс зүйн ноцтой зөрчил гэж юу юуг тодорхойлох вэ гэдгээ нээлттэй хэлэлцээд энийгээ тодорхойлох юм байгаа юм.

Тэгэхээр манай энэ бидний зүгээс өргөн барьж байгаа хууль маань үндсэндээ ерөнхий нөхцөлийг тодотгосон хуулийн төсөл гэж ойлгож болно. Баярлалаа.

Түрүүн асуусан Цэцийн тухай гишүүн асуусан. Тэгэхээр 1992 оноос хойш Цэцийн шийдвэрээр 7 тохиолдолд Их Хурлын гишүүдэд шийдвэр гаргаж байсан юм байна лээ. Элбэгдорж гишүүн, Ганболд гишүүн, Зориг гишүүн, Гончигдорж гишүүн, Нямдорж гишүүн, Төрмандах гишүүн гээд. Тэгэхээр энэ шинэ асуудал биш. Энэ 92 оноос хойш Цэцийн хүчин төгөлдөр шийдвэрийн асуудлууд байгаа. Тэгэхээр энэ бид бүхэн Үндсэн хуульдаа л захирагдаж Үндсэн хуулийнхаа хэм

хэмжээнд тааруулж энэхүү хуулийн төслийг санаачилсан гэж бас ойлгож болно. Баярлалаа.

Ж.Батжаргал: Баярлалаа. Баярмаа гишүүн асуулт асууя.

Байхгүй байна. Лодойсамбуу гишүүн асуулт асууя.

Ч.Лодойсамбуу: Гишүүддээ оройн мэнд хүргэе. Би бол энэ хуулийн төслийг өнөөдөр хэлэлцэх үү байх уу гэж ярьж байгаа энэ процесс дээр үнэхээр харамсаж байгаа. Ер нь манай парламентын гишүүдээс үе үеийн нэг ийм үйлдлүүд, үгнүүд гардаг. Энэ парламентын сүүлийн гишүүд юм шиг, энэ гишүүдээр энэ парламент ер нь цаашдаа дуусах юм шиг, зогсох юм шиг зөвхөн өөрсдийнхөө мэдрэмж, өөрсдийнхөө байгаа байдал, нөхцөл байдал дээр үнэлэлт, дүгнэлт хийгээд Монголын парламент, төрөөр тоглоод байдаг. Тоглох санаачилга гаргаад байдаг. Сая хууль санаачлагчдаас асуулт асууж байгаа, хариулж байгаа хэлэлцүүлгийг сонслоо. Эргээд гарах сөрөг үр дагаврын талаар олон гишүүд бас сануулж байна. Олон гишүүд бас асууж байна.

Хууль санаачлагчийн зүгээс хариулахдаа жишээлбэл парламентын дархлаа яах вэ гээд тэгэнгүүт, ёс зүй нь яах юм бэ гэнгүүт Их Хурлын гишүүд та нар өөрсдөө шийднэ ээ, гишүүнийг ингээд жагсаалтын гишүүнийг эргүүлэн татаад эхэлбэл яах юм бэ гэхээр Сонгуулийн хуулиараа явна аа. Энэ парламент эргээд энэ хуулиас чинь болж Монголын парламентын засаглал цаашдаа мянга мянган жил үргэлжлэх энэ парламентын засаглал хаашаа явах вэ, ямар муу үр дагавар гарч болох вэ гэдэг дээр ерөөсөө бодоогүй байна шүү дээ. Энийг хамгийн түрүүнд бодож байх ёстой. Энийг ухамсарлаж байх ёстой бид нар бүгдээрээ. Аягүй ойлгомжтой шүү дээ хэдэн хүнд л хариуцлага тооцох гээд байгаа шүү дээ. Энэ танхимд сууж л байна. Үгүй ээ энэ хүмүүсийг чинь бас хариуцлага тооцъё гэдгийг бид нар ч хүсэж байгаа шүү дээ.

Тэгэхдээ байна шүү дээ анчин, ямар ч анчин хүн байна шүү дээ ан хийх гэж байгаа нь энэ ээ гээд ой мод, уул, усаа тэр чигт нь шатаадаггүй байхгүй юу. Зүгээр ангаа хий л дээ. Яагаад парламентыг ингэж шатааж хаях гээд байгаа юм, нурааж унагаах гээд байгаа юм? Тодорхой яг үнэнээ л хэлж байна шүү дээ. Энэ 2 заалт тэр нэг гишүүний ёс зүйн ноцтой зөрчлөөр эргүүлэн татах, тэгээд дээр нь тэр жагсаалтын гишүүдийг эргүүлэн татах гэдэг энэ 2 заалт чинь л та нарын өргөн барьж байгаа төслийн амин сүнс нь шүү дээ. Энэ 2 заалтгүйгээр энэ хууль чинь цаашид та нарт хэрэг болох ч үгүй санаачлагчдад.

Тэгэхээр Монголын парламентыг бас бид нар бүгдээрээ бодох хэрэгтэй. Энэ парламентын гишүүдэд Монголын парламентын баганыг өшиглөх эрх байхгүй. Энийг яриад сууж байх бүүр ийм ямар ч эрх байхгүй. Бид нараар дуусах гэж байгаа парламент биш шүү дээ. Асуулт асуугаагүй. Дараа нь үг хэлнэ ээ.

Ж.Батжаргал: Оюун-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Л.Оюун-Эрдэнэ: Хэлбэр баахан ярилаа. Би шууд агуулга руугаа оръё гэж бодож байна. Монгол Улс өнөөдөр парламентын засаглалтай юм уу Ерөнхийлөгчийн засаглалтай юм уу? Ерөнхийлөгч нь парламентад ажлаа тайлагнадаг юм уу, эсвэл парламентад Ерөнхийлөгч хичээл заадаг юм уу? Энэ л асуудал дээр л одоо бид нар сүүлийн 30-аад жил л хэрэлдлээ. Би хүн яриагүй субъектив битгий хүлээж аваарай.

Сая Үйлстөгөлдөрийн үгэнд гарч байна. Бүх ард түмнээс сонгогдсон Ерөнхийлөгчийн хувьд гэж одоо хэдэн ч удаа ярив. Парламентын гишүүд нь болохлоор төрийн эрх барих дээд байгууллагын хувьд. Ингээд энэ чинь хоорондоо мөргөлдчихөөд байгаа байхгүй юу. Хэн нь том юм бэ гэдэг л зодоон яваад байна. Гүйцэтгэх засаглалаа аваачаад тоглоом болгочихлоо. Гүйцэтгэх засаглал гэж үндсэндээ өнөөдөр байхгүй боллоо. Одоо хууль тогтоох засаглалаа аваачаад нөгөө прокуророор нэг крантаар гоожуулдаг байсан чинь одоо дээрээс нь Цэцээр гоожуулаад, Ёс зүйн дэд хороогоор гоожуулаад, Улсын дээд шүүхээр гоожуулах юм байна. Санаа нь маш ойлгомжтой. Энийг батлахгүй бол тэгээд парламентыг тараах асуудлыг нөгөө ард нийтийн санал асуулга гээд төрийн бус байгууллагын хэдэн нөхдүүд тавих юм байна. Тэгээд ийм ойлгомжтой зүйл дээр би Монгол Улсын 126 гишүүнтэй 5 намтай энэ хүчирхэг парламент ингээд үг хэлж чадахгүй тойруулаад ингээд бас ярьж байгаад бол харамсах сэтгэл төрж байна.

Хэрвээ Монгол Улс өнөөдөр парламентын засаглалтай хэвээрээ бол ард түмэн сонгуулиар зөвхөн парламентад төрийн эрх барих эрхийг түр хугацаанд шилжүүлж байгаа сонгуулиар, ардчилсан сонгуулиар. Өөр хэнд ч биш. Хэрвээ парламентын засаглалтай бол.

Тийм учраас ард түмний санал өгсөн саналыг хамгаалж байгаа парламентын дархлаа гэдэг бол. Яагаад? Яагаад гэвэл парламент тусгаар тогтнолын асуудлыг, тогтолцооны асуудлыг, засаглалын асуудлыг, уул уурхайн лицензүүдийн асуудлыг шийднэ. Хэнээс ч хамаатай биш хараат бусаар Улсын Их Хурлын гишүүд санал өгөх эрхийг л баталгаажуулж байгаа. Энд одоо өнөөдөр халдаж байгаа ийм ноцтой үйлдэл болж байна аа гэж миний хувьд бол үзэж байна. Өмнө нь байр сууриа илэрхийлсэн.

Тийм учраас өмнө нь судлаачдаа 2019 онд би ч байсан та нар мөнгө өгсөн хүнийхээ л төлөө ярьдаг за юу. Одоо энд орж ирээд Элбэгдорж Ерөнхийлөгчийг алчхаад одоо Хүрэлсүх Ерөнхийлөгчийг алах гээд битгий 2 нүүр гаргаад худлаа яриад суугаад бай за юу. Одоо энэ хуулиа Их Хурлын даргаа яаралтай татаж авах хэрэгтэй. Тэгээд хэрвээ ёс зүй байгаа бол парламент өөрөө яриг л даа. Асуулт гаргах үүднээс нэг зүйл асуучихъя.../минут дуусав./

Ж.Батжаргал: 3 номер ажлын хэсгийн.

А.Үйлстөгөлдөр: Оюун-Эрдэнэ гишүүн маань жоохон бухимдалтай байх шиг байна уу даа. Үгүй ээ та гэнэт сэрсэн юм шиг өнөөдөр парламентын дархлаа гэж ярих эрхгүй ээ.

Ж.Батжаргал: Дэгээ бариад.

А.Үйлстөгөлдөр: Та парламентын дархлаа гэж ярих ёс зүйгүй хүн гэж би бодож байгаа. Та хамтарсан Засгийн газар байгуулаад тэргүүлэхдээ хамтарсан Засгийн газрын нэрийдлээр сөрөг хүчингүй болгож АН-ынхныгаа албан тушаалаар бүтээмжийн менежер гэдэг нэрийдлээр, албан тушаалаар амыг нь таглаж жинхэнэ парламентын дархлаанд халдаж.../үг тасрав./

Ж.Батжаргал: Асуусан асуултад нь хариулья.

А.Үйлстөгөлдөр: Өөрийнхөө эсрэг дуугарсан Их Хурлын гишүүн Лодойсамбуу, өөр бусад гишүүд байна Баярмаа, Анар, Энхтүвшин гээд эдгээр гишүүдийг та хар бэхийн хонгилоороо бол явуулсан гэдгийг би хэлээгүй энэ гишүүд чинь өөрсдөө хэлсэн шүү. Зөвхөн үг, үзэл бодлоо илэрхийлснийхээ төлөө.../үг тасрав./

Ж.Батжаргал: Үйлстөгөлдөр.

А.Үйлстөгөлдөр: Гэтэл та өнөөдөр.../үг тасрав./

Ж.Батжаргал: Асуусан асуултынхаа агуулгаар хариулна. Дэгээ барина. Оюун-Эрдэнэ гишүүн нэмээд тодруулах уу?

Л.Оюун-Эрдэнэ: Яг энэ дээр одоо ёс зүй гэдэг асуудал хөндөгдөнө өө. Ерөнхийлөгчид таалагдсан бол ёс зүйтэй, Ерөнхийлөгчид таалагдаагүй бол ёс зүйгүй гэдэг асуудал яваандаа үүсэх нь ээ. Субъектив. Энэ бол өөрөө юу вэ гэхлээр энэ хууль батлагдах туйлын эрсдэлтэй гэдгийг харуулж байгаа маш тод жишээг сая Үйлстөгөлдөр дарга өөрөө гаргалаа. Энэ таны өөрийн чинь үзэмж болохоос биш энэ шүүхийн эцсийн шийдвэр биш ээ тийм ээ? Энэнээс авхуулаад наад маргаан чинь их болно.

Дээрээс нь нөгөө карма хаалга андуурахгүй гэдэг шиг юм болно оо. Наадах чинь ингээд явж байгаад юм эргэнэ. Одоо жишээлбэл Хэрлэн гишүүн хэрвээ Энхбаяр дарга өнөөдөр шүүх дээр байж байсан бол та өнөөдөр яг ийм юм ярихгүй. Энэ хуулийг яагаад ч баталж болохгүй гээд сууж байгаа. Гэтэл өнөөдөр яаж ийж байгаад баталъя гээд сууж байна. Тийм учраас хэдүүлээ ситуацаар биш объектив харах ёс.../минут дуусав./

Ж.Батжаргал: Баасанжаргал гишүүн асуулт асууя.

Х.Баасанжаргал: Би нэг хэдэн юм асуугаадахъя. Хэдэн юм асуухаасаа өмнө бас хуулийн төсөл танилцуулж орж ирж байгаа 5 хүний бүрэлдэхүүнтэй сууж байгаа юм байна. Тэгээд дунд нь сууж байгаа 3 хүнээс нь та 3 ямар нэгэн байдлаар улс төрийн намын тэр дундаа манай МАН-ын улс төрийн албан тушаал хашиж байгаа юу гэдэг асуулт. 2 захын хүн нь яагаад вэ гэвэл хоёулаа төрийн тусгай албан хаагч байгаа учраас би энэ асуултыг асуух нь зохисгүй гэж бодож байна. Нэг. Тэр асуултад хариулаарай гэж хүсэх гээд байгаа юм.

Хоёрдугаарт гэвэл Ерөнхийлөгч ингэж хууль тогтоох байгууллагын гишүүнийг эргүүлэн татах асуудлаар ингэж санал гаргах ийм хуулийн төсөл санаачилж байгаа нь эрх мэдлийн хуваарилалтын зарчимд харшлахгүй юу? Би ойлголоо тэр Үндсэн хууль дээр ингээд заачихсан, Ерөнхийлөгчийн хууль дээр ингээд заачихсан гэдгийг бол хуулийн заалтуудыг ойлголоо.

Гэхдээ энэ нь Ерөнхийлөгчид хил хязгааргүй, хамаа замбараагүй, бүх хуулийг санаачил гэсэн үг биш гэдгийг та бүхэн маш сайн мэдэж байгаа. Бүгдээрээ мэдэж байгаа эрх мэдлийн хяналт, тэнцэл гэдэг дотроо байх ёстой гэдгийг бүгдээрээ мэдэж байгаа. Тэгэхээр яг энэ эрх мэдлийн хуваарилалтын зарчимд харшлахгүй юу гэдэг асуултад маш тодорхой хариулаад өгөөч ээ гэсэн үг.

Хоёрдугаарт, энэ хуулийн төсөл нь бодитоор ёс зүйг сайжруулах уу, эсвэл улс төрийн өрсөлдөгчөө шахах зэвсэг хэрэгсэл болох уу? Болохгүй гэвэл яг энэ

дээр та нар өөрсдөө баталгаа өгч чадах уу? Ялангуяа энэ удаагийн парламентад 5 улс төрийн намын төлөөлөл оролцсон. Бид нар энэ парламентыг ийм багтаамжийг нь томруулах гэж оролдсон ийм яг Үндсэн хуулийн өөрчлөлт гэдгийг бас та бүхэн маш сайн мэдэж байгаа. Энэ нь эргээд жижиг, бусад улс төрийн намуудыг дөнгөж бойжиж байгаа, дөнгөж парламентад орж ирж байгаа энэ улс төрийн намуудыг яг улс төрийн арга хэрэгсэл болгоод эргээд буцааж тараагаад зөвхөн томоохон улс төрийн намуудын өөрсдийнх нь үзэмжээр явдаг ийм улс төрийн хүчин болгож энэ олон намын тогтолцоонд чинь сөргөөр нөлөөлөхгүй юу? Энийг юу гэж харж байгаа вэ?

Дараачийнх нь ёс зүйн хариуцлагыг парламентад өөрт нь бий болгох боломжийг яагаад парламентад өөрт нь олгохгүй Ерөнхийлөгчийн энэ эрхийг эдлээд байгаа вэ? Үүнтэй холбоотой нэг асуудал гарч ирнэ. Үндсэн хуулийн эрх зүй талаасаа Ерөнхийлөгч үндсэн 3 чиг үүргийг хэрэгжүүлдэг гэж үзэж байгаа. Баталгааны чиг үүргийг хэрэгжүүлдэг, зохицуулагчийн чиг үүргийг хэрэгжүүлдэг, хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Энэ 3-ынхаа алиных нь хүрээнд энэ хуулийн төслийг санаачлаад байгаа вэ гэсэн ийм асуулт.

Ж.Батжаргал: Хариулъя. Ажлын хэсгийн 2 номер.

А.Бямбажаргал: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Та үндсэндээ 4 асуудал, асуулт тавилаа.

Монгол Улсын Үндсэн хуулиа барьж бид нар одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжоо баривал жижиг нам, том нам гэдэг ойлголт лав хууль зүйн хувьд байхгүй. Та жижиг нам гэж хөндлөө. Улсын Их Хуралд суудал бүхий нам, суудал бүхий биш нам л гэдэг 2 ойлголт байгаа юм. Монгол Улсын Үндсэн хуулиар шүү.

Хоёрдугаарт, эрх мэдлийн хувьд энэ чинь харин Монгол Улсын Үндсэн хуульдаа хэрвээ оруулбал зөвхөн Ерөнхийлөгч энэ хуулийг санаачилна. Их Хурлын гишүүн санаачлах эрх байхгүй. Яагаад гэвэл Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын хуулиар хязгаарлагдчихсан, Засгийн газар хязгаарлагдчихсан. 26 дугаар зүйлд байж байгаа хууль санаачлах эрх одоо хүртэл хүчин төгөлдөр байгаа гэж бид нар харж байгаа Ерөнхийлөгчийн хувьд. Үндсэн хуулиа өөрчилчхөөгүй бол. Өөрчилчихвөл тэр бол болно. Мэдээж хэрэг.

Гуравдугаарт, парламентад харин энэ эрхийг нь үлдээж байгаа юм. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Ерөнхийлөгч өнгөрсөн хугацаанд 2021 оноос хойш та хэдэн хуулийн төсөл санаачилсан бэ та нэг хараад үзээрэй. Би хуулийн зөвлөхийн хувьд ч тэр ажиллаж байхад хууль санаачлах энэ ёс зүйн хувьд хязгаарлалт, хуулиар бол хязгаарлалт байхгүй. Бид нар хийх гэж үзсэн. Гэхдээ бүүр хязгааргүй нээчихсэн байгаа. Би түрүүн бас уншиж өгсөн. Хаалт бол, хязгаарлалт бол байхгүй байгаа юм байна лээ шүү. Энийг Их Хурал маань өөрсдөө бас анзаарч шийдэх ёстой байх. Яаж шийдэх бол Их Хурлын өөрийн эрхийн асуудал. Ерөнхийлөгчийн хуулиар бас нээлттэй хууль санаачлах эрх. Энийг Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөргөх журмын хуулиар энэ эрхийг санаачлах эрхийг зөвхөн үүргийг буюу эрхийг хэнд өгсөн бэ гэхээр Засгийн газарт өгсөн. Засгийн газарт өгсөн. Ерөнхийлөгч өөрөө санаачлахгүй.

Дөрөвдүгээрт, та бас хэллээ ёс зүй энэ хянах энэ эрх рүү халдаад байгаа юу. Үгүй ээ харин эсрэгээрээ энэ эрхийг нь Их Хурал маань өөрсдөө тогтоогооч ээ гэж байгаа юм. Ёс зүйн дүрмээ шинэчил ээ. Тэгэхдээ хууль байх уу, дүрэм байх уу? Та бүхний онцгой бүрэн эрхийн асуудал. Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийн асуудал. Онцгой бүрэн эрхийн асуудал.

Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах гэдэг нэр томъёо 92 онд ч байсан. 19 онд тодруулсан. Тодруулахдаа Цэц рүү хандах. Гэхдээ би түрүүн бас яриан дээр дурдагдсан. 92 оноос хойш энэ 7 тохиолдолд Төрмандах гишүүнээс өгсүүлээд Нямдорж гишүүнийг хүртэлх энэ асуудал болгон өөрөө дандаа иргэний мэдээллээр шүү. Одоо ч нээлттэй. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх хууль, Цэцийн хуулиудаар эдгээр маань нээлттэй байж байгаа юм. Хэн хүссэн иргэн хандаж болно шүү.

Ж.Батжаргал: 3 номер асуулт дутуу байна. Хариулт дутуу байна гээд байна.

А.Үйлстөгөлдөр: Та асуултаа тодруул даа.

Ж.Батжаргал: Баасанжаргал гишүүний микрофоныг өгөөрэй.

Х.Баасанжаргал: Улс төрийн намын гишүүнчлэлтэй юү, улс төрийн намын удирдах зөвлөл болон бусад төрлийн албан тушаал улс төрийн намд хашдаг уу МАН-д?

Ж.Батжаргал: Хариульъя 3 номер.

А.Үйлстөгөлдөр: Улс төрийн намын харьяалалд хамаардаг. Удирдах зөвлөлийн гишүүн. Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдэлж байгаа хүн. Баярлалаа.

Ж.Батжаргал: Ажлын хэсгийн 4.

Т.Энхтүвшин: Монгол Улсын Ерөнхийлөгчийн орон нутаг хариуцсан зөвлөх бол улс төрийн албан тушаалтан байдаг. Намын харьяалалтай Үндсэн хуульд заасан. Дээр нь одоо Бага хурлын гишүүнээр ажиллаж байгаа.

Ж.Батжаргал: Ажлын хэсгийн 5.

Ж.Мөнхболд: Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга Мөнхболд. Ямар нэгэн улс төрийн намын гишүүнчлэл байхгүй ээ.

Ж.Батжаргал: Баасанжаргал гишүүн тодруульъя.

Х.Баасанжаргал: Би тодруульъя. Би яагаад энэ асуултыг асуусан бэ гэвэл Ерөнхийлөгч улс төрийн намын харьяаллаасаа түдгэлзэх ёстой байдаг. Үнэн хэрэгтээ өөрөө түдгэлзсэн боловч баг нь тэр чигээрээ улс төрийн намын албан тушаал, улс төрийн намын гишүүнчлэлтэй байгааг бүгдээрээ харж байгаа. Харж байгаа боловч хараагүй юм шиг байсан учраас би өнөөдөр энийг зориуд микрофон дээр асууж байгаа юм. Бид нар ингэж дандаа бие биеийгээ хуурдаг шүү дээ. Ингэж нүглийн нүдийг гурилаар хуурч явдаг шүү дээ.

Тэгчхээд одоо ингээд ийм хууль оруулж ирчхээд энийгээ Их Хурал өөрөө л мэднэ биз гээд. Хэрвээ Их Хурал өөрөө мэднэ гэж байгаа бол тэгвэл та нар энэ хуулиа татаад авчих. Бид нар өөрсдөө мэдье. Нэг. Би байр сууриа илэрхийлж байна. Хүлээж байгаарай.

Хоёрдугаарт, асуултад маш тодорхой хариул. Яг өөдөөс хичээл заагаад, би таны зааж байгаа хичээлүүдэд би зөндөө сууж байсан би мэдэж байна. Гэхдээ хэдийгээр Үндсэн хуульд тэгж эрх хэмжээг нь тодорхойгүйгээр Ерөнхийлөгчид бүх төрлийн хуулийг санаачлахаар оруулж байгаа гэдэг нь, байгаа гэдэг нь өөрөө бүх хуулийг санаачилж болно оо гэсэн үг биш гэдгийг та өөрөө маш сайн мэдэж байгаа шүү дээ багш байж байж.

Ж.Батжаргал: Ажлын хэсгийн 2 номер.

А.Бямбажаргал: Баярлалаа. Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Та асуусан учраас л би одоо хариулж байгаа шүү дээ чадах чинээгээрээ. Би ажлаа хийж байгаагийнхаа төлөө, ажлын хэсгийн гишүүнээр орж ажиллаж байгаагийнхаа төлөө ямар нэг байдлаар субъектив би өөрийгөө хамгаалж юм хэлж чадахгүй. Татаж авах эсэх асуудал бол зөвхөн Ерөнхийлөгчийн онцгой бүрэн эрхийн асуудал хууль санаачлагчийн. Хууль санаачлагчийн. Түүнээс энийг хэн нэгэн эдлэхгүй шүү дээ. Энд ажлын хэсэгт орж ирээд суусан би тухайлбал эдлэхгүй энэ эрхийг. Монгол Улсын Үндсэн хуулийн дэг журмын дагуу байгаа зүйлийг байгаагаар нь л би хэлж байна. Зөвхөн өнөөдөр хэлээгүй ээ, 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээн дэх протоколуудаа би бас бүгдийг нь эргэж үзлээ. Яг энэ хэд зөвлөөд би хэлж байсан юм байна лээ яагаад ч юм. Өнөөдөр би яг тэрийгээ л хэлж байна танд. Баярлалаа танд.

Ж.Батжаргал: Баасанжаргал гишүүн тодруулъя.

Х.Баасанжаргал: Би асуултаа өшөө тодорхой асуугаадахъя. Ерөнхийлөгчийн хууль санаачлах эрх нь ямарваа нэгэн хязгаарлалт байхгүй гэж Үндсэн хууль дээр заасан гэж та үзэж байгаа юм бол, гэж үзэж байгаа юм бол уг нь бол бид нар Монгол Улсын Их Хурал, Дэгийн тухай хуулиараа Ерөнхийлөгчийн хууль санаачлах эрхийг буюу тэр дундаа Их Хурлын тухай хууль, Их Хурлын дэгийн тухай хуулийг хэн санаачлах вэ гэдгийг нь уг нь заачихсан. Гэхдээ та нар энийг Үндсэн хууль зөрчсөн хуулийн заалт аа гэж үзэж байгаа бололтой. Тийм учраас Ерөнхийлөгч энэ хуулийг санаачлах бүрэн эрхтэй гэж үзэж байгаа бололтой. Тийм гэж үзье. Энэ нь өөрөө парламент, гүйцэтгэх засаглал, энэ эрх мэдлийн хяналт, тэнцэлд ямарваа нэгэн сөрөг нөлөө авчрах уу, үүнээс яаж хамгаалах вэ? Ямар нэгэн сөрөг нөлөө авчрах уу, энэ чинь сөргөөр нөлөөлөх үү л гэж асуугаад байна.

Хоёрт, би түрүүний асуултдаа хариултаа авсангүй. Ерөнхийлөгчийн 3 чиг үүрэг байгаа юм. Энэ 3 чиг үүргийн алинд нь хамаарах юм гэж үзэж энэ хуулийг санаачилж байгаа юм? Хяналтын чиг үүрэг юм уу, зохицуулах юм уу?

Ж.Батжаргал: Ажлын хэсгийн 2 номер.

А.Бямбажаргал: Баасанжаргал гишүүний дэд асуултад хариулъя. Монгол Улсын Үндсэн хуулийн би тодорхой заалтыг л одоо танд уншиж өгөх болох гээд байна л даа. Тэр нь юу вэ гэхээр Монгол Улсын Ерөнхийлөгч хууль санаачлах эрх бүхий субъектийн нэг байгаа. Энийг хуулийн хүрээ, хязгаарыг хуулиар тогтооно

гэж заасан. Тогтоож байгаа хууль тогтоомжийг нь та бас нэг эргээд заавал та надаас асуухгүй мэдэж байгаа байх. Энийг засах эрх бол танд байж байгаа.

Хоёрдугаарт, та бас түрүүн хэллээ Ерөнхийлөгчийн аль чиг үүрэг гэж? Энэ шинжлэх ухааны л нэр томьёо, ойлголт. Тэгэхээр би тэгээд тайлбарлачихаар одоо бас хичээл заасан болчих болов уу, яах бол? Энэ шинжлэх ухааны нэр томьёо. Би тайлбарлаж өгч болно оо. Энийг бол шинжлэх ухааны үүднээс л тайлбарлачихаар одоо хичээл заасан болчих гээд байх шиг байна. Гуравдугаарт.

Ж.Батжаргал: Баярлалаа. Номинчимэг гишүүн асуулт асууя.

О.Номинчимэг: Би яах вэ энэ хуулийн талаар ер нь нөгөө Улсын Их Хурал өөрөө хариуцлагатай байх ёстой, хариуцлага тооцдог механизм байх ёстой гэдэг шаардлага байгааг ойлгож байгаа. Байх ч ёстой. 30 хэдэн жил бид нар мөрдөж ирсэн Үндсэн хуульдаа Улсын Их Хурал өөрөө үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж чадахгүй, ажиллаж чадахгүй байх юм бол ямар механизмаар хариуцлага тооцдог байх юм бэ гэдгээр манай Үндсэн хууль угаасаа сул. Тэгээд энэ бол энэ 126-тай парламентын үед ч одоо ингээд ёс зүй, янз бүрийн асуудал болчихоод хариуцлага тооц гэдэг асуудал гараад байгаа гэхээсээ илүү энэ 30 жилийн хугацааны бугшил гэж бодож байгаа. Өмнөх парламентад Улсын Их Хурлын гишүүд хариуцлагагүй ажиллаж байсан учраас энэ олон юм чинь иргэдийн бухимдлыг төрүүлээд иргэд ч гэсэн ийм шаардлагыг тавиад байгаа гэж бодож байгаа.

Тэгээд та бүхний оруулж ирсэн энэ хуулийг харсан. Хэрэгцээ, шаардлага байгаа дээр та бүхэн Улсын Их Хурлын гишүүдийг тэгвэл ийм 4 одоо ийм шалгуураар, 4 өөр ийм шалгуураар татдаг болъё оо гэдэг энэ хуулийн төслийг оруулж ирж байгаа юм. Энэ 4 шалгуурыг чинь 2 нь бол маш тодорхой. Маш объективний хэн ч харсан маргахгүй, энэ бол ойлгомжтой. Энэ бол тэр хуралдаандаа суудаггүй байх, биеэрээ санал өгдөггүй байх. Энэ бол Улсын Их Хурлын гишүүн ард түмнийг төлөөлөөд энд сонгогдсон бол хуралдаанд орж, санал өгч, хэлэлцэж энийгээ төлөөлөх эрх, үүрэгтэй.

Манай одоо чуулганд чинь хэзээ ч ирдэггүй, манай Өргөдлийн байнгын хороонд гишүүн мөртөө хэзээ ч ирж байгаагүй гишүүн байгаа. Би бол энэ хүмүүсийг Улсын Их Хурлын гишүүнийхээ үндсэн үүргийг гүйцэтгэж чадахгүй байгаа гэж харж байгаа. Энэ хүмүүст хариуцлага тооцох механизм байх ёстой. Би энэ объектын энэ 2 шалгуур дээр бол юм хэлэхгүй. Энэ байх ёстой гэж үзэж байгаа.

Нөгөө 2 буюу өнөөдрийн хамгийн их сэдэв болоод байгаа 2 шалгуур байна. Нэг нь тангаргаасаа няцсан, нөгөөх нь ёс зүйн ноцтой зөрчил гэсэн энэ 2 шалгуур чинь ерөөсөө маш тодорхой бол биш, маш субъективийн байдалтай байгаад байгаа байхгүй юу.

Нэгдүгээрх нь тангаргаасаа няцсан гэж байгаа юм. Улсын Их Хурлын гишүүний тангаргийг та бүхэн мэднэ ээ. Яг тангаргийнхаа аль хэсгээс нь няцсан гэдгийг нь тэгвэл Цэц тогтоох гээд юм уу? Энэ дээр Цэц дээр тангаргаасаа харах юм бол ашиг сонирхлоос ангид байж, байна аа гэдэг асуудал. Энэ ашиг сонирхолд үнэхээр автсан бол энэ чинь Эрүүгийн хуультай гэмт хэрэг болно. Үүгээрээ тогтоогдоод ороод ирнэ. Тэгэхээр энэ тангаргийнхаа хувьд юу гэх юм одоо чи гишүүний үүргээ чин шударгаар биелүүлээгүй гэдгийг яагаад шүүх шийдэхгүй заавал Цэцээр шийдүүлэх гээд байгаа юм? Энэ дээр нэг асуулт авъя.

Хоёрдугаарт, ёс зүйн асуудал байна. Ёс зүйг байна шүү дээ. Түрүүнээс хойш ёс зүйг хуульчилж болно оо, хуульчилдаг юм аа гээд байх юм. Ёс зүйг бүрэн хуульчилдаггүй байхгүй юу. Ёс зүйг бүрэн хуульчилдаггүй болохоор зарим нь хуульчлагдаад эрүү, хуулиараа болоод явна. Зарим нь бол нийгмийн софт хэм хэмжээ хэвээрээ байна. Тэгээд ийм нийгмийн софт хэм хэмжээг та нар хуулийн хариуцлага болгох үндэслэл болгоод ороод ирж байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг чинь буруугаар ашиглах, улс төрийн сэдлээ.../минут дуусав./

Ж.Батжаргал: Хариулъя. Ажлын хэсгийн 2 номер.

А.Бямбажаргал: Номинчимэг гишүүний асуултад хариулъя. Бид нар хууль санаачлаагүй ээ. Би, таны ярианд нэлээн олон дурдагдсан учраас та нар гэж. Би хууль санаачлагчид уламжилъя аа. Та нар. Энийг бол Ерөнхийлөгч санаачилж байгаа юм аа. Энэ дээр бас бид бүхэн бас анзаарахгүй бол болохгүй байх. Заналхийлээгүй ээ. Энэ бол хуульч би хүнтэй хууль зүйн хэлээр ярьж байгаа юм.

Хоёрдугаарт, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хүчин төгөлдөр шийдвэрүүд байна. Тухайлбал, 1994 оны 2 сарын шийдвэр байна. 04 дүгээр дүгнэлт. Няцсан эсэхийг шийдсэн байна аа тангаргаасаа. Би нөгөө 92 оны Үндсэн хуульд байсан шүү гээд байгаа нь энэ юм л даа уг нь. Хэн нэгэн өнөөдөр няцсан эсэхийг тогтоох тухай яриагүй шүү дээ энэ чинь. Одоогоос 22 жилийн өмнө Үндсэн хуулийн цэц маань тухайлбал Улсын Их Хурлын зарим гишүүд няцсан уу үгүй юу гэдгийг тогтоож байжээ. Одоо ч тогтоох боломжтой. 19 оны өөрчлөлтөөр энийг нь тогтоогоод няцсан гэдэг нь тогтоогдчих юм бол эгүүлэн татна гээд нөгөө императив хэм хэмжээ биччихсэн. Императив хэм хэмжээ биччихсэн. Энийг л хэлээд яриад байгаа юм. Түүнээс биш Үндсэн хуульд байхгүй юм зохиож яриагүй шүү дээ энэ чинь. Үндсэн хуулийн дэг журамд байхгүй зүйлийг бол бас санаачилж болохгүй. Баярлалаа.

Ёс зүйн гэдэг бол одоо ч гэсэн бас хүчин төгөлдөр үйлчилж байна аа. Ёс зүйн дүрэм гэж би хэлээд байгаа. Энэ чинь одоо би хууль тогтоомжийн нэг хэсэг гэж ойлгоод байгаа шүү дээ Улсын Их Хурлын тогтоолоор батлагдсан. Та бүхэн дагаж мөрдөж байгаа. Дагаж энэ хуулийн төсөлтэй холбоотойгоор “Хууль батлагдсантай холбогдох арга хэмжээний тухай” тогтоолын төсөлд ёс зүйн дүрмийг шинэчилж батал гэдэг агуулгаар оруулсан. Эндээ тухайлбал алиныг нь няцсан, ёс зүйн зөрчил нь ноцтой гэдэгт нь оруулах юм, алийг нь удаа дараа гэдэгт нь оруулах юм гэдгийг Их Хурал маань өөрсдөө хэлэлцэж тогтоох бүрэн эрхтэй. Энэ бол өөрөө Их Хурлын онцгой бүрэн эрх учраас энэ хүрээнд нь үлдээж санаачилсан гэж ингэж ойлгож байгаа.

Ж.Батжаргал: Номинчимэг гишүүн тодруулъя.

О.Номинчимэг: Бямбажаргал дарга аа та надад их тийм юм заах гээд байх хэрэггүй. Би Үндсэн хуулийн хүрээнд л асууж байгаа юм. Тангаргаасаа няцчихсан байгаа Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтүүдтэй ч танилцсан. Тэгээд Үндсэн хууль зөрчинө гэдэг чинь аягүй ерөнхий үг байхгүй юу. Үндсэн хууль зөрчинө гэдгийг бид нар Үндсэн хууль зөрчсөн хууль гаргаж байгаа юм бол 126 бүгдээрээ тэгвэл хариуцлага хүлээх юм уу гэх мэтчилэн. Энийг энэ чинь нарийвчилж та нар хууль санаачлагчийн зүгээс ямар үзэл санаагаар энийг оруулж ирсэн юм бэ, тангаргаасаа няцна гэдгийг юу гэж ойлгож орж ирсэн юм бэ гэдэг юмыг бид нар үзэл санааг нь бид нар асуугаад байхаар урдаас нэг юм яриад байх юм.

Хоёрдугаарт байна шүү дээ энэ ёс зүй гэдэг асуудал байна аа. Дүрмээрээ гээд байх юм. Би хар даа Олон улсын парламентын холбоодын Парламентчдын хүний эрхийн хорооны ерөнхийлөгчөөр нь ажиллаж байгаа юм. Яг энэ асуудал дээр явдаг байхгүй юу. Тэгээд энэ улсуудын асуудлуудыг бид нар бусад олон улсын юмыг үзэхээр ёс зүйгээр хуульчилж болохгүй, ёс зүйгээр хуулийн хариуцлага хүлээдэг механизм алга аа. Ялангуяа гишүүнийг татдаг юм алга. Сахилгын хариуцлагаа хүлээлгэ болно. Цалинг нь багасга яадаг юм.../минут дуусав./

Ж.Батжаргал: Хариулъя. Ажлын хэсгийн 2.

А.Бямбажаргал: Баярлалаа Номинчимэг гишүүнд. Монгол Улсын Үндсэн хуулийг би ахиад л дахиад л нөгөө Үндсэн хуулиа л би танд танд хэлэх гээд байгаа юм. Дэлхийн бусад улсын Үндсэн хуулиас Улсын Их Хурлын гишүүнийг нь одоо Монгол Улсад үйлчилж байгаа шиг эгүүлэн татдаг улс та нэгийг ч олохгүй ээ. Харьцуулах боломжгүй ээ. Энэ Монгол Улсын Үндсэн хуулийн дэг журам байхгүй юу. Монгол Улсад импичмент гэдэг ойлголт бас байхгүй хуулиар. Цэц юуг нь тогтоодог юм бэ гэхээр Үндсэн хууль зөрчсөн эсэх, тангаргаасаа няцсан эсэхийг тогтоо гээд бид нар 19 онд ийм гипотиз биччихсэн. Монгол Улсын Их Хурал энийг нь баталчихсан.

Харин энэ нь өөрөө чухам юу байх юм бэ гэдэг нь Цэцийн практик бас зарим нэгд нь байна. Цаашид энийг хуулиар нарийвчлан зохицуулах хэрэгцээ, шаардлага гарахыг үгүйсгэхгүй. Энийг Их Хурлын онцгой бүрэн эрхийн хүрээнд тогтооно. Хууль санаачлах санаачлагчийн хувьд.../минут дуусав./

Ж.Батжаргал: Номинчимэг гишүүн тодруулъя.

О.Номинчимэг: Тэгээд энэ нөгөө тодорхой юм, тодорхой үзэл санаатай тэрийгээ шалгуур болж явахгүй бол хар даа ингээд ийм юм байгаа, Үндсэн хууль дээрээ байгаа юм, хамгийн онцлог юм аа гэх юм бол бид нар одоо тэрийгээ тодорхойлохгүйгээр бусад улсад байхгүй юм чинь энийг бид нар тодорхойлох юу гэдэг юм боломжгүй гээд хаячхаж болохгүй шүү дээ. Тэгээд ийм субъектив байдлаар тэгвэл тодорхойгүй юмыг тайлбарлах боломжтой юмаар бид нар хуулийн ийм чухал одоо шаардлага, хариуцлага хүлээх юм ороод ирэх юм бол энэ чинь цаашдаа та хэдийн санаа зөв боловч өөр хүн гарч ирээд буруугаар ашиглах үүд, амыг нээдэг гэдгийг бол та бүхэн бас биднээр заалтгүй мэдэж байгаа байх тээ? Тэн дээр чинь л санаа зовоод асуугаад та нар ямар үзэл санаагаар, ямар цар хүрээгээр бодож орж ирсэн юм гэдэг асуултыг асуухаар би бол бас тодорхой ингээд хариулт авч чадахгүй л байна. Тэгээд өнөөдөр ингээд хэлэлцэх эсэхээ Байнгын хороон дээр чинь, дахиад чуулган явна. Энэ асуудлаараа та бүхэн ч гэсэн бэлтгэлтэй орж ирэхгүй бол надад бол маш тодорхойгүй л санагдаад байна.

Ж.Батжаргал: Хариулъя. Ажлын хэсгийн 2.

А.Бямбажаргал: Номинчимэг гишүүнд баярлалаа. Хууль тодорхой байх бол өөрөө эрх зүйт төрийн бас гол зарчмын нэг ээ. Тангаргаасаа няцсан гэдэг энэ гипотез нь юу байх юм гэдэг нь өөрөө цаашид Улсын Их Хурлын хууль, Дэгийн хууль, дүрмээр илүү зохицуулагдах харилцаатай юм байна лээ. Энэ дээр бол Монгол Улсын Ерөнхийлөгчийн хууль санаачлах хүрээ, хязгаар нь үүгээр хязгаарлагдаж байгаа гэдэг үүднээс бас зохицуулахгүй байгаа.

Гэхдээ объектив юм бичиж байгаа. Тэр нь юу вэ гэхээр тухайлбал, тангаргаасаа няцсан эсэх асуудлаар шалгуулахаар хандаж болно оо. Төлөөлөх чиг үүргээ хэрэгжүүлсэн эсэх асуудлаар хандаж болно оо. Хууль тогтоох чиг үүргээ хэрэгжүүлэх асуудлаар хандаж болно оо. Мөн ёс зүйн ноцтой зөрчил болон удаа дараа зөрчил гаргасан эсэх асуудлаар хандаж болно оо.

Ж.Батжаргал: Баярлалаа. Хууль санаачлагчийн илтгэл, төслийн үзэл баримтлалтай холбогдуулж гишүүд асуулт асууж дууслаа.

Одоо хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр суурь илэрхийлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Оюун-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Золжаргал гишүүнийг оруулаарай. Өөр орхигдсон гишүүн байна уу?

Алга байна. Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Муу муудаа дээрэлхүү гэдэг шиг л ер нь нэг ийм л байдалтай байна. Хуулийн төсөл дээр гарцаагүй жагсаалтын гишүүдийг бүүр хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар буюу жагсаалтаар гээд зүйл, заалттай асуудлыг олон ч гишүүн ярилаа. Ариунзаяа гуай хуулиа унш аа гэсэн хэсгээ л тэгээд л таслаад л баахан одоо сошиалаар сэвээд л явж л байна л даа. Жагсаалтын гишүүдийг та хоёр ч гэсэн хэвлэлийн хурал хийхдээ 3 сарын 1-ний өдөр жагсаалтын гишүүд, ёс зүйгүй гээд л зөндөө л жагсаалт руу л дайрч ярьсан шүү дээ. Худлаа биш ухраагаад харахгүй юу. Би худлаа яриад байгаа юм уу? Хуулиа уншаагүй би юм байна л д аа сошиалаар. Энэ асуудал чинь цаг үе нь биш байна аа. Хэдийгээр намын мөрийн хөтөлбөр дээр гишүүний ёс зүйн хариуцлага зөв боловчиг яг цаг үе нь бол бүүр шал өөр утга агуулгаар яваад байгаа нь бол хэн болгонд ойлгомжтой байгаад байна шүү дээ. Үнэхээрийн гишүүд ёс зүйтэй байх ёстой юу? Байх ёстой. Бид нар ёс зүйн дүрэмтэй юу? Дүрэмтэй. Энэ хууль гарч байж ёс зүйн дүрмээ шинэчлэх асуудал бас биш шүү дээ. Энэ хууль байхгүй болоод бид нар ёс зүйн дүрмээ шинэчлэхгүй суугаад байгаа юм уу? Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын тухай хуулийн би дүрэм яриагүй шүү. Би хууль ярьж байна 44.1.11 бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Байнгын, дэд, хянан шалгах түр хорооны болон нэгдсэн хуралдаанд, эсвэл хуралдаанаас гадуур бусдыг гүтгэж доромжлох нь Улсын Их Хурлын гишүүнд хориотой. Хориглох үйл ажиллагаанд хуульчлаад өгчихсөн байгаа.

41.2 гишүүн бусдыг гэмт хэрэгт холбогдуулан доромжлох, гүтгэхээс бусад тохиолдолд бүрэн эрхийнхээ хүрээнд хэлсэн үгийнхээ төлөө хуулийн хариуцлага хүлээхгүй гээд байгаа шүү дээ. Хуульчилсан байгаа. Тэгээд яагаад хоёрхон эмэгтэй дээр дөрөөлөөд хуулийн заалт байсаар байтал нийгэмд баахан давлагаа явуулчхаад тэгээд ийм асуудал оруулж ирж байгаа юм? Хуулиар гарцаагүй байгаа. Энийг Ёс зүйн дэд хороо ёс зүйгээр шийддэг асуудал биш. Гишүүд хэн нэгнийг гүтгэх, доромжлох хуулиар хориотой. Ойлгож байна уу? Гэтэл Хууль зүйн сайдаар ажиллаж байсан хүн одоо Хэрэг эрхлэхийн сайдаар ажиллаж байгаа хүн юу гүтгэх, доромжлох бүүр хүн алаад чандарсан гээд хэлээд зүв зүгээр одоо сайдаа хийгээд явж байгаа шүү дээ. Өөрсдөө ямар үлгэр дуурайлал үзүүлж байгаа юм.

Ирцтэй холбоотой тухайн жилдээ 5-аас дээш хоног буюу 40 цагаас дээш тасалсан бол, ямар нэгэн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тасалсан бол бид нар

хариуцлага тооцох ёстой. 25 оны 1 сарын 1-нээс 25 оны 12 сарын 31-ний хооронд Халтмаагийн Баттулга, Норовын Алтанхуяг, Равжихын Эрдэнэбүрэн, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан 40-өөс дээш цаг тасалсан. Энэ асуудлыг Ёс зүйн дэд хороогоор хамгийн түрүүнд ярих ёстой шүү дээ. Нарагаас өмнө Батсуурийн асуудал ч гэсэн байгаа байхгүй юу.

Яагаад өнөөдөр энэ хууль орж ирж байхад Нарагийн асуудлыг заавал өнөөдөр гэж ярьж байгаа юм. Энэ цаана нь ямар нэгэн зохиолтой байсан уу? Ёс зүйн хороо хүртэл, Ёс зүйн дэд хороо хүртэл өөрөө ийм ялгавартай ханддаг байхгүй юу. Өчигдөрхөн Үндсэн хуулийн өдөртөө буюу Засгийн газрыг огцруулахаар өргөн барьсан байгаа энэ асуудлыг 3 хоногийн дотор хэлэлцэж эхлээд 10 хоногийн дотор шийднэ ээ гэдэг ийм хугацаатай чуулганд оролцоогүй гишүүд одоо эсрэгээрээ чи чуулгандаа оролцоогүй, ёс зүйгүй байна аа гэж ярьж байгаа шүү дээ. Өөрөөсөө нэхээгүй ёс зүйг бусдаас нэхэж болдоггүй байхгүй юу. Тэгээд энэ ёс зүй чинь яг өнөөдөр энэ цаг үед энэ Цэцдээ чинь.../минут дуусав./

Ж.Батжаргал: Болормаа гишүүн саналаа хэлье.

Э.Болормаа: Би энэ хуулийг дэмжихгүй байгаа. Тэгээд бид нар нэг нь хамгаалаад нэг нь одоо нэг дайрч давшлаад тэгээд бүгдээрээ хувийн эрх ашигтай ч юм шиг хүмүүс хэлэлцэж байгаа учир би энэ яг цахим дээр энэ хуулийг ChatGPT рүү оруулж дүгнэлт авсныг зүгээр уншиж өгье гэж бодож байна. Тэгэхгүй бол одоо энд бүгдээрээ нэг хүнээс хичээл заалгаад ч байгаа юм шиг нөгөө хэд нь нөгөө өөрсдийгөө хамгаалаад ч байгаа юм шиг.

Энэ хуулийг хиймэл оюун, одоо бид нар цахимжаад Улсын Их Хурлынхаа үйл ажиллагаандаа бас энэ дүн шинжилгээ хийдэг болсон. Тэгээд манай Монголын нэг хэвлэл мэдээллийн сайт “unnu.news” гээд сайт энийг ChatGPT рүү оруулсан байна аа. Энэ хуулийг хэтэрхий субъектив байна гэсэн байна. Энэ хуулийн эрсдэлийг хэлсэн байна. Эрсдэлийн жишээ нь намын удирдлага өөртэй нь улс төрийн хувьд санал нийлээгүй гишүүнийг ёс зүйн ноцтой зөрчил гаргасан гэх субъектив үндэслэлээр эгүүлэн татах санал гаргаж болзошгүй ээ. Зүгээр ганц л эрсдэл нь шүү. Энэ аягүй олон эрсдэл дунд орсон байгаа.

Тэгээд би өнөөдөр энийг магадгүй үзэж байгаа залуучууддаа хэлэхэд бид нар эрх чөлөө, үг бодлоо илэрхийлэх эрх, парламентын ардчиллаа хамгаалахын төлөө бас үүнийг эсэргүүцэж байгаа шүү гэдгийг бас онцолж хэлээд цаг зав гаргаад цаадах чинь бид нар энийг ороод харчхаарай, “claude” байна уу, “gemini” байна уу яг л бодит олон улсын энэ хүн маань одоо олон улстай нэг ч жишээ харьцуулж болохгүй гэж хэлээд байна л даа. Гэхдээ энийг олон талаас нь дүн шинжилгээ хийгээд хараарай гэж хүсэж байна.

Бид нар өнөөдрийн жишээгээрээ ярих юм бол сая Ариунзаяа гишүүн хэлж байна л даа хүн угаасаа субъектив байх эрсдэлтэй. Бид нар байнга энийг өөрсөд дээрээ бодох ёстой. Би хэтэрхий субъектив хандаад байна уу, энэ асуулт асуудалд объектив хандаж байна уу? Сая Лодойсамбуу гишүүн хэлсэн бид нарын дараа гишүүд байна шүү дээ бид нар энэ дараа дараагийн парламентаа хамгаалах ёстой. Тэрнээс биш бид нар өөрсдөө дараа нь энд суух уу огт хамаагүй. Яах вэ та хэдийн дургүйг хүрээд та хэд маань очоод буудчих уу Жанжин гээд юу гэж хэлэх нь нэг их тийм падлигүй байхгүй юу. Дараа дараагийн магадгүй Үйлстөгөлдөр дарга та нэг өдөр жагсаалтаар гишүүн болоод орж ирээд сууж байвал би таны эрхийг хамгаалах талаар яриад энийг эсэргүүцэж байгаа юм шүү. Энийг

ойлгоорой. Дараа дараагийн аль ч намын залуу гишүүд хэн ч байсан өөрсдийнхөө дуу хоолойгоо яг хүргэдэг байгаасай. Энэ парламент 5 намын төлөөлөлтэй энэ бол бид нарын үүрэг юм шүү.

Нийгэмд бид нараас хүмүүс зүй ёсны ёс зүй шаардаж байгаа. Тэрэнтэй бол санал нэг байгаа. Гэхдээ шийдэл нь бол огт энэ хууль биш. Өнөөдөр бид нар Нара гишүүний асуудлыг яриад л ёс зүй шаардаад л ямар аймаар дайралт зохион байгуулалттай хийдэг юм бэ? Миний мэдэх ёс зүйгээр нялх биетэй ээж рүү ингэж дайрна гэдэг бол Монгол ёс зүйд байхгүй шүү. Энэ үйлийн үр өөрөө хаалга андуурахгүй очих хүндээ очих байх аа. Тэгэхээр бүгдээрээ өөр өөрсдөө бас дүгнэлт хийе ээ. Тэгээд энэ сошиалыг удирдаж байгаа, түүнд хөрөнгө мөнгө, цаг заваа зарцуулж байгаа хүмүүстээ ялангуяа хэлэхэд бид нар энэ ёс зүйгүй байгаа гэдэг зүйлээ энэ сошиалаа цэвэрлэхээс эхэлнэ шүү.

Тэгэхээр харин бид нар эргээд өнөөдөр ёс зүй яримаар байвал яаж хүний эрх, үг хэлэх эрх чөлөөг хамгаалахын тулд энэ сошиалаа үнэн, зөв байлгах вэ? Энэ Монгол Улсын жинхэнэ үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудал болсон шүү. Тэгэхээр өнөөдөр ямар албан тушаалаар би Бямбажаргал докторыг энд сууж байгааг мэдэхгүй байна. Та докторынхоо хувьд ч байна уу, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын хувьд ч байна уу энэ асуудал дээр харин анхаарлаа хандуулаасай гэж чин сэтгэлээсээ хүсье.

Ж.Батжаргал: Зулпхар гишүүн.

С.Зулпхар: Байнгын хорооны дарга, гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Парламентын засаглалын бас давуу тал нь аливаа асуудлыг хэлэлцэх. Бид энд Байнгын хороо бол Улсын Их Хурлын бүтэц учраас энд бид энэ асуудлыг нээлттэй хэлж байгаа нь өөрөө их давуу тал гэж би ойлгох ёстой. Олон ч гэсэн энийг бол бас тэгж харж байгаа. Олон талт байр суурь байх ёстой. Тэгж байж бид энэ бол ардчилсан засаглалыг бэхжүүлж байна, парламентын ардчиллыг бэхжүүлж байна гэж бас ярих ёстой. Энэ бол үндсэн шалгуур нь гэж байгаа юм. Өнөөдөр энэ хууль орж ирсэн. Хууль орж ирэхээс авхуулаад л олон нийтийн хэлэлцүүлэг, улс төрчдийн дунд хэлэлцүүлэг явлаа. Гол зүйл бол ёс зүйг хуульчлах юм уу гэдэг асуулт дээр суурилсан. Энэ ёс зүйг бол хуульчилж болно.

Гэхдээ бол бүрэн хуульчилж болохгүй гэдэг ийм л хариулттай. Энэ МЭӨ III зуунд аль хэзээний Аристотель өгчихсөн хариу. Дараа нь одоо ёс зүйн чиглэлээр хамгийн том философич Иммауил Кант бол угаасаа бас тэгчихсэн. Гэхдээ Кантын байр суурь бол их хатуу. Ёс зүй гэдэг бол зөв үү, буруу юу л гэдэг асуудал. Улсын Их Хурлын гишүүн Байнгын хороодынхоо хуралдаанд цагтаа ирж оролцох ёстой юу гэдэг бол ёс зүйн асуудал. Гэхдээ энэ асуудлыг бид бол бол одоо хуралдаа ирэхгүй байгаад байгаа улсуудын тухай л ярихаараа зэрэг энийг хуульчлахаас өөр аргагүй боллоо гэж байгаа бол хуульчилж бас болно оо л гэсэн үг.

Тэгэхлээр зэрэг энэ талаас нь бид асуудлыг бас харах ёстой байх. Би сайн санаж байна. Одоо бид энэ Ёс зүйн тухай хуулийг 2023 оны 5 сард баталж байсан. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль. Тэр үед ч гэсэн энэ хэлэлцүүлэг явж байсан.

Гэхдээ тэр үед энэ хэлэлцүүлэг явж байхад нэг чухал зүйл яригдсан юм байгаа юм. Бид яаж байна гэхээр зэрэг хэрэг “Алсын хараа-2050” гэдэг баримт бичгийг боловсруулахдаа бид Монгол Улсад төрийн одоо жишээ нь засаглалыг

боловсронгуй болгохдоо чадварлаг, ёс зүйтэй, мэргэшсэн төрийн албатай болно гэдэг ийм зорилт тавьсан. Энийг хэрэгжүүлэх хүрээнд энэ хуулийг оруулж ирлээ гэсэн ийм тайлбар тавигдаж байсан. Би сайн санаж байна. Энэ нь ч зөв.

Яагаад гэвэл бид тавьсан зорилготойгоо уялдсан байдлаар эрх зүйн орчин дутуу байна аа гэдгийг л ярьж байсан. Төрийн алба гэдэг бол төрийн улс төрийн алба, албан хаагчдаас бүрддэг, төрийн захиргааны албан хаагчдаас бүрддэг, төрийн тусгай албан хаагчдаас бүрддэг, төрийн үйлчилгээний албан хаагчдаас бүрддэг. Энэ хуулиар бол энийг их тухайлан зохицуулсан байгаа.

Гэхдээ төрийн улс төрийн албан хаагчтай холбоотой зүйлийг ёс зүйн дүрэмд найдаад үлдээчихсэн ийм зүйл байгаа учраас энийг боловсронгуй болгох чиглэлээр бид ярих нь ээ гэсэн ийм л бас хэлэлцүүлэг явж байна. Энэ талаас нь аваад үзэх юм бол бид ёс зүйг хуульчилж болно оо гэж байгаа юм. Гэхдээ энэ хууль дээр бас бодууштай зүйл байгаа.

Нэгдүгээр асуудал бол ер нь бол Улсын Их Хурлын өөрөө гишүүний өөрийнх нь абсолют эрх байдаг, абсолют халдашгүй байдал гэж. Улсын Их Хурлын гишүүн бол хуралдаанд оролцох явцдаа хэлсэн үгнийхээ төлөө тухайн үед бол болон дараа нь хариуцлага хүлээдэггүй. Энэ бол улс төрийнх нь одоо гол үндсэн хамгаалалт болдог. Тэгэхлээр энийг бид нар энэ хууль хангаж байна уу гэдэг талаас нь бас сайтар бас хэлэлцэж судлах ёстой. Энэ нэг зүйл.

Хоёрдугаар зүйл бол сая би бас зарим гишүүдийн ярьсантай бол бас санал нэгдэж байгаа юм. Энд Улсын Их Хурлын гишүүн гэдэг бол ижил статустай улс төрийн албан хаагч. Улс төрийн өндөр албан хаагч. Гэтэл энийг тойргоор сонгогдсон, тэрнээс гадна жагсаалтаас гарсан гэдэг байдлаар ялгаатай авч явж байгаа нь бас өөрөө бид эргэж харах ёстой зүйл байна аа л гэж байгаа юм.

Гэхдээ эндээс бид нэг зүйлийг бас ярих ёстой. Бид энэ хуулийг хэлэлцэх нь зүйтэй. Гэхдээ хэлэлцэхдээ бид энийг саяын хэлсэн тодорхой шалгууруудын, Улсын Их Хурлын гишүүдийн хэлсэн бас тодорхой шалгуурууд байгаад байна шүү дээ парламентын өөрийнх нь одоо жишээ нь дархлааг алдагдуулчих тийм нөхцөл байдал үүсэхгүй байх талаас, парламентын ардчиллын гол үндсэн шалгуур болсон 5 үндсэн шалгуур байгаа шүү дээ. Энэ 5 үндсэн шалгуурыг бас алдагдуулахгүй байх талаас нь бид хэлэлцэж мэргэшсэн түвшинд тал талаас нь ярьж байж энэ хуулийг бол бид батлах эсэх ийм шийдвэр гарах байх аа гэж бодож байна. Тийм учраас миний хувьд бол энэ хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг дэмжиж байгаагаа илэрхийлье. Баярлалаа.

Ж.Батжаргал: Баярлалаа. Лодойсамбуу гишүүн.

Ч.Лодойсамбуу: Би энэ МАН-ынхнаасаа бас одоо сүүлдээ гуйя даа. Хоорондоо маргалдаж болно оо, тэмцэлдэж болно оо, санал зөрж болно оо, нэг нэгнээсээ өш хонзон авч болно оо, хэн нэг нь ах нь хэн нэг дүүгээ ороолгож болно оо. Гэхдээ энэ Монголын төрийг битгий ашиглаад байгаач ээ. Энэ парламентын ардчилал гэдэг юмаа хайрлаач ээ. Ерөнхийлөгчийг бол ойлгож байгаа. Ёс зүй, сахилга хариуцлага өөрөө цэргийн хүн, байнга ярьдаг. Сахилга хариуцлагатай байя, ёс зүйтэй байя, ёс суртахуунтай байя гэдэг санаачилга гаргаж байгааг нь ойлгож байгаа.

Тэгээд энэ хууль санаачлагчид нь оруулж ирэхдээ ингээд завааруулаад байдаг юм уу, эс үгүй бол үнэхээр энэ Монголд энэ парламентын засаглалтай тохирохгүй гэж хэлээд байдаг юм уу? “Монголын за нь андгай буузаа” гэж парламентын танхимд орж ирээд би бол парламентын ардчиллынхаа төлөө байсаар байгаад явна аа гэж өөрөө хэлж байсан. Одоо энэ өргөн барьсан энэ залуучуудынх нь боловсруулсан хууль бол тэр гол бүүр яг авч явах гэж байгаа хадгалж авч үлдэх гээд байгаа тэр 2 заалт нь Монголд парламентыг байхгүй болгох гэж байгаа. Парламентын гишүүн гэдэг ойлголтыг байхгүй болгох гэж байгаа. Урдуур нь ёс зүй гэдэг ийм маск, баг л зөвлөж байгаа юм.

Тэгэхдээ Нарантуяа-Нара гишүүний үйлдлээр бамбай хийж байгаа юм. Нара Нарагаараа л байсан, Нарагаараа л байгаа, Нарагаараа л байна шүү дээ цаашид. Үгүй ээ тэгээд орж ирчхээд Нара нь Нара болоод байгаа юм уу? Энэ одоо тэгээд парламент бид нарын буруу болоод байгаа юм уу сонгогдоод ороод ирсэн хүн? Яг үнэндээ тэр намд саналаа өгсөн тэр 8 хувийн сонгогчдын санал яг тийм парламентад бас Наратай баймаар л байгаа шүү дээ. Тэгээд тэд нарын буруу юм уу, тэгээд ёс зүйгүй гэж хэлэх юм уу? Би бол ёс зүйгүй үйлдэл гэж хэлэхгүй. Энэ бол ёс суртахуунгүй үйлдэл. Ёс зүйгүй үйлдэл гэдэг бол хууль, дүрэмд л байхыг л хэлнэ. Ганц нэг ёс зүйгүй юм бас авир гаргаж байсан юм байна аа мартчихаж намайг гүтгээд. Хэн нэгнийг гүтгэсэн бол Монгол Улс хуультай. Шүүхэд өгөөд л бол оо.

Гэтэл одоо тэрүүгээр далимдуулаад л тэрийг баахан хөөсрүүлж байгаад л энэ гишүүд ер нь болохоо байлаа жоохон ташуурдъя аа. Тэгээд олон нийт нь алга ташаад олон нийт нь шаардаад байнгуут нөгөө сонгогчдоосоо айсандаа батлаад явна. Энэ их хөөрхөн ийм төлөвлөгөө гаргачихсан юм шиг байгаа юм. Энэ Монголын парламентад, энэ Их Хуралд бас энэ парламентын засаглалаа хайрладаг бас нэг өнөө маргаашаа боддог ийм гишүүд олон байгаа.

Бид нар өөрсдийнхөө тэр ёс зүйн асуудлыг, хариуцсан ажлаа хийх ёстой, ажилдаа ирэх ёстой, хуралдаа суух ёстой, саналаа ухамсартайгаар өгөх ёстой гэдэг асуудлуудаа Их Хурлын даргын дэргэдэх Зөвлөл дээрээ ярьж байгаад Их Хурлын гишүүд нь өөрсдөө өргөн барьчихъя. Наад парламентыг цоолж өшөө өш хонзонгоо авах гэж байгаа энэ санаархлуудыг зогсоох хэрэгтэй. Энийг татаж авах хэрэгтэй. Энийг бол надаар хэлүүлэлгүй энэ хуульчид сайн мэдэж байгаа. Сөрөг үр дагаврыг нь асуугаад хариулахгүй байна шүү дээ. Яагаад хариулахгүй байна гэхээр мэдээд байгаа байхгүй юу. Ард нь яг ийм асуудал үүснэ л дээ гэдгийг мэдээд байгаа байхгүй юу даа хэнээр ч хэлүүлэлгүй. Гэхдээ тэр нь хамаагүй гээд байгаа юм.

Тэгээд өнөөдөртөө бид нар энэ танхимд байгаа хэдэн хүнийг бүүр нэг байранд нь аваачиж тавья гэдэг зүгээр ийм өс хонзонгийн бүүр сэдэл явж байгаа байхгүй юу. Энэ үйлдэлд нь хохирч үлдэх Монголын төр, парламентын засаг л хайран байна.

Ж.Батжаргал: Оюун-Эрдэнэ гишүүн.

Л.Оюун-Эрдэнэ: Миний хувьд бас зарчмын, тогтолцооны л талаас нь ярьж байгаа шүү. Энийг бас та хэд маань зөвөөр ойлгоорой. 2027 оноос цааш би ямар ямар зүйл Ерөнхийлөгчийн өмнөх цаг хугацааны энэ сургамж дээр үндэслээд энэ 5 нам анхаарч Монгол Улсын парламент хийгээсэй гэж одоо бодож байна вэ гэдэг л зүйлээ ярья.

Нэгдүгээрт, Монгол Улсын Ерөнхийлөгч мөрийн хөтөлбөртэй байх ёсгүй ээ. Монгол Улсын Ерөнхийлөгч төмөр зам барьдаг хүн биш, хүнсний хувьсгал хийдэг хүн биш, тэрбум мод тарьдаг хүн биш ээ. Энэ бол гүйцэтгэх засаглалын ажил. Энэ зааг, ялгааг салгахгүй бол жоохон төсвөө аваачаад 2 гүйцэтгэх засаглал хуваагаад ингээд хэн нь хариуцлага хүлээх нь мэдэгдэхгүй ийм зүйл болж байгаа.

Тийм учраас 2027 оны Ерөнхийлөгч аж ахуйн ажлын мөрийн хөтөлбөрийг дэвшүүлэхгүй байх ёстой. Энэ дээр одоо хэдүүлээ мэтгэлцэж өмнөх сургамж дээрээ үндэслэх ёстой. Дээрээс нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөл аж ахуйн ажлыг хариуцаж авч татдаг институц биш ээ. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл гэдэг бол 3 институц хурал хийхийг зохион байгуулдаг институц болохоос биш хонгилын түлхүүр атгаад шүүгч нарыг тангараг өргөх, үгүйгээр барьцаалж хэрэг захиалдаг байгууллага биш ээ.

Тийм учраас цаашдаа Үндэсний аюулгүй байдлын зөвлөл гэдэг энэ бүтцийг нууц тендер зохион байгуулдаг газар биш. Үүнийг 3 институцийн эв нэгдлийн хурлыг зохион байгуулдаг институц болгож, томоохон хэмжээнд Улсын Их Хурлаас аудит гаргаж шалгаж, 27-ноос цааш цэгцлэх ёстой. Энэ алдаа цаашаа давтагдахгүй байх ёстой. Гэхдээ зөвхөн энэ удаа гэж байгаа юм биш шүү. Дандаа ийм байсан.

Дээрээс нь Ерөнхийлөгч парламентаас сонгогддог байх асуудлыг 27 оны мөрийн хөтөлбөрт улс төрийн намууд сонгодог парламентын засаглалтай байж гэвэл ярих ёстой. Парламент ард түмнээс сонгогддог цорын ганц субъект байж байж энэ асуудал хийгдэнэ ээ. Тэгэхгүй бол ингээд хагас парламент, хагас Ерөнхийлөгчийн засаглалаа бид нар үндсэндээ одоо ингээд дийлэхээ больж байна. Ерөнхийлөгч нам бус бол Ерөнхийлөгчийн Тамгын газрын бүх ажилтнууд нам бус байх ёстой. Энэ хуулийг яаралтай оруулах ёстой. Энэ ингээд цаашаагаа алдаа давтагдаж бас болохгүй ээ.

Цэц болон бусад байгууллагууд сая энэ олон асуудал дээр парламент руу халдсан. Тийм учраас энэ асуудлыг бас Монгол Улсын парламент авч үзэж дүгнэх хэрэгтэй. Хамтарсан Засгийн газрыг би дэмждэг ээ. Хамтарсан Засгийн газар зөвхөн сая миний үед явсан зүйл бас биш шүү. Цаашдаа олон удаа олон янзаар хамтрах байх аа.

Тийм учраас Ерөнхийлөгч гүйцэтгэх засаглалаа унагадаг энэ асуудал 2027 оноос цааш бид ийм гунигтай түүхийг давтаж болохгүй ээ. Ингэж байж Монгол Улсын гүйцэтгэх засаглал өөрөө тийм ээ хариуцлага хүлээдэг байна. Парламентаас байгуулагдсан Засгийн газар, Ерөнхий сайд адаглаад кабинетаа өөрөө бүрдүүлэх хэмжээний эрх мэдэлтэй байж байж Монгол Улсад үр дүн гарна.

Тийм учраас энэ ингээд 2027 оноос цааш томоохон хэмжээний мэтгэлцээн болж өрнөөсэй гэж бодож байна. 27 хүртэлх энэ асуудалд харамсалтай байна. Баярлалаа.

Ж.Батжаргал: Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Нэгдүгээрт, Байнгын хорооны гишүүддээ хандаж хэлэхэд нэгдүгээрт хуулийн агуулга руу орохоос өмнө энэ хуулийн төслийг өргөн барих,

хэлэлцэж байгаа процесс өөрөө Үндсэн хуулийн зөрчил үүсгэж байна уу үгүй юу гэдгийг олж хараасай гэж бодож байгаа юм.

Тийм учраас Ерөнхийлөгч өөрт нь хуулиар олгогдоогүй өөрт нь олгогдсон бүрэн эрхээсээ хальж гэж байгаа юм. Түрүүн хэдийгээр Үндсэн хуулиар заасан бүрэн эрхийнхээ хүрээнд ямар ч хуулийг санаачилж болно оо гэж тайлбарласан боловч онол ёсоороо ийм биш гэдгийг бүгдээрээ сайн мэдэж байгаа энд сууж байгаа судлаач нар. Дотроо бүгд ингээд өөр өөртэйгөө тэмцэлдээд сууж байгаа байх аа гэж найдаж байна.

Тэгэхээр энэ бүрэн эрхээсээ хальж, парламентын үйл ажиллагаа болон хуралдааны дэгийн асуудлаар хууль санаачилсан нь парламент ёсны суурь зарчим болох эрх мэдлийн хуваарилалт харилцан хяналт, тэнцлийн механизмыг институц институцийн хувьд бол алдагдуулахад хүргэлээ. Парламентын үйл ажиллагаа дахь Ерөнхийлөгчийн энэ оролцоо нь хууль тогтоох байгууллага дотоод зохион байгуулалтын асуудлаа гагцхүү өөрөө бие даасан байдлаар шийдвэрлэх энэ зарчмыг үндсэндээ бүрэн дүүрэн үгүй хийх гэж байна аа гэсэн үг.

Цаашид энэ мэт байдлаар Их Хурлын өөр бусад олон асуудал руу орж ирээд ингээд Их Хурал Их Хурал шиг биш Их Хурал үндсэндээ Ерөнхийлөгчийн институцээс хараат байдлаар ингэж үйл ажиллагаа явагдах нь ээ. Би түрүүн үгэндээ хэлсэн асуултдаа хэлсэн. Бусад улс төрийн намуудын гээд “жигжиг” гэдэг үгэн дээр маш их дөрөөлж тоглож байх шиг байна. Одоо бодвол сошиалаар энэ “жигжиг нам” гэж хэлснийг маань тастаад л явуулах байх.

Гэхдээ бүгдээрээ дөнгөж бойжиж байгаа бусад улс төрийн намуудаа бодох хэрэгтэй. МАН 105 жилийн түүхтэй. АН 35 жилийн түүхтэй гээд бусад улс төрийн намууд чинь хэдэн жилийн түүхтэй билээ, хэд нь парламентад дөнгөж орж ирээд хэчнээн суудалтай болж байгаа билээ бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ. Энэ парламентын ардчилал энэ бусад улс төрийн намуудыг ингэж бойжих энэ орон зайг бид нар энэ бид хуулиар үгүй хиймээргүй байна аа гэсэн үг. Тийм учраас би тэр үгийг хэлсэн юм. Хоёрдугаарт, тийм учраас Байнгын хорооны гишүүд анхаараасай гэж хүсэж байна.

Хоёрдугаарт, Лүндээжанцан, Энхбаатар нарын ном дээр одоо хичээл заалгасан учраас дахиад нэг ном дурдчихъя. Үндсэн хууль болон Ерөнхийлөгчийн тухай хуульд байгаа Улсын Их Хурлыг тараах тухай шийдвэр нь зөвхөн Ерөнхийлөгчийн засаглалтай, эсвэл хаант засаглалтай улсын Ерөнхийлөгчид олгодог эрх мэдэл юм. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Ерөнхийлөгчид хаант засаглалтай улс оронд олгодог эрх мэдэл байдаг гэдгийг бид нар ямагт санах хэрэгтэй. Энэ өөрөө болж байгаа юм уу? Түүнээс гадна Засгийн газрын сайд нарыг томилох, хуульд хориг тавих маш том бүрэн эрхийг эдэлдэг, шүүгч нарын томилгоо. Бид нар ийм том Ерөнхийлөгчтэй. Тэгэхдээ бид нар парламентын засаглалтай.

Тэгэхээр парламентын засаглал байнгын сорилтод нүүр тулах нь ойлгомжтой. Энэ бол энэ удаагийн сорилт бол ээлжит нэгэн сорилт гэж би хувьдаа харж байна. Энэ олон хууль тогтоомжууд, энэ асуудлуудыг шийдэхгүйгээр бид нар цаашид энэ байтугай сорилттой нүүр тулна. Тэгэхээр парламентын гишүүд минь энэ дээр бас бүгдээрээ дотроо бодолтой бас энэ шийдвэрээ гаргах байх аа гэж найдаж байна.

Хамгийн сүүлд Цэцийн 9 гишүүнийг ард түмнээс сонгодоггүй. Өнөөдөр Улсын Их Хурлын гишүүдийн ёс зүйн асуудлыг явсаар байгаад Цэцийн гишүүд шийдээд, Цэцийн гишүүний шийдвэрийг бид нар ерөөсөө хянахгүй юм байна, хэлэлцэхгүй гэж байна. Урьд нь хэлэлцдэг ч үгүй байсан гээд. Тэгээд ард түмнийг бүгдээрээ Цэцэд хандаач ээ л гэж уриалаад байх шиг байна. Тэгэхээр Цэцийн 9 гишүүний гарт өнөөдөр 126 гишүүн орох бүүр тийм дээрээ тулчихсан юм уу? Тийм болтлоо манай засаглал ингэж доройтчихсон юм уу? Бас арай ч тийм дүгнэлт хийж болохгүй байх аа гэж бодож байна. Баярлалаа.

Ж.Батжаргал: Баярлалаа. Золжаргал гишүүн.

Ж.Золжаргал: Монгол Улсын Үндсэн хуульд 2 тохиолдолд гишүүнийг эгүүлэн татахаар их тодорхой бичсэн байгаа.

Нэгдүгээрт нь Үндсэн хууль зөрчсөн бол.

Хоёрдугаарт нь шүүхээр гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон бол. Тэгээд үндэслэл байгаа эсэхийг нь Цэц дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд хэлэлцүүлж болно. Миний бодлоор бол энэ аягүй тодорхой зүйл. Энийг шүүхээр гэмт үйлдэл тогтоогдчихоод Үндсэн хуулийн цэц нь нөгөө тохиолдолд нь дүгнэлт гаргачхаад байхад Улсын Их Хурал нь хэлэлцэхгүй хойшлуулаад л ингээд л байгаад байвал яах вэ? Тэгэхээр процессыг тодорхой болгох ийм хэрэгцээ, шаардлага байгаа нь бол харагдаж байна. Энэ процесс тодорхой биш байх юм бол эцэс төгсгөлгүй ингээд л маргаан үргэлжилнэ. Тийм болохоор процессыг нь тодорхой болгох хэрэгтэй юм болов уу гэж.

Гэтэл энэ өргөн барьсан хууль дээр байгаа 2 том заалт энэ процесстой холбоогүй. Нэг нь бол жагсаалтын гишүүн ёс зүйгүй байх юм бол намаас нь санал гаргаад ингээд санал хураагаад Их Хурал дээр шийдчихнэ. Тэгэхээр ёс зүй гэдэг бурхны сургаалыг хэн тогтоох юм. Энэ дүрэм дээр бид нар хэдийгээр тодорхойлоод бичиж байх боловч явж явж энэ чинь нөгөө намын дарга нэг фракцын үзлээр ёс зүйн зөрчилд нь үндэслээд гишүүдийг эргүүлэн татуулдаг ийм зүйл нээгдэх эрсдэлтэй харагдаж байгаа юм. Энэ бол энэ парламентын засаглалд үнэхээр том эрсдэл.

Хоёр дахь нь иргэн гомдол гаргаад тэр гомдол дээр нь үндэслээд авч хэлэлцээд тэгээд ингээд процесс явж байгаад Их Хурал дээр санал хураагаад гишүүнээс нь эргүүлэн татах. Одоо бид нар энэ жагсаал, цуглаан юу болдог билээ мэддэг тийм ээ ямар хүмүүс захиалгаар хэн үг хэлдэг вэ, яадаг вэ гэх ямар ч тохиолдолд өө тэр нөхрийг ер нь байхгүй болгоё, наад нөхөр чинь ингээд олон юм цор цор гээд байдаг юм тийшээ өргөдөл биччих гээд ингээд олонхоороо төр барьж байгаад шийдээд татаад аваад явчих ийм эрсдэл байна. Энэ бол ингээд нэг удаагийн ганц нэг тохиолдол биш цаашдаа ер нь маш ноцтой үр дагаварт хүргэж болзошгүй харагдаад байгаа юм.

Тийм учраас хэрвээ энэ гишүүний ёс зүй юм уу тэр Үндсэн хуулийн асуудал, тэгээд шүүхийн тогтоогдсон гэмт хэрэг энэ тэр асуудал нь байгаа бол тэр процессыг л тодорхой болгох хэрэгтэй. Тэгэхээр би бол энэ хуулийн төслийг хэлэлцэх шаардлагагүй гэж үзэж байгаа. Процессын тодорхой болох агуулга нь шал өөр байгаа учраас яг энэ агуулгаар нь хэлэлцээд явцын дунд засна гэхээр углуурга нь өөр учраас ерөөсөө болохгүй байгаа.

Тэгэхээр энийг бол хэлэлцэх шаардлагагүй гэж үзэж байна. Процесс тодорхой болох асуудлыг бол тусад нь магадгүй дахиад авч хэлэлцэх ёстой болов уу гэж бодож байна. Мэтгэлцээний байдлыг харж байхад улс төр маш их үнэртэж байна. Энэ улс төрийн нэг ийм тэмцэл яваад байна. Тэр тэмцлээс болж парламентын энэ юун дээрээ Улсын Их Хурлын тухай хууль дээр ийм эмзэг өөрчлөлтийг хийх нь зохисгүй л гэж үзээд байгаа юм даа. Баярлалаа.

Ж.Батжаргал: Баярлалаа. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулж дэмжсэн, дэмжээгүй байр сууриа гишүүд илэрхийлж дууслаа.

Энэ хуулийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэхийг нь дэмжээд, ажлын хэсэг гаргаад, илүү боловсронгуй болгох талаас нь анхаарах ёстой юм болов уу гэж би бол байр сууриа их эрт илэрхийлсэн. Яагаад тэгж байна вэ гэхээр зэрэг нийгмийн хүсэмжлэл ч байгаа, гишүүд өөрсдөө энэ Их Хурлынхаа үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөөд энэ асуудал хуулийн төслөөр хөндөгдөж орж ирсэн асуудлууд дотор үнэхээрийн бас илүү боловсронгуй болгоод авчих ёстой асуудлууд байна. Арай хууль, эрх зүйнхээ хувьд боломгүй зүйл байна гээд ингээд асуудалдаа хандаж байгаа.

Тийм учраас би намуудынх нь төлөөллийг жигд оруулаад, ажлын хэсэг гаргаад үүнийгээ тал бүрээсээ авч үзээд илүү боловсронгуй болгох тал дээр нь анхаарах нь зөв байх аа гэсэн ийм байр суурьтай байгаа гэдгээ бол аль хэзээ илэрхийлсэн гэдгийг хэлмээр байна.

Ингээд гишүүд үг хэлж, санал хэлж дууслаа.

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалт явуулъя. Саналын томъёоллыг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Хуралдаанд оролцсон 14 гишүүн дэмжиж, 66.7 хувиар дэмжигдлээ.

Санал хураалт дуусаагүй байгаа шүү. Дагасан хуулиуд байгаа. Гишүүд ээ дагасан хуулиуд нь байгаа. Санал хураалтдаа оролцоорой. Дагасан хуулиуд байгаа. Нэгэнт хуулийг нь хэлэлцэх эсэхийг нь дэмжсэн бол дагасан хуулиудын асуудлыг авч үзэхгүй бол хууль хоорондын зөрчил үүснэ шүү.

Хамт өргөн мэдүүлсэн Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд нь дэмжих нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Гишүүдийн 66.7 хувиар дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Хуралдаанд оролцсон гишүүдийн 66.7 хувь нь дэмжлээ.

Хамт өргөн мэдүүлсэн “Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явууля. Санал хураалт.

Хуралдаанд оролцсон гишүүдийн 66.7 хувиар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа танилцуулна.

Байж байгаарай манайхан. Хурдан уншиж байна. Та сууж байна уу. Дараагийн асуудалдаа оръё.

18.01 цаг

Монгол Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нарын 8 гишүүн 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж эхлүүлье.

Хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүд байна уу?

Алга байна. 1 зарчмын зөрүүтэй санал Сандаг-Очир, Отгонбаяр хоёроос санал орж ирсэн байна.

“50” гэснийг, “50 хувь” гэснийг “30 хувь” гэж өөрчлөхөөр санал оруулж ирсэн байна. Зарчмын зөрүүтэй саяын саналын томьёоллоор санал хураалт хийнэ. Санал хураалтад бэлдэх үү? Санал хураалтад бэлдье.

“50 хувь” гэснийг “30 хувь” болгож өөрчлөх зарчмын зөрүүтэй санал гарсан. Энэ саналын томьёоллыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явууля.

Хуралдаанд оролцсон гишүүдийн 47.6 хувь нь дэмжиж, энэ санал уналаа.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүд байна уу?

Энд бэлтгэгдсэн санал байна.

Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Энэ хуулийг 2026 оны 5 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн ийм саналын томъёолол байна. Энэ саналын томъёоллоор санал хураалт явуулъя, дэмжье гэсэн гишүүд саналаа өгөөрэй. Санал хураалт.

Хуралдаанд оролцсон гишүүдийн 52.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар танилцуулна. Дараагийн асуудалдаа оръё.

18.04 цаг

Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийг, тайланг хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Б.Энхбаяр Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Ч.Бат-Эрдэнэ Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын дарга, И.Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Л.Мөнхтүвшин Гадаад харилцааны Төрийн нарийн бичгийн дарга, М.Баярмагнай Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч. Ажлын хэсэг орж ирэх ёстой гишүүдийг оруулж ирээрэй. Мягмар Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Б.Дашпүрэв Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Д.Ганхуяг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ш.Батбаяр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Х.Батжаргал Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Л.Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Б.Болор-Эрдэнэ Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Б.Бат-Эрдэнэ Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга, М.Баяраа Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Т.Жамбалцэрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Б.Мягмарнаран Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Б.Ерэн-Өлзий Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга, Д.Очирбат Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Энхманлай, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга, Ц.Баяр-Эрдэнэ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага зохицуулалтын хэлтсийн дарга, Т.Даваадалай Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан 1 дүгээр орлогч, Л.Наранчимэг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Эрсдэлийн удирдлагын газрын дарга, Эрдэнэбаяр Бүсчилсэн хөгжлийн хүрээлэнгийн гүйцэтгэх захирал гэсэн ийм ажлын хэсэг байна.

Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолын 2025 оны жилийн эцсийн биелэлтэд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайланг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр танилцуулна. Энхбаяр сайд хаа байгаа юм? Энхбаяр сайдын микрофоныг өгөөрэй.

Б.Энхбаяр: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Засгийн газрын 2025 оны 183 дугаар тогтоолоор баталсан хууль тогтоомж тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журмын 6-д заасны дагуу цахим системд хяналтад байгаа Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд хамаарах 32 шийдвэрийн 228 заалтын биелэлтэд 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнг танилцуулж байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн санд ирүүлсэн тайлан, мэдээллийн эх өгөгдлийн дата баазыг ашиглаж хийсэн бөгөөд анхан шатын нэгжээс шат дараалсан үнэлгээний тайлан нэгтгэсэн үнэлгээг хийж гүйцэтгэлээ.

Энэ үйл явцад яам, агентлаг, орон нутгийн төлөөллийг оролцуулснаас гадна Канадын “Мерит” төсөл, “UNICEF”, Удирдлагын академийн зөвлөхүүдийн арга зүйн дэмжлэг, зөвлөмж, саналыг тусган ажилласан нь анх удаа бүх шатын оролцоог хангасан арга хэмжээ боллоо.

Мөн ажлын бүтээмж, үр дүнг нэмэгдүүлэхэд технологийн дэвшлийг ашиглаж тус Байнгын хороонд хамаарах шийдвэрийн биелэлтэд хиймэл оюун ухааныг ашиглан дүн шинжилгээ хийж үзсэн болно.

2025 оны жилийн эцсийн байдлаар тус Байнгын хорооны 32 шийдвэрийн 228 заалтыг яам, агентлаг, нийслэл хэрэгжүүлж ажилласан бөгөөд биелэлтийн дундаж 79.5 хувьтай байна.

Нийт 124 заалт хэрэгжсэн, 40 заалт хэрэгжих шатад, 17 заалт хэрэгжээгүй, 19 заалт хугацаа болоогүй, 28 заалт хэрэгжих боломжгүй гэж үнэлэгдсэн байна.

2025 оны жилийн эцсийн Хяналт шинжилгээ, үнэлгээний дүнд үндэслэн бүрэн хэрэгжсэн бодит шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй болсон, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан, тухайн шийдвэр хүчингүй болсон зэрэг шалтгаанаар 124 заалтыг Засгийн газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн сангаас хяналтаас хасах үндэслэлтэй гэж үзэж Байнгын хорооны хуралдаанд танилцуулж байна.

Тайлант онд хэрэгжээгүй шийдвэрүүд нь төрийн байгууллагуудын удирдлага зохион байгуулалт хангалтгүйгээс шалтгаалсан гэж дүгнэгдэж байна. Тухайлбал, төрийн байгууллагуудын түвшинд хариуцлагын тогтолцоо хангалттай бүрдэж чадаагүй, салбар хоорондын ажлын уялдаа сул, олон удаагийн бүтцийн өөрчлөлт хийгддэг, төсөв, хөрөнгө оруулалтын эрэмбэ, дараалал хангалтгүй, бодлогын болон хүний нөөцийн тогтворгүй байдал зэрэг нь хууль тогтоомжийн биелэлтэд сөргөөр нөлөөлж байна.

Иймд Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтийг 2025 оны жилийн эцсийн тайланг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэнтэй холбоотойгоор Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт дараах арга хэмжээг авахыг даалгасан. Үүнд:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг эрчимжүүлж, салбар хоорондын уялдааг ханган бодитой үр дүнтэй хэрэгжүүлэх;

Салбарын хэмжээнд хэрэгжүүлж байгаа хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгч, иргэдийн ахуй амьдрал болон салбарын хөгжлийн үзүүлэлтэд хэрхэн нөлөөлж буйг үнэлж тооцож ажиллах;

Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн төслийг боловсруулахдаа зохицуулалт, утга, агуулгын хувьд давхардал, хийдэл, зөрчилтэй шийдвэр гаргахгүй байх;

Санхүүгийн эх үүсвэрийг тусгах, хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт хэрэгжихүйц байхад анхаарах;

Дижитал хяналт, их өгөгдөлд суурилсан үнэлгээ хийх, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг бодит цагт хянах, ил тод болгох чиглэлээр цахим шинэчлэл хийх санал боловсруулж танилцуулах.;

Мөн хууль тогтоомжийг хангалтгүй биелүүлсэн албан тушаалтнуудад зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад даалгасан.

Цаашид Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлтийн талаар баримт, бодлогыг эргэн харж, шинэчлэх, сайжруулах үндэслэл бий болсныг харуулж байгааг дурдах нь зүйтэй.

Хууль тогтоомжийн биелэлттэй холбоотойгоор Улсын Их Хурлын түвшинд анхаарах асуудлууд бас байна аа.

Улсын Их Хурлын удирдлага нь томилогддог, сонгогддог байгууллагуудад үүрэг даалгавар болгосон шийдвэрийн хэрэгжилтийг хангах, биелэлтийг тайлагнах үйл ажиллагааг гүйцэтгэлийн байгууллагуудын түвшинд уялдуулах, нэгдсэн байдлаар тайлагнах боломжийг бүрдүүлэх;

Улсын Их Хурлаас гарч байгаа шийдвэрийн талаар нэгдсэн бүртгэлийн систем үүсгэж, Засгийн газрын хяналт, шинжилгээ, үнэлгээний мэдээллийн сантай уялдуулах. Гарч байгаа шийдвэрийг шуурхай дамжуулах, хяналтад авах.;

Улсын Их Хурлын Байнгын хороо, Улсын Их Хурлын гишүүдийн түвшинд шийдвэрийн хэрэгжилтийн явцыг цахим систем ашиглан улирал тутам танилцах боломжоор хангах;

Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчил болон тухайн жилдээ бүрэн хэрэгжсэн болон бусад шалтгаанаар хяналтаас хасуулах шийдвэр, заалтын талаар Засгийн газартай тогтмол хамтарч ажиллах;

Хууль тогтоомж Улсын Их Хурлын тогтоол, Байнгын хороодын шийдвэр, Засгийн газрын бодлогын баримт бичигт заасан зарим заалт агуулгын хувьд давхцах, хуулиар ноогдуулсан чиг үүргийг дахин тогтоол хэлбэрээр албажуулах зэрэг зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх зэрэг болно.

Тус Байнгын хороонд хамаарах шийдвэрүүдийн биелэлтэд анх удаа хиймэл оюун ухааныг ашиглан дүн шинжилгээ хийсэн бөгөөд нийт 228 заалтын 27 хувь нь хуулиар ноогдуулсан чиг үүргийг дахин үүрэгжүүлсэн заалт байна. 18 хувь нь

тогтоолын хэрэгжилтийг давтан баталгаажуулсан заалт байна. 23 хувь нь бодлогын баримт бичигтэй агуулгын огтлолцолтой заалт эзэлж байна.

Цаашид Улсын Их Хурлын холбогдох бүтцийн нэгжтэй хамтран хиймэл оюун ухааныг ашиглан дүн шинжилгээ хийх ажлыг улам боловсронгуй болгох, Улсын Их Хурлаас гарч байгаа шийдвэрийн биелэлт, үр нөлөө, хяналтыг сайжруулахаар хичээж ажиллана аа.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд хамаарах хууль, тогтоолын биелэлтийн 2025 оны жилийн эцсийн хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийг хавсаргасан болно.

Баярлалаа.

Ж.Батжаргал: Энхбаяр сайдад баярлалаа. Танилцуулгатай холбогдуулан асуулт асуух, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Цуг. Асуулт, саналтай гишүүд нэрсээ өгөөрэй.

Зулпхар гишүүнээр тасаллаа. Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Надад Энхбаяр сайдаас асуулт байхгүй. Би Байнгын хороондоо нэг зарчмын ажил хэрэгч санал гаргамаар байна. Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Улсын Их Хурлаас өгөх Улсын Их Хурлын шийдвэр, өгөгдсөн чиглэлийн үүрэг даалгаврын биелэлт нь харьцангуй сайн байгаа. 25 оны эхний хагас жилдээ дүгнэхэд бараг 50 хувийн 50 нэгжээр сайн, жилийн дундаж биелэлт бол 75.5 хувь байгаа нь бол бусад Байнгын хороотой харьцуулахад бол маш сайн. Яагаад гэвэл Төрийн байгуулалтын байнгын хороо нь бас харьцангуй сайн хууль тогтоомжуудаа хараад үүрэг, даалгавраа өгөхдөө бас нэг тийм учиртайхан шиг өгч байгаа.

Бусад Байнгын хороод бол 50 хувиас дээш ер нь бол гардаггүй. Тэгээд ухаад судлаад үзэхлээр ер нь үүрэг даалгаврууд маань өөрөө нэгдүгээрт бас их тодорхойгүй өгөгддөг юм байна. Давхарддаг юм байна. Мөн түүнчлэн өгөгдсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хангагдчихсан байг аа биелэлтүүдээ зогсоодоггүй гэдэг юм уу, хяналтаас гаргадаггүй угаасаа одоо цаг хугацааны хувьд угаасаа биелэх боломжгүй энэ үүрэг, даалгавруудыг ч гэсэн хяналтдаа хэвээрээ байлгаад байдаг нь эргээд нөгөө биелэлтийн хувь, хэмжээг доош нь татаад байдаг юм байна аа.

Тэгэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороон дээрээ би өнгөрсөн жил бас санал гаргаад бид манай Байнгын хорооны, тэр Байнгын хорооны хувьд одоо энэ бүүр хаа байсан 2016, 2017 онд өгөгдсөн үүрэг, даалгавруудыг хүчингүй болгох ийм шийдвэрээ бол гаргачихсан.

Тэгэхээр яг энэ агуулгаараа Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах энэ зүйл, заалтуудыг бас бүртгэлээс хасах асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй юм байна. Тэгэхээр магадгүй болохгүй бол надаа үүрэг даалгавар өгөөд бид дараагийн Байнгын хорооны хуралдаандаа яг энэ хүчингүй болгох тогтоолыг бас оруулж Байнгын хороогоор хэлэлцүүлэе гэсэн ийм ажил хэрэгч санал байна.

Ж.Батжаргал: Баярлалаа. Баярбаатар гишүүн.

Б.Баярбаатар: Оройн мэнд ээ. Өглөө Хууль зүйн байнгын хороон дээр бас нэлээн олуулаа 50 хүн орж ирээд тэгээд би жоохон шүүмжлэлтэй хандсан. Одоо ашгүй жоохон цөөрөөд ирсэн байна. Тэгэхдээ ер нь бол энэ цаашдаа бол энэ Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, тэгээд энэ парламентын хяналт Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх агентлаг 3 л орж ирж байгаарай. Бусад хүмүүсийн төрийн албан хаагчдын ажлыг нь хийлгэж байх ёстой шүү гэдгийг бас дахиад хэлье.

Өнгөрсөн жилийн өдийд би бас яг л хэлж байсан юм энэ үнэлэх аргачлалаа өөрчилье гээд. Тэгээд тэр үед за зуу гээд л явсан юм. Тэгээд өнөөдөр ч өдөр бас өглөө байсан энэ өмнө нь ингээд гишүүд ийм ийм саналууд гаргаж байсан юм аа. Тэгээд энэ дагуу одоо ийм ийм арга хэмжээг авч хэрэгжүүлсэн гэдэг ийм тайлан ерөөсөө орж ирэхгүй байгаа юм. Бид нар нэг үг хэлэхээр нэг ийм элсэнд тос асгаж байгаа юм шиг байдлаар ингээд алга болчихдог. Тэгээд энэ жил дахиад л бахь байдгаараа нөгөө л хэд зүгээр энэ. Одоо энэ үнэлсэн байгаа аргачлалыг харах юм бол өнгөрсөн жилийнхээс бол илүү сайжирсан байгаа юм. Хэрэгжилт илүү сайжраад явчихсан.

Одоо ингээд ямар аргачлал, жишээлбэл одоо бид нар тоо л яриад байгаа шүү дээ. Тэдэн заалт хэрэгжээгүй, давхацсан, хэрэгжих боломжгүй. Яагаад хэрэгжээгүй юм? Ямар хуулийн ямар заалт, ямар Байнгын хорооны тогтоолын ийм ийм агуулгатай заалтууд ингэж ингэж хэрэгжээгүй гэдэг агуулга дээрээ илүү уул нь энэ хуралдаанд.

Яагаад гэвэл энэ хуралдаан чинь нээлттэй явж байгаа байхгүй юу. Иргэдэд бид нар мэдээлэл өгөх үүрэгтэй. Иргэдийг мэдэх эрхээр хангах үүрэгтэй. Зүгээр нэг тоо яриад өнгөрчихөөр тэгээд тэдэн тогтоол батлаад тэд нь хэрэгжсэн юм байна л гэдэг энэ ийм ерөнхий зүйлтэй байгаа юм. Тэгэхээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар одоо энэ дээрээ дараа дараадаа илүү сайн анхаараад яам, агентлагуудаасаа авч байгаа, нэгтгэж байгаа мэдээ, мэдээллүүдээ илүү боловсронгуй болгоод.

Тэгээд бид өнөөдөр эндээ яах вэ энэ Байнгын хороогоор хэлэлцүүлсэн болоод ингээд гараад явах нэг хэрэг байх. Энэ төрийн үйл ажиллагаа ер нь яг ямар зарчимтай, яаж явагддаг юм бэ гэдгийг иргэдэд энэ ойлгуулах асуудал нь өөрөө их чухал байгаа шүү гэдгийг хэлье. Жилээс жилд ингээд ахиж байгаад нь бол их сайхан талархалтай байна аа л гэдгээ л хэлье. Баярлалаа.

Б.Энхбаяр: Баярлалаа Зулпхар гишүүн.

С.Зулпхар: Та бүхний өдрийн амгаланг айлтгая. 2 асуулт байна Энхбаяр сайдаас. Сая таны бидэнд өгсөн мэдээлэл дээр энэ төрийн байгууллагуудын үйл ажиллагааг үнэлэхтэй холбоотой арга зүйг бид Удирдлагын академийн зөвлөсний дагуу эцэслээд ингээд үнэллээ бас зохих үр дүн гарлаа гэж байна. Энийг сайн байна гэж би бодож байна. Яагаад гэвэл байсхийгээд л бид нэг үнэлгээнийхээ арга зүйгээ өөрчлөөд байдаг юм, аргачлалаа өөрчлөөд байдаг юм. Тэгээд л тэрэнд нь төрийн албан хаагчид будилдаг. Тэгээд явсаар байгаад тайлан нь өөрөө будилаад байдаг. Тэгэхлээр одоо энэ бол ямар нэгэн байдлаар туршигдаад цаашдаа бол энэ тогтвортой явах аргачлал болж байна уу гэсэн нэг ийм асуулт байгаа юм. Эхний асуулт.

Хоёр дахь зүйл, та өчигдөр бас одоо мэдээлэл өгсөн байна лээ. Би тэрийг бол мэдээллийг сонсоод бол бас сайшаалтай, талархалтай хандаж л байна. Тэнд төрийн албан хаагчид баахан тайлан гаргасаар байгаад л ерөөсөө өдрийг бардаг, эсвэл ажлынхаа ихэнх цагийг одоо тэр тайланд зарцуулдаг зарцуулдаг болчихлоо гээд. Энийг уг нь бид багасгая гээд зорилт тавьсаар байтал сүүлдээ бүүр хууль батлах болгондоо янз янзын үүрэг өгсөөр байгаад ерөөсөө ийм тайлантай болгочихсон юм.

Тухайлбал, тодорхой байгууллагын дарга нь яадаг гэхлээр зэрэг авлигатай тэмцэх хөтөлбөртэй холбоотой хэрэгжүүлсэн арга хэмжээгээ тайлагнадаг, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой төлөвлөгөө гаргаад тэрийгээ тайлагнадаг гээд ингээд ийм бид хуулиар баахан юм нэмчихсэн юм. Тэгэхлээр одоо ингээд та хэлсэн зүйлийнхээ дагуу энэ зарим зүйлийг цэгцлэх үү? Хэчнээн ийм тайлангуудыг ер нь нэг бол одоо багасгах юм, эс үгүй бол хялбаршуулах юм, эс үгүй бол одоо цахим болгох юм гэдэг ийм чиглэлээр та бүхэн маань ажиллаж байна уу гэсэн ийм асуулт байна. Баярлалаа.

Ж.Батжаргал: Энхбаяр сайд хариулъя.

Б.Энхбаяр: Зулпхар гишүүний асуусан эхний 2 асуултад манай ажлын хэсгээс ярилцаж байгаад хэн нь хариулах вэ?

Гурав дахь асуудлын тухайд Монгол Улсын Ерөнхий сайд ч гэсэн хэлсэн. Ер нь төрийн албаны ачаалал энэ албан хаагчдын ажлын байрны зураглал гэдэг юманд бол бас сүүлийн хэдэн жил бас үнэлгээ мониторинг хийж үзсэн юм байна. Сүүлийн ялангуяа 2000-2005 он гэхэд бараг Засгийн газрын, зөвхөн Засгийн газрын түвшинд гэхэд 700 журам гаргасан байна. Сүүлийн 10 жилийн байдлаар авч үзэхэд манай улс дахь энэ журмын тоо бол 5 дахин нэмэгдсэн юм байна. 5 дахин.

Тэгэхээр одоо хуулиасаа хуулиасаа энэ чинь бараг хэд дахин давчхаад байна журам. 5 дахин их журамтай болчихсон юм байна. Тэгээд энэ ерөөсөө энэ яам, агентлаг, ялангуяа энэ төрийн захиргааны төв байгууллагуудын түвшинд маш их журам боловсруулдаг, үүнийхээ одоо хэрэгжилт, тайлан гэдэг юмнуудыг гаргадаг ийм байдалд орчихсон. Ерөөсөө энэ нь өөрөө нөгөө тийм хэтийдсэн ийм ачаалалтай. Тэгээд яг журмуудыг нь аваад үзэхээр та бүхэнд сая танилцуулж байгаа. Хуулиудыг аягүй их “сору” хийгээд ийм ийм зохиомол ийм юм үүсчихсэн.

Тэгээд тайлагнал гэдэг юм хийчихсэн. Яг энэ асуудлыг маргаашийн Засгийн газрын хуралдаанаар миний бие оруулах гэж байгаа. Би нөгөө кабинетын зарчим баримтлах ёстой учраас Засгийн газраар урьдчилж шийдвэрлэгдээгүй асуудлыг бас ингэх гэж байна, тэгэх гэж байна гэж ярих нь өөрөө бас зохимжгүй байгаад байгаа юм. Яг энэ асуудлыг бас оруулаад ялангуяа энэ төрийн албан хаагчдын энэ ачаалалтай холбоотой, үнэлгээтэй холбоотой, тайлагналтай холбоотой ажлын цагтай холбоотой бас энэ асуудлыг нэгдсэн журмаар оруулах гэж байгаа. Ямар ч байсан Ерөнхий сайд бол бодлогоо өчигдрийн Засгийн газрын хуралдаан дээр бол зарлачихсан. Засгийн газар бол дотооддоо Хэрэглэх газар, яам, агентлагуудынхаа түвшинд бол ийм цаасан санал авдаг энд юу зүйлүүдийг бүгдийг нь цахимжуулах ийм шийдвэр ямар ч байсан гаргах гэж байгаа гэдгийг бол хэлье.

Тэгээд Улсын Их Хуралтайгаа хамтарч бас нэг шийдэх асуудлууд байгаа. Улсын Их Хурлын тогтоолоор Улсын Их Хурлын бас бүтцийн байгууллагуудын

түвшинд бас бас их тийм яг энэ адилхан байгаа юм байна. Журамлалт яг адилхан. Засгийн газар бол нөгөө гүйцэтгэх эрх мэдлийнхээ хүрээнд их асуудлаа хариуцаад зохион байгуулна.

Улсын Их Хурлын бүтцийн байгууллагуудын түвшинд Улсын Их Хуралтайгаа хамт бас нэг бодлогоор энийг зохион байгуулбал бас энэ хамтын үр дүнд хүрэх юм байна аа гэсэн ийм бодлого чиглэлтэй байгаа. Тэгээд Их Хурлын гишүүд маань бас би нөгөө урьдчилж шийдэх гэж байгаа асуудлын талаар бас байр суурь илэрхийлж болохгүй байгаад байна.

Ж.Батжаргал: Ажлын хэсгийн 5 номер гүйцээж хариулъя.

Ч.Бат-Эрдэнэ: Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын дарга Бат-Эрдэнэ байна. Зулпхар гишүүний асуултад хариулъя. Гишүүний саяын асуусан асуулттай холбоотойгоор энэ хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтийг үнэлэх энэ арга аргачлалууд бол ойр ойрхон хугацаанд бас өөрчлөгдөөд байг аа ийм зүйл ажиглагдаж байгаа. Жишээлэхэд 2025 онд 2 удаа өөрчлөгдсөн байж байгаа. Тэгээд бид бүхэн бол сая 2025 оны 183 дугаар тогтоолоор өнөөдрийн энэ тайлангийн хэрэгжилтийн үнэлгээг хийж орж ирсэн. Бид бүхэн энэ тайлангаа гаргахдаа олон улсын байгууллагууд энэ тайлангуудаа яаж үнэлдэг юм бэ, гарсан шийдвэрүүдийнхээ хэрэгжилтийг яаж хангадаг юм бэ гэдэг дээр бас арга зүйн болон тухайн байгууллага дээр очиж бас туршлага судалж судалж ингэж үзэж байсан. Энэ дээр бол харахад бол жишээлэхэд.../минут дуусав./

Ж.Батжаргал: Гүйцээгээд хариулчихъя. Ажлын хэсгийн 5 номер.

Ч.Бат-Эрдэнэ: “UNICEF” бол үйл ажиллагаа тайлагнахаасаа илүү үр дүн ямар индикаторуудаар хэмжиж, үр дүнгээ хэмждэг болох юм бэ гэдэг энэ асуудлуудаар бол маш тодорхой зөвлөмжүүдийг өгсөн. Тийм учраас яг энэ чиглэл дээр бид нар ажлын хэсэг байгуулахаар энэ саяын одоо Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр үүрэг өгчихсөн байж байгаа.

Дараагийн асуудал нь энэ хиймэл оюун ухааны асуудал. Их өгөгдлийг ашиглаж энэ тогтоол, шийдвэрийн биелэлтийг бодит цагт хянах боломж, бололцооны талаар бас үүрэг өгчихсөн байг. Энэ дээр бол бас тодорхой хэмжээний ажлууд ингээд хийгд явж байгаа.

Тухайлах юм бол Улсын Их Хурлын гишүүд дээр, холбогдох Байнгын хороод дээр бол тухайн зүйл, заалтын хэрэгжилт улирал бүр бас цахимаар ороод хэрэгжилтийг бас харж байх ийм боломж, бололцоог бүрдүүлэх ийм чиглэлүүд өгсөн. Энэ дээр бол бас ажлын хэсэг байгуулагдахаар болоод ингээд ажиллаж байгаа.

Ж.Батжаргал: Баярлалаа. Танилцуулгатай холбогдуулж гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Тайлан оруулж ирж хэлэлцүүлсэн Засгийн газрын гишүүн ч тэр, манай Байнгын хорооны гишүүн, Ариунзаяа гишүүн ч тэр хэрэгжилт нь одоо хангагдчихсан, бүртгэл хяналтаас хасах ёстой шийдвэрүүдийн талаар тодорхой санал гаргалаа гэж би ойлгосон. Үүнийг ажлын хэсэг гаргаж дараагийн Байнгын хорооны хуралдаан дээрээс ажлын хэсэг гаргаж нягталж үзээд бүртгэлээс хасах

ажлыг нь хийж өгөх ёстой. Энэ тэгж байж бид энэ тайлагналын гэдэг юм уу, ачааллын дарамтаас салах бололцоо, боломж бүрдэж байгаа юм аа.

Ер нь бол энэ шийдвэрүүдийн биелэлт хангах, хэрэгжилтийг зохион байгуулах энэ ажлууд дээр уг шийдвэрийн өөрийнх нь төлөвлөлтийн асуудал байгаад байгаа юм. Үүнийгээ их зөв харж хийх тухай асуудал. Тэгээд гүйцэтгэл, үр дүнгийн тухай асуудал, тэрийгээ одоо сүүлийн үед хиймэл оюун ухаан дээр тулгуурлаад давхар контролд нь хяначихдаг болчихсон гээд Байнгын тайлагналдаад байг.

Тийм учраас энэ мэдээлэл, технологийн давуу талуудыг ашиглах, түүн дээрээ тулгуурлаж их бодитой үнэлэх явцын байдалд нь тодорхой үнэлгээ бодитой гарч, хэрэгжилтийн ахицыг бий болгох асуудал ерөөсөө хамгийн гол зүйл л дээ. Тэрнээс үр дүн ийм гарлаа гэж эцсийн тайлагналаар явдаг ч зүйл биш. Бид нарын гол явж байгаа зорилго бол энэ явцын үр дүн дээр нь бодитой үнэлгээ хийж, тэгээд дутуу дулимаг байгаа юмнуудаа хэрэгжилтийг нь ахиулах тухай л асуудал байгаа гэдгийг зориуд хэлмээр байна. Энэ рүүгээ манай Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, холбогдох салбарын яамнууд онцгойлон анхаарч ажиллаарай.

Ингээд тайланг сонсож дууслаа.

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

Өнөөдрийн хуралдаанд идэвхтэй оролцсон Байнгын хорооныхоо гишүүдэд, ажлын хэсгийнхэндээ бүгдэд нь баярлалаа.

18.28 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР